

“Бурханаас агуу зүйлийг хүсэн хүлээ. Бурханы төлөө
агуу зүйлс хийхийг хичээ”

Виллиам Кари

ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН

Арихам

Ариун Сүнсээр гучурах нь

ХЭЛМУТ ХАУБЭЙЛ

Хэвлэл:

Эх хувилбар: “Schritte zur persönlichen Erweckung”

TOP Life Wegweiser-Verlag GmbH, Wien

Austrian Publishing House Verlagsarchivnummer: 040 415

ISBN: 978-3-903002-14-2

Англи хэл дээрх хэвлэлүүд – Хэвлэгдсэн улс

2015 он 3 сарын 1 – Герман

2016 он 4 сарын 2 – Өмнөд Солонгос

2015 он 4 сарын 3 – АНУ

2015 он 4 сарын 4 – Герман

2017 он 2 сарын 5 – Өмнөд Солонгос

2017 он 4 сарын 6 – Филиппин

2017 он 4 сарын 7 – АНУ

2017 он 4 сарын 8 – Замбиа

2017 он 5 сарын 9 – Герман

2017 он 11 сарын 10 – Самбиа

2017 он 12 сарын 11 – Авсрали

2017 он 12 сарын 12 – АНУ

2017 он 1 сарын 13 – АНУ

Зохиолч: Симон Эйтэнбергер, www.desim.de

Найруулагч: Конрад Принт & Медиан, www.konrad-medien.de

Төслийн Менежер: Христиан Строик

Зураглаач: Хенри Стобер

Зургаа дахь Герман хэвлэлээс орчуулсан: Холли Тарита

Орчуулгыг захиалах, холбоо барих:

© Helmut Haubeil, Rosenheimer Str. 49

D-83043 Bad Aibling / Oberbayern – Germany

Имэйл: helmut@haubeil.net or if returned

helmut.haubeil@gmail.com

Утас: +49 (0)8061 4900 712

Монгол хэлнээ:

Орчуулсан: Б. Ууганцэцэг

Хянасан: М. Энхбаяр

Хянаж, эх бэлтгэсэн: Ж. Пүрэвдулам

Библийн ишлэлүүдийг Библийн

Нийгэмлэгийн 2004 оны “Ариун Библи”-ээс авав.

Орчуулгууд:

Эх хувилбар нь Герман хэлээр бөгөөд *Этиоп-Арам, Индонез-Бахаса, Болгари, Крошиа, Чех, Дани, Англи, Филиппин-Тагало, Франц, Энэтхэг-Хинди, Унгар, Руванда-Киньяраванда, Бурунди-Кирунди, Энэтхэг-Мизо, Энэтхэг-Одья, Польш, Португаль, Романиа, Орос, Серб, Словян, Испани, Швед, Энэтхэг-Телугу, Пакистан-Урду, Вьетнам хэлээр орчуулагдсан. Мөн Араб, Бенгал-Бангла, Бурма, Хятад Мандарин, Дач, Итали, Лионе-Крио Сир, Латив, Малайз, Норвейг, Зүүн Африк—Шахили, Номхон Далай/Тонгагийн Арлууд-Тонга хэлээр орчуулсан.*

Вебсайтууд:

www.steps-to-personal-revival.info and www.schritte-zur-persönlichen-erweckung.info Энэхүү сайтуудад орчуулсан хувилбарууд тавигдах бөгөөд уншиж, хэвлэж мөн найз нөхөддөө илгээж болно. Сайтны цэсэнд: Удирдагч, хэрхэн сонирхлоо төрүүлэх вэ? Хуваалцах, сайжруулах гэрчлэлүүд (100-с илүү) мөн холбоо барих гэсэн хэсгүүд бий.

Мөн номын үргэлжлэл: Есүс дотор байх нь

Захиалгын мэдээлэл:

Илүү мэдээллийг 2-р хуудаснаас хараарай.

Бүх ишлэл болон санаануудыг Ариун Библийн NKJV, NIV хувилбаруудаас авсан болно.

Зохиогчийн эрх 1973, 1978 Олон улсын Библийн нийгэмлэг. Бүх эрх хуулиар

хамгаалагдсан. Олон улсын Библийн Нийгэмлэгийн зөвшөөрөлтэйгөөр ашигласан болно.

ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН АЛХАМ

“Жоли Пресс” Хэвлэлийн Газар
2018 он

ЗАХИАЛГЫН МЭДЭЭЛЭЛ

АНУ

Үлдсэн хэвлэлүүд
649 E. Chicago Rd
Coldwater MI, 49036
Утас: 800-423-1319 or 517-
279-13043 Захиалгын веб хаяг:
www.remnantpublications.com

Канад

Lucas Jurek 118 G First Avenue
North Williams Lake, BC V2G
1Y8
Имэйл: lucasjurek@gmail.com
Утас: 250 983 - 2650

Австрали

Colin Hone
Booklets in English colin.hone@
murrayhone.com.au

Филиппин

Allan D. Faina, Имэйл: allan@
lightingtheworld.org SDA church
Fidela Herrera Subd Bgy. Santol,
Tanza, Cavite-4108
Утас: (63) 926 054 1175

Орос

Source of Life Publishing House
Vostochanya St. 9 Zaoksky
301000 Tula Region,
Утас: +78 73 42 01 01

Европ болон Орос хэл

Christa Medien GmbH Pulverweg
6 D-21337
Luneburg (Germany)

Утас: +49 (0)4131 9835-580
www.christa-medien.eu und www.
christa-shop.eu
Имэйл: info@christa-medien.eu

Герман

Wertvoll leben Im Kiesel 3,
D-73635 Rudersberg www.
wertvollleben.com имэйл: info@
wertvollleben.com
Утас: +49 (0)7183 - 3071332
Утас: +49 (0)7183 - 3099847

Австри

TOP Life Wegweiser-Verlag
Prager Str.287, A-1210 Wien/
Vienna www.toplife-center.com
Имэйл: info@wegweiser-verlag.at
Утас: +43 (0)13199301-0

Австри болон Герман

Adventist Book Center Bogen-
hofen, A-4963 St.Peter/Hart
www.adventistbookcenter.at
Имэйл: info@adventistbookcenter.
at
Утас: +43 (0)2294000

Швейцар

Advent-Verlag Leissigenstr. 17,
CH-3704 Krattigen www.av-
buchshop.ch имэйл: info@advent-
verlag.ch
Утас +41 33 654 1065
Имэйл: www.lifesource.ru

ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН

Духам

Ариун Сүнсээр гүүрэх нь

ХЭЛМУТ ХАУБЭЙЛ

АГУУЛГА

7

Танилцуулга

ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН АЛХАМ

Ариун Сүнсээр дүүрэх нь

9

Удирдагч нарт зориулсан өмнөх үгс

ҮР ДҮНГЭЭ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

15

Бүлэг 1

ЕСҮСИЙН ХАМГИЙН НАНДИН БЭЛЭГ

Есүс Ариун Сүнсний талаар юу гэж сургадаг вэ?

Та Есүсийн хүчирхэг мэдээтэй танилцаж амжсан уу?

25

Бүлэг 2

БИДНИЙ АСУУДЛЫН ГОЛ ШАЛТГААН НЬ ЮУ ВЭ?

Бидний асуудалд сүнслэг шалтгаан бий юу?

Энэхүү шалтгаан нь Ариун Сүнс дутагдсанаас бий болдог уу?

49

Бүлэг 3

БИДНИЙ АСУУДЛЫГ ШИЙДЭЖ БОЛОХ УУ?

ХЭРХЭН ШИЙДЭХ ВЭ?

Бид хэрхэн аз жаргалтай, хүчирхэг Христэд итгэгчид байж чадах вэ?

Ариун Сүнс хэрхэн бидний амьдралыг дүүргэдэг вэ?

65

Бүлэг 4

БИД ЯМАР ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

*Ариун Сүнс дүүрэн амьдралаар амьдрах нь ямар давуу талтай вэ?
Хэрэв бид Ариун Сүнсийг хүсэн залбирахгүй бол юу алдах вэ?*

87

Бүлэг 5

БОДИТ ҮЛГЭР ДУУРАЙЛД ХҮРЭХ ТҮЛХҮҮР

*Бурханы надад зориулсан шийдлийг амьдралдаа хэрхэн мэдэрч
хэрэгжүүлэх вэ?
Ариун Сүнсээр дүүрэхийн тулд хэрхэн залбирах вэ?*

101

Бүлэг 6

БИДЭНД ЯМАР ГЭРЧЛЭЛҮҮД БАЙНА ВЭ?

Хувь хүн болон чуулган, сүмүүдийн гэрчлэл

111

Бүлэг 7

СОНИРХОЛ БА БУСАДТАЙ ХУВААЛЦАХ НЬ

*Бусдад өгсөн баяр хөөр нь бидэнд буцаж ирдэг. (Германы зүйр үгс)
“Бялхсан амьдралыг” мэдрүүлэхийн тулд бид тэдэнд хэрхэн туслах вэ?
(Иохан 10:10)*

120

Төгсгөлийн үгс

121

ХАВСРАЛТ

Цаашид суралцах зөвлөгөө

40 өдрийн зааврын гарын авлага

Ариун Сүнстэй амьдрах шинэ мэдрэмжүүд

Уг сэдвээр хэвлэгдсэн бусад ном

БИДНИЙ ЭЗЭН ӨӨРӨӨ
ТУШААСАН ЮМ¹

ҮРГЭЛЖ СҮНСЭЭР ДҮҮРЭН
БАЙГААРЫ!²

1. Элен Уайт Ерөөлийн уулан дээрх сургаал МВ 20.3 (egwwritings.org)

2. Жоханес Мареп, Auf den Spuren des Heiligen Geistes (Lüneburg, 1999), Seite 101

ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН АЛХАМ

Ариун Сүнсээр дүүрэх нь

*Би яагаад энэхүү
"Ариун Сүнсээр дүүрэн альдрал"
хэмээх сэдвийг эрчимтэйгээр шамдан судлах болов?*

Намайг 2011 оны 8 сарын 14-нд Швейцарын Бернес хэмээх уулархаг нутгийн цэцэрлэгт хүрээлэнд явж байтал нэгэн маш чухал зүйл оюун бодолд минь тодхон орж ирэв. Тэр мөчөөс би залуусын маань алддагддаг сүнслэг шалтгааныг ойлгож эхэлсэн юм. Тэр үед би үнэхээр гайхаж билээ. Тэгээд өөрийнхөө хүүхдүүд болон ач зээ нарынхаа тухай бодов. Түүнээс хойш би энэ сэдвийн талаар өдөр шөнөгүй бодож явна.

Маш олон асуудлын ард хувь хүн, орон нутгийн сүмүүд болон дэлхийн сүмүүдийн аль алиных нь асуудал Ариун Сүнсний хомсдол хэмээх яг л энэхүү шалтгаан байдаг гэдгийг мэдсэн.

Хэрэв шалтгаан нь энэ юм бол бид яаралтай шийдэх хэрэгтэй. Шалтгааныг нь багасгаж эсвэл арилгаж чадвал маш олон асуудал шийдэгдэж эсвэл үгүй болж болно.

Энэхүү дутагдлын талаар хүмүүс ямар байр суурьтай байна вэ?

- ▶ **Эмил Бруннер,** Ариун Сүнс бол “Үргэлж маш ихээр эсвэл тодорхой хэмжээгээр шашин судлалын зайлшгүй нэг хэсэг байсаар ирсэн”¹ гэж Евангелийн хөдөлгөөний шашин судлаач бичжээ.
- ▶ **Д. Мартин Ллойд-Жонс:** “Хэрэв би өөрийн бодлоо чинь үнэнээр нь хэлэх аваас Ариун Сүнсний талаарх өнгөрсөнд ч одоо ч орхигдсоор ирсэн сэдэв Библийн итгэл бишрэлд байхгүй. ... Энэ нь Евангел итгэл бишрэлийн сүл дорой байдлын шалтгаан гэдэгт би итгэлтэй байна.”²
- ▶ **Лирой Е. Фрүүм:** “Ариун Сүнсээр дутмаг байдал бол бидний хамгийн том асуудал гэж хэлмээр байна.”³
- ▶ **Двайт Нейлсон:** “Бидний сүм чуулган энэхүү сүльдсан хэсэгтээ сайжруулсан, сонирхолтой хэлбэрийн, төсөл төлөвлөгөөнүүд гарган анхаарах хэрэгтэй. Хэрэв бид олон ахлагч, удирдагчдаас авагдсан сүнслэг дампуурлаа хүлээн зөшөөрөхгүй байх аваас бид хэзээ ч зүй ёсны Христэд итгэгч болж чадахгүй.”⁴

Бид хамгийн эхлээд олон талын ач тустай Бурханы үгнээс урам зориг авах хэрэгтэй.

Дараа нь бидний Эзэн Есүс Христийн Ариун Сүнсний талаарх уриалгад анхаарал хандуулъя.

1 Johannes Mager, Auf den Spuren des Heiligen Geistes, (Luneburg, 1999), Cover

2 D. Martin Lloyd-Jones, Vollmacht, Telos-Taschenbuch Nr. 385, Marburg 1984, p. 72

3 E.G. White, The Coming of the Comforter (Hagerstown, 1949), p. 94

4 Editor Helmut Haubeil, Missionsbrief Nr. 34 (Bad Aibling, 2011), Seite 3

ҮР ДҮНГЭЭ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Эрхэм уншигчид даа,

Та сүнслэг байдлаараа хязгааргүй ихээр өсөхийг хүсч байна уу? Гэхдээ өнөөдөр энэ нь үнэхээр боломжтой юу? Тиймээ, энэ боломжтой. Гэвч яаж?

“Тэгээд тэр надад
“Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус,
харин Миний Сүнсээр!”
гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна.”
(Зехариа 4:6)

Үүнийг хэрхэн хийх вэ? Бүгдээрээ энэ номоос суралцсаар байх нь зөв гэж би бодож байна. Та бусдын туршлагаас суралцмаар байна уу? Эзэн бидэнд өөрийн Сүнсээрээ бүх арга замыг харуулах болтугай.

“Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” номын талаар бичсэн гэрчлэлүүд нь энэхүү ном үнэ цэнэтэй бөгөөд тусламж үзүүлж чадна гэдгийг нь харуулдаг. Гэхдээ сүнслэгээр өсөхийн тулд номыг ганц удаа унших эсвэл бусдад тараах нь хангалтгүй. Үүнд таны чинь сэтгэлийн чармайлт хэрэгтэй. Танд зүрхлэн хэлэхэд: Өсөлт хөгжил тань хүрч чадах хэмжээ хүртлээ өсөх болно. Энэхүү замаар явж байгаагүй хэн ч таныг чиглүүлж чадахгүй. Бидний амьдрал, бидний залбирал, бидний гэрчлэлүүд, бидний харилцаа, бидний нөлөөлөл болон номлол бүрийг Бурхан удирдах болно. Үнэндээ, олон дахин унших нь гол түлхүүр юм. Судалгаагаар амьдралд хэрэгтэй чухал сэдвийг бүрэн ойлготлоо тухайн зүйлийг зургаагаас арван удаа зайлшгүй унших хэрэгтэй гэж тогтоосон байна. Тэгвэл дор хаяж нэг удаа оролдоод үзээрэй. Үр дүн нь танд батлан харуулах болно.

Бүсийн хэлтсийн захирал, чөлөөндөө гарсан нэгэн Америк пасторын гэрчлэл:

1. Гэрчлэл – ... Би таны энэхүү “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” хэмээх номыг гурван удаа уншсаны дараа л залбирлын талаар шинэ ойлголт олж авна гэж хэзээ ч бодоогүй. Би Бурханы амлалт дээр суурилсан залбирлын талаар ойлгосон юм. Түүнээс хойш миний боломжтой гэж хэзээ ч бодож байгаагүй ялалтыг Бурхан миний амьдралд өгсөн. – Би нэг удаа кэмпийн цуглаанд номлохоор уригдахад таны ном надад сэдвийг нь өгсөн юм. 2017 оны 6 сарын 26 F.S.-товчлов.

2. Гэрчлэл – ... Энэхүү номноо зөвлөсний дагуу 6 удаа уншиж мөн амлалтуудыг барин залбирч сурснаар миний амьдрал өөрчлөгдсөн. ... Эзэн намайг кэмпийн цуглаанд бидний агуу хэрэгцээ болох Бурханы Сүнс бидэнд бууж ирэх талаар номлол бэлдэхэд чиглүүлсэн. Олон жилийн турш үйлчлэлд амьдралаа зориулж байхдаа би танхимд буй 3000 хүмүүсийн дунд нөлөөлөх тийм Ариун Сүнсний хүчийг хэзээ ч мэдэрч байгаагүй юм. – Эхнэр минь миний бүрэн өөрчлөлтийг анзаарсан байлаа. Би бүр өөрөө ч гайхаж байв. 2017 оны 6 сарын 25, F.S. товчлов.

40 – өдрийн ойлголт, 17-с 65 гишүүн

Германы Кологн-Калка дахь жижиг сүм нь Герман, Испани, Португаль хүмүүсээс бүрдсэн 17 гишүүнтэй. Пастор Ж. Лоце тэднийг 40 өдрийн хичээлд урьжээ. Тэд хоёр бүлэг болон 40 өдрийн номыг судалж, бүлэг бүр тус тусдаа 5 шинэ хүний төлөө залбирч, тэдэнтэй хувийн харилцаа тогтоожээ. 40 дэх өдөр нь шинэ хүмүүсийг цуглуулан Шаббат хийж, дараа нь 14 хоногийн баярт мэдээний үйл ажиллагаанд хамрагдуулаад богино хугацаанд 13 хүнийг усан баталгаанд оруулж чадсан байна. Тэд 40 өдрийн хичээлийг хэд хэдэн удаа давтан хийхдээ, 4 жилийн турш 65 гишүүнтэй болж чаджээ. (40 өдрийн ойлголтыг хэрэгжүүлж, амтыг нь мэдрээрэй. №19-с Кологнийн гэрчлэлийн талаар илүү ихийг уншаарай.)

Лугано буюу Швейцарын Италиар ярьдаг хэсэг газарт шашингүй үзэлтнүүд олон бий.

Пастор Матиас Мааг Өмнөд Африкт үйлчилж байхдаа, Деннис Смитийн бичсэн 40 өдрийн ойлголтын талаар туйлын их туршлага хуримтлуулсан нэгэн. Тэрээр Швейцарт буцаж ирээд, энэ ойлголтыг шууд хэрэгжүүлж эхэлсэн байна. Тэгээд эхний жилдээ 15 хүнийг усан баталгаанд оруулжээ (энэ нутгийнхны хувьд энэ нь гайхалтай үзэгдэл юм). Нэгэн эмэгтэй тэр сүмд 15 жилийн турш ирдэг байжээ. Тэгээд энэхүү 40 өдөрт усан баталгаанд орохоор шийдсэн байна.

Залуус – Миний нэрийг Алина Ван Ренсбург гэдэг бөгөөд би өмнөд Күинланд чуулганы залуу удирдагч [Австрали 12,200 гишүүнтэй] билээ. Энэ жил нэгэн залуу эмэгтэй надад “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” номын талаар хуваалцсан бөгөөд энэ нь намайг бүрэн өөрчилсөн юм.

Нөхөр бид хоёрын зүрх сэтгэлд Бурхан хэрэгтэй байсан тэрхүү сэдвийг маш тодорхой хэлсэн юм: Бид амьдралдаа Ариун Сүнсийг сэрээх хэрэгтэй байлаа!

Би танд маш олон түүх ярьж өгч чадна. Хамгийн гол нь бид энэ бяцхан номоор дамжуулан маш ихээр ивээгдсэн юм!

Грег Праттад [дагалдуулагч, сүнслэг төлөвшлийн удирдагч SQC] бусдад өгөхийг хүссэн илүү 300\$ байлаа. Би түүнийг нь жилийн эхний хагаст залуу удирдагчдын уулзалтанд тараан өгсөн бөгөөд үр дүн нь үнэхээр гайхалтай байсан юм. Тиймээс одоо надад байгаа 150\$-г жилдээ нэг удаа болдог том цугларалтын “Амьдралын бүлгийн” залууст өгөх хүсэлтэй байна.

366 Баптисм + 35 Баптисмийн анги

Бурундигийн бүсийн нарийн бичиг Паул Иракоз [130,000 гишүүнтэй, 100,000 ширхэг “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” товхимлыг Кирундид тараав], алдагдсан **320 гаруй гишүүд энэхүү товхимлын нөлөөгөөр эргэн ирж, 2017 онд шинээр усан баталгаанд орсон** гэж хэлсэн юм.

Сонсголын бэрхшээлтэй хүмүүс – энэ номыг 3 удаа уншиж, бусад сонсголын бэрхшээлтэй хүмүүст өөрсдийнхөө ойлгосон зүйлийг хуваалцсан байна. Үр дүнд нь: 2017 оны 3 сард бид 25 сонсголын бэрхшээлтэй хүнд усан баталгаа хийсэн байна.

Хоригдлууд – Бид Мпимба хорих газарт хүмүүждэг сүмийн гишүүддээ номоо тараасан юм. Тэд Ариун Сүнсээр хөтлөгдөн итгэлээ хуваалцаж эхэлсэн. Өнгөрсөн Шаббатаар 21 хоригдол усан баталгаа хүртэж, мөн дахин 35 хоригдол усан баталгаа хүртэхээр бэлтгэж байна. Энэ бол “Хувийн сэргэлт шинэчлэлийн алхмууд”-н үр жимс юм. Хураангуйлав.

Залбирлын долоо хоног/ Судлах хугацаа

Арван нэгдүгээр сард Бурундигийн бүсийн 130,000 гишүүн залбирлын долоо хоног хийжээ. 2017 онд дахин “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” номыг ашиглан залбирлын долоо хоног явуулж байна. Мөн нарийн бичгийн маань энэхүү сэдвээр бэлтгэсэн номлолууд орой бүр радиогоор цацагддаг байсан.

Оюутнууд – Андрус их сургуулийн ахлах пастор Двайт Нельсон энэ бяцхан ном “Намайг дотроос минь өөрчилж чадсан бөгөөд танд ч гэсэн адил нөлөөлөөсэй” гэж хэлсэн байна. 2017 оны 9 сарын 2-нд тэрээр “Хэрхэн Ариун Сүнсээр баптисм хүртэх вэ?” хэмээх цуврал номлолоо номлож эхэлсэн бөгөөд “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам”-н талаар дурдаж хүмүүст санал болгосон юм. Үүний улмаас 4000 гаруй хүн номыг интернетээс татаж 1000 гаруй хүн товхимол захиалсан байна. Номлолын линк болон түүний блогийг хавсаргалаа: [https:// www.pm-church.tv/sermons](https://www.pm-church.tv/sermons)

Шилдэг санаа – Америкаас – би өчигдөрхөн Двайт Нельсоны цуврал номлолыг сонслоо. Энэ Шаббатаар сүмийнхэндээ “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” хэмээх энэ номыг 5 минут танилцуулахад л номтой холбогдолтой гэрчлэл тэдний сонирхлыг төрүүлнэ. Тэгээд дараа нь пастораасаа зөвшөөрөл авч, сонирхсон хүмүүст нь номлолыг бүтнээр нь үзүүлэх болно! Д.В.

Баярт мэдээ – Двайт Нельсон 2017 оны 11 сарын 11-нд блогтоо (товчилж, зассан болно)

Ерэн-нэгэн “зочид” (тэднийг ингэж нэрлэдэг) шөнийн ерэн нэг программд Адвентист Загребчуудтай нэгдлээ хэмээн бичжээ. ... Комент болон талархал илэрхийлсэн хэсэгт нь **би энэ олон жил Загребт баярт мэдээнд оролцож байхдаа үүн шиг баярт мэдээний номлолыг сонсож байгаагүйгээ хэлэх хэрэгтэй байх.** Мөн сайн дурын пасторууд, өдөр шөнөгүй зуучлан залбирч буй нь энэ хотод Ариун Сүнсний үр жимсийг үзүүлж байгааг маш тодорхой харж байна гэж хэлсэн юм. Тэгээд бидний ихэнх нь 9 сард хийсэнтэй адил Ариун Сүнсний өдөр тутмын баптисм хүртэхээр Бурханыг эрэн хайж эхэлсэн. (Христ мөн биднийг Лук 11:13 дээрх залбирлыг хийхийг уриалсан). Учир нь би өөрөө үүнийг мэдэрч мөн Бурханы ажлыг Загребт гэрчлэн харсан учраас итгэлтэй байна. Энд миний тухай биш харин бүх зүйл Есүсийн амлалтын үнэн байдлын тухай юм. **“Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв.”** (Үйлс 1:8) Тэгэхээр бид юу ч хийсэн өглөө бүр Ариун Сүнсний баптисм хүртэж, өдөр бүр Бурханы шинэ Сүнсийг эрэлхийлсээр байа.

Эв нэгдэл: Гэр бүлүүд, хувь хүмүүсийн талаар маш олон сайхан гэрчлэл бий. (Гэрчлэлүүдийн дугаар 2/17; 3/31; 3/35; 3/40; 4/52; 4/56). Хүнд хэцүү асуудалтай сүмүүдийн тухай мөн хэрүүл маргаан, хуваагдал, зовлон шаналал, үл уучлал, сэтгэл зүйн тогтворгүй байдал мөн дарамт

зовлонгууд нь хайрласан, амар тайван, уучлан энэрсэн мөн эвлэрч нэгдсэн байдлаар солигдсон гэрчлэлүүд бий. (Гэрчлэлийн дугаарууд.1/10; 7/84)

Залуу ээж ба хүүхдүүд: Би гурван хүү өсгөх маш том үүрэг хариуцлагатай хүн. Ариун Сүнсийг л өдөр бүр надтай хамт байгааг хэмээн гуйх нь миний цорын ганц найдвар юм. Таны номыг уншсанаас хойш хөвгүүдийн минь зан чанарт илт өөрчлөлт гарч байгааг би анзаарсан. Би тэвчдэггүй зүйлдээ тэвчээр гаргаж мөн цөхөрч гомдох үедээ хайр энэрэл дүүрэн байж чаддаг болсон. Хөвгүүд минь ихэвчлэн тэрслүү хандлага гаргадаг ч бид хамтдаа өсөж хөгжсөөр байна. Миний дотор Есүс оршин байх талаар энгийн үнэнийг ойлгосондоо ямар их баяртай байгаа гээч! Д.В

Сонирхлоо хэрхэн өсгөх вэ? Үүнээс та маш үнэ цэнэтэй зүйлсийг олох болно. Эхлэхэд хялбар нэг зүйл бол “Зохион байгуулалттай унших” юм. Хамгийн хүчтэй түлхэц бол “Хичээлээсээ” зуурсаар байх явдал юм. Та үүнийг өөрөө хийх эсвэл хэн нэгэнд ярьж өгч болно (эсвэл видео үзэж болно. Гэхдээ бичлэг нь зөвхөн цөөн тодорхой хэлээр бий).

Миний хүсэлт: Ахмад хүний хувьд би танд ойр дотны хэн нэгэнтэйгээ хамт энэ номыг хэд хэдэн удаа уншиж мөн залбираарай гэж санал болгох байна. Энэ нь таны жижиг бүлэг, сүм мөн чуулганд мэдэгдэхүйц үр дүнгээ өгөх болно.

Дараагийн алхам нь та өөрийн ойлголт, мэдрэмжүүдээ пасторууд, ахмадууд болон бусад чухал гишүүдтэй хуваалцаж чадах уу? Тэдний зүрх сэтгэлд хүрэх нь хамгийн чухал нь юм шүү. Етиопт 2017 оны 7 сард Амхарикт сүнслэг сэргэлтийн цуглааны үеэр 500 пасторт энэхүү товхимлыг тараан өгсөн юм. Мөн 2017 оны 6 сард Хойд Филиппиний нэгдсэн залбирлын чуулган дээр 1500 хүнд товхимлыг маань танилцуулсан.

Гэрчлэлүүд- Та өөрийн гэрчлэлээ бидэнтэй хуваалцах уу? Энэ нь маш их урам зориг өгдөг юм шүү. Хэрэв мөн шаардлагатай бол доорх сайтаас гэрчлэл ашиглаж болно. www.stepsto-personal-revival.info – Testimonies

Эрхэм удирдагчдаа!

Ариун Сүнс дотор өсөж хөгжицгөөе. Эзэн Өөрөө энэ тушаалыг өгсөн юм. [МВ20.3]:

“Өөрийгөө үргэлж, тасралтгүй Сүнсээр дүүрэн байлга” (Ефес. 5:18).

Христ бидний дотор байх аваас Ариун Сүнс биднийг “Сайн мэдээг түгээгч” болгодог (Исаиа 40:9). Есүсийн хэлсэн сүүлчийн үгсийг бүү мартаарай:

“Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олох болно. [чадвар, бэлэн байдал, ер бусын хүч].” (Үйлс 1:8)

Христээр нэгдсэн ах

Хэлмут Хаубэйл

ЕСҮСИЙН ХАМГИЙН НАНДИН БЭЛЭГ

ЕСҮС АРИУН СҮНСНИЙ ТАЛААР
ЮУ ГЭЖ СУРГАДАГ ВЭ?

*Та Есүсийн хамгийн хүчирхэг мэдээтэй
танилцаж амжсан үү?*

Хувь хүний гэрчлэлүүдээс:

“Анхны хайраа” эргэн дурсая: Нэгэн эмэгтэйн бичсэн захидал: Би найзтайгаа хамт “40 өдрийн номыг”, “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” товхимолтой хослуулан одоо гурав дахь удаагаа судалж байна. Энэхүү материалыг судлахаас өмнө бидний итгэл болон залбирлын амьдрал анхных шигээ байгаагүй. Бид дахин “Анхны хайраа” олохыг маш их хүссэн юм. Тэгээд олж чадсан билээ. Бид Бурханд чин зүрх сэтгэлээсээ талархаж байна. Бидний залбирал болон залбирч буй хүмүүсийн минь төлөө Хайрын Бурханы Сүнс хэрхэн биелэлээ олж байгааг харах нь үнэхээр гайхамшигтай. М.С

Есүс бидний амьдралд орж ирсэн нь: Өөр нэгэн хүн энэ номын тухай бичсэн байна: “Эдгээр нь миний амьдралдаа маш удаан хүлээж байсан тэр их ивээлүүд байсан юм. Яг л сүмийн бусад олон гишүүн болон эгч дүүс маань мэдэрдэг шиг бидний итгэлийн амьдралд ямар нэгэн зүйл үргэлж дутагдаж байдаг. Харин одоо Есүс хэрхэн бидний амьдралд орж, өөрчилдгийг мэдрэх таатай боломж ирлээ. Тэрээр бидэнтэй ажилласаар байдаг бөгөөд алхам алхмаар Өөр рүүгээ ойртуулдаг”. С.К

Есүс хэрхэн ийм агуу нөлөөллүүдийг үзүүлж чадсан юм бол гэж Есүсийн дагалдагчид өөрсдөөсөө асууж байсан болов уу:

Энэ нь Түүний залбирлын амьдралтай холбоотой болов уу? Тийм учраас тэд Түүнээс ийн асуусан байна: “Эзэн бидэнд залбирахыг заагаач” гэхэд Есүс тэдний асуултад хариулжээ.

Түүний залбирлын хичээл Лук 11:1-13-д байдаг: Шөнө дунд талх гуйдаг хүний сургаалт зүйрлэл нь Ариун Сүнсийг тасралтгүй гуйж байгаатай адил юм.

Сургаалт зүйрлэлд, (5-8 ишлэл) шөнө дунд тэр залуугийнд зочид ирэхэд, түүнд тэдэнд өгчихөөр юм **юу ч байсангүй**. Тэрээр хэрэгцээтэй зүйлийг асуухаар шууд хөршийнх рүүгээ явжээ. Тэгээд өөрт нь **“Юу ч байхгүй”** талаар тайлбарлаж түүнээс талх гуйв. Тэрээр талхыг авах хүртлээ гуйсаар байдаг. Одоо тэрээр ирсэн зочиддоо болон өөртөө талхтай болсон – бүр амийн талхтай болсон. Тэрээр өөртөө ямар нэгэн зүйлтэй болсон бөгөөд харин одоо түүнийгээ хаана хуваалцах вэ гэсэн нөхцөлд ордог.

Тэгээд Есүс энэ зүйрлэлийг (асуудал: Надад юу ч байхгүй) **“Тиймээс Би та нарт хэлье, гуй тэгвэл та нарт өгөгдөнө”** хэмээн Ариун Сүнсийг гуйхтай холбодог Лук 11:9. Цааш нь:

Есүсийн онцгой уриалга: Тиймээс Ариун Сүнсийг гуй.

Есүс бидэнд Ариун Сүнсийг гуй хэмээн маш онцгойлон тушаасан хэсэг Библид бий. Биднийг зүрх сэтгэлдээ хүлээн авах талаар ийнхүү эелдэгээр уриалсан Есүсийн өөр ямар нэгэн зүйл Библид байдгийг би мэдэхгүй. Эдгээр ишлэлүүд нь Лук 11-т Түүний залбирлын талаарх сургаалд бий. Үүндээ Тэрээр Ариун Сүнсийг 10 удаа гуйх талаар онцгойлон дурдсан. Лук 11:9-13:

“Би та нарт хэлье. **Гуй**, тэгвэл та нарт өгөгдөнө. **Хай**, тэгвэл та нар олно. **Тогш**, тэгвэл та нарт нээгдэнэ. Учир нь **гуйдаг** хүн бүр авна, **эрж хайдаг** хүн олно, **тогшдог** хүнд нээгдэнэ. Эцгүүд та нарын нэгээс чинь хүү нь загас **гуйвал** оронд нь могой өгөхгүй нь лавтай. Тийм биш гэж үү? Эсвэл хүү нь өндөг **гуйвал**, эцэг нь хилэнцэт хорхой өгөхгүй биз дээ? Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь **гуйдаг** хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв.”

Энэ хэдэн ишлэлд Есүс “гуй” хэмээх үйл үгийг таван удаа, “гуй” хэмээх үгийг “хай” хэмээх үйлдэл шаардсан үгээр хоёр удаа - мөн дахин тус бүр нэг удаа “эрж” болон “тогш” хэмээх үйлдэл шаардсан үгээр онцолсон байна.

Ариун Сүнсээр дүүрэхийн тулд үйлдэл хэрэгтэй гэдгийг Тэрээр бидэнд тодорхой хэлсэн байна. Сүүлчийн “Гуй” хэмээх үг нь Грек хэлэнд одоо үргэлжилж буй цаг дээр бичигджээ. Энэ нь бид зөвхөн нэг удаа асуугаад

өнгөрөх биш харин үргэлжлүүлэн асуусаар байх гэсэн үг юм. Энд Есүс биднийг зөвхөн яарсан үедээ биш харин үргэлжлүүлэн гуйсаар байхыг хүссэн. Мөн тэрээр энэхүү чинь сэтгэлийн урилгаараа Ариун Сүнсийг хүсэн тэмүүлэх бидний хүслийг сэрээхийг хүссэн нь тодорхой. Энэхүү яаралтай уриалга нь хэрэв бид Ариун Сүнсийг үргэлжлүүлэн гуйхгүй бол ямар нэгэн чухал зүйлийг алдаж болох талаарх Есүсийн ятгалгыг харуулдаг. Тэрээр бидний анхаарлыг Ариун Сүнс үнэхээр хэрэгтэй гэдэгт чиглүүлж буй нь тодорхой байна. Энэхүү арга замаар Есүс биднийг Ариун Сүнсний бялхам ивээлийг үргэлж авсаар байгаасай гэж хүсдэг.

Христийн сургамжийн санаа нь: “Бурхан нэг удаа гуйгаад, хүссэн юмаа авна гэж хэлээгүй” Тэрээр биднийг цуцашгүй залбирлаараа гуйсаар байгаасай гэж хүсдэг. Шаргуу гуйх нь тухайн хүнд идэвхтэй хандлагыг өгч, асуусан зүйлээ хүлээн авах хүслийг нь хүчтэй бадрааж өгдөг.”¹

Есүс гурван жишээ харуулсан. Нүгэлт хүн хүртэл хүүгийнхээ төлөө итгэмээргүй зан гаргаж байхад тэнгэрлэг Эцэг маань биднийг гуйхад бидэнд Ариун Сүнсийг өгөх нь дамжиггүй гэдгийг харуулж байна. Хэрэв бид Ариун Сүнсийг зохистойгоор гуйвал авна гэдэгтээ итгэлтэй байгаасай гэж Есүс хүсдэг. Энэ амлалтыг болон бусад амлалтыг барин гуйсан зүйлээ аль хэдийн авсан гэдэгтээ итгэж болно. (1 Иохан 5:14-15; илүү мэдээлэл 5-р бүлэгт бий)

Энэхүү онцгой уриалга нь Есүсийн хэлсний дагуу бид тасралтгүй Ариун Сүнсийг гуйхгүй бол ямар нэг чухал зүйл дутагдах болно гэсэн үг. Тэгэхээр бидний анхаарлыг Ариун Сүнс маш их хэрэгтэй гэдэгт хандуулж байна. Тэрээр биднийг Ариун Сүнсний бялхам ивээлийг үргэлж мэдэрч байгаасай гэж хүсдэг.

Залбирлын талаарх Түүний сургамж бол их өвөрмөц үйл явц юм. Ариун Сүнс бол Бурханы агуу бэлэг бөгөөд Өөрөө бусад бэлгүүдийг хамт дагуулан ирдэг. Энэ нь Түүний дагалдагчдадаа өгсөн шилдэг бэлэг бөгөөд Бурханы хайрын цэвэр баталгаа билээ. Энэхүү үнэ цэнэтэй бэлгийг хэн нэгэн рүү түлхэж болохгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ нь зөвхөн тэрхүү бэлгийг хүсэн тэмүүлж, талархсан хүмүүст л ирдэг.

Мөн Ариун Сүнс нь Есүст амьдралаараа бууж өгсөн хүнд л бууж ирдэг. Ариун Сүнс нь үргэлж хариу үйлдэл гаргадаг хүмүүст ирнэ (Иохан 15:4-5). Үйлдлийг доорх зүйлсээр илэрхийлнэ:

- ▶ Бурханыг хүсэмжлэх (“цангасан хэн боловч” Иохан 7:37)
- ▶ Бурханд итгэх (“бичвэрт бичсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол үрсах болно” Иохан 7:38)
- ▶ Бурханд итгэж, бүрэн бууж өгөх (“Бурханы эрх мэдэл дор бүхий л амьдралаа тавьж өгөх” Ром 12:1)

1 Элен Уайт, *Христийн сургамжууд* (1900), х. 145.3

- ▶ Бүх зүйл дээр Бурханыг дагах (“Түүнийг дагадаг хүмүүс” Үйлс 5:32)
- ▶ Өөрийн замыг огоорч Бурханы замыг сонгон Түүний хүслийн дагуу үйлдэх. (“гэмшиж, баптисм хүртэх” Үйлс 2:38)
- ▶ Ямар нэгэн бүрүү зүйл төлөвлөхгүй байх (“Хэрэв би зүрхэндээ цөв мууг хүндэтгэсэн бол Эзэн сонсохгүй байхсан” Дуулал 66:18)
- ▶ Өөрсдийн чухал хэрэгцээгээ хүлээн зөвшөөрч, ойлгох (“надад юу ч байхгүй” Лук 11:6)
- ▶ Ариун Сүнсийг гуйсаар байх (Лук 11:9-13)

Бурханы биднээс хүсдэг эдгээр хүлээлтүүдээс энэхүү бэлэг нь ямар үнэ цэнэтэй болохыг та анзаарч байна уу? Эдгээр шаардлагыг бодох үед та өөрөөсөө сул талаа олж харах болно.

“Хэрэв хэн нэгэн цангавал Над дээр ирж, Надаас уу” хэмээн Иохан 7:37-д өгүүлсэнчлэн Ариун Сүнстэй холбоотой байхын тулд өдөр бүрийн залбирлыг би дадал болгон хэвшүүлсэн юм.²

Бидний залбирал: “Эзэн Есүсээ, би Ариун Сүнсийг хүлээн авахын тулд бүх шаардлагуудад тийм гэж хэлье. Би Танаас өнөөдөр чин сэтгэлээсээ энэ бүгдийг миний дотор бялхаагаач хэмээн гуйж байна.”

Гайхамшигт Бурхан бидний төлөө энэхүү шаардлагуудыг биелүүлэхэд Өөрөө тусалсаар байгаа билээ.

Ариун Сүнс бол бүрэн дүүрэн амьдралын эх сурвалж юм.

Есүс яагаад энэ дэлхийд ирсэн вэ? Тэрээр

“Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм” гэжээ. (Иохан 10:10)

Есүс биднийг энэ шинэ амьдралыг мэдэрч мөн Бурханы хаанчлалын мөнхийн амьдралыг авч ирэх Түүний дахин ирэлт хүртэл хадгалаасай гэж хүсдэг.

Мөн Тэрээр бидэнд бүрэн дүүрэн амьдралын эх үндэс бол Ариун Сүнс гэдгийг заадаг: “...Хэрэв цангасан хүн байвал, Над уруу ирж, уугтун. Надад итгэдэг хүн “Түүний дотроос амийн усны гол урсах болно” гэж Сударт хэлсэнчлэн байх болно гэв. Есүст итгэсэн хүмүүсийн хүлээн авах Сүнсний тухай Тэрээр ийн хэлжээ.” (Иохан 7:37-39)

“Амийн усны гол” – энэ нь бүрэн дүүрэн амьдралын талаарх тохирсон жишээ биш гэж үү?

² Бурханы Амлалтуудыг дурдаад залбирахад, илүү үр дүнтэй байдаг.

Энэ талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл 4-р бүлгийг уншаарай.

Есүс дэлхий дээр амьдарч байх хугацаандаа бидэнд ямар жишээ үзүүлсэн вэ?

Мариа Ариун сүнсээр дамжуулан Есүсийн талаар ойлгосон гэдгийг бид мэднэ. (Матай 1:18). Баптисм хүртсэнийхээ дараа “Ариун Сүнс биет хэлбэрээр Түүн дээр тагтаа мэт буун ирэхэд ...” (Лук 3:22) Тэрээр Ариун Сүнсийг хүлээн авсныг бид мэднэ. Тэгвэл Есүс Ариун Сүнсийг өдөр бүр хүлээн авах зайлшгүй чухал хэрэгтэй гэж үү? Элен Уайтын бичсэнээр:

“Өглөө бүр Тэрээр тэнгэрийн Эцэгтэйгээ харилцдаг ба Түүнээс өдөр бүрийн Ариун Сүнсний шинэ баптисм хүртдэг байв.”³

Элч Нарын Үйлс номноо: “Христ ч мөн адил дэлхий дээр амьдарч байх хугацаандаа Эцэгээсээ өдөр бүрийн хэрэгцээт зүйлсээ эрж асууж байсан гэдгийг мэдэх нь ариун ажилчдын хувьд тайтгарам сайхан мэдээ билээ....”⁴

Энэ тал дээр Есүс бидэнд үнэхээр жишээ болсон юм. Бид өөрсдөөсөө: Хэрэв Есүс өдөр бүр Ариун Сүнснээс хүчийг авдаг байсан юм бол танд болон надад ямар их чухал байх вэ? гэж өөрсдөөсөө асуух хэрэгтэй.

Элч Паул Есүсийн зорилгыг үнэхээр сайн ойлгосон байжээ. Ефесийн чуулганд бичсэн захидалдаа Паул Ефес 1:13-д Түүнд итгээд, амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан байв хэмээн үүнийгээ баталж өгсөн байна. Ефес 3:16-17-д Сүнс дотор хүчтэй байхыг уриалдаг бол Ефес 5:18-д эрх мэдэлтэй элчийн хувьд Паул өөрөө биднийг болон Ефесчүүдийг: “*Үргэлж мөн дахин дахин өөрийгөө Сүнсээр дүүрэн байлга*” хэмээн уриалсан байдаг.⁵ Бид дахин төрж Ариун Сүнсийг хүлээн авсан ч өдөр бүр хүч чадал авах хэрэгцээтэй байдаг. Ариун Сүнсээр өдөр бүр дүүргэгдэх нь итгэгч хүний өсөлт болон сүнслэг амьдралд маш чухал билээ.

Бидний Шаббат хичээлийн ном Ефес 5:18-н талаар өгүүлдэг: “Ариун Сүнсээр баптисм хүртэнэ гэдэг нь яг юу гэсэн үг вэ? Есүс үүнийг ижил утгатай жишээгээр тайлбарладаг. Ариун Сүнс тэдэн дээр буухад (Үйлс 1:8) тэд Ариун Сүнсээр баптисм хүртсэн гэсэн үг (Үйлс 1:5). Баптисм хүртэнэ гэдэг нь ямар нэгэн зүйлд бүрэн булхаж орно гэсэн үг (ихэвчлэн усанд). Энэ нь тухайн хүнийг бүхлээр нь оруулдаг (норгодог). Ариун Сүнсээр баптисм хүртэнэ гэдэг нь Ариун Сүнсний бүрэн нөлөөнд орж, Түүгээр бүрэн дүүрнэ гэсэн үг юм.

3 Элен Уайт, Цаг үеийн тэмдгүүд, 1895 он 11 сарын 21, 3-р хэсэг

4 Элен Уайт, Элч нарын үйлс (1911), х. 56.1

5 Жоханнес Marep, Auf den Spuren des Heiligen Geistes, (Luneburg, 1999), Seite 101



Паул Ефес 5:18-д “дүүрэх” хэмээх Грек үйл үгээр үүнийг зөвхөн нэг удаа мэдрээд орхих биш харин үргэлжлүүлэн давтан дахин дахин хийх ёстой зүйл хэмээн илэрхийлжээ.⁶

Есүсийн сүүлийн үгс болон Ариун Сүнс

Есүс хамгийн сүүлд Өөрийнх нь оронд Ариун Сүнс ирнэ хэмээн хэлснээрээ баяр хөөр, итгэл найдвар өгсөн юм. Иохан 16:7:

“Харин Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв Би явахгүй бол Туслагч та нар уруу ирэхгүй. Харин Би явбал Өөрөө Түүнийг та нар уруу илгээнэ.”

Шинэ Шийдэл

Есүс дагалдагчдаа гайхалтай үг хэлжээ: “Миний явах нь та нарт хэрэгтэй.” Энэ нь тэрхүү шинэ шийдэл бөгөөд Тэрээр Ариун Сүнсээр бидэнтэй хамт байна гэдэг бол Есүс Өөрөө биеэрээ байхаас илүү давуу талтай гэсэн үг юм. Энэ аргаар Тэрээр хязгаарлагдалгүй, хаана ч байсан хамаагүй хүн бүртэй хамт байж чадна гэсэн үг юм.

Багш шавь хоёрын гэрчлэл:

Жилийн өмнө манай сүмд Хаубэйлийн “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” товхимол тараасныг би зүгээр л хурдан гүйлгэж уншиж билээ. Уншаад би өмнө нь мэдэрч байгаагүйгээрээ Бурханыг мэдэрч, сонирхол минь татагдаж мөн урам зориг авсан юм.

Уг номын хавсралтаас: Чухал сэдвийг бүрэн ойлготлоо зургаагаас арван удаа зайлшгүй унших хэрэгтэй гэж судалгаагаар тогтоожээ.

“Ядаж нэг удаа оролдоод үзээрэй. Үр дүн нь гайхалтай байх болно” гэсэн мөрүүдийг уншиж билээ. Эдгээр урмын үгс миний анхаарлыг татсан юм.

Үүнийг л мэдрэхийг хүссэн бөгөөд гурав дахь удаагаа уншихад, илүү ойлголт авч, бүх л амьдралынхаа туршид хүсэн тэмүүлж байсан Аврагчаа хайрлах агуу хайрыг мэдэрсэн юм. Хоёр сарын дотор би зургаан удаа уншсан бөгөөд гайхалтай үр дүнтэй байлаа.

Энэ нь Есүс бидэнд ойртон Түүний эелдэг зөөлөн, цэвэр ариун нүд рүү ширтэхэд бидэнд ямар байхыг мэдрэх шиг л санагдав. Үүнээс хойш би Аврагчийн доторх баяр хөөр дүүрэн амьдрахыг хүссэн юм.

Би өглөө босоод Бурхантай хамт байх тэрхүү мэдрэмжийг дахин мэдрэхийн тулд өглөөний мөргөлийн цагийг хүсэн хүлээдэг ба өдрийн туршид Ариун Сүнс миний бодол, бусадтай харилцах харилцаа, үлгэрлэл, зааж сургах, ярих явцад минь туслаасай хэмээн залбирдаг болсон.

Хүүхдүүд анхаарал татах гэж янз янзын үйлдэл гаргахад, Бурхан надад үүнийг хэрхэн шийдэх хүч чадал, мэргэн ухааныг өгдөг.

Түүнээс хойш ажлын өдрүүд маань хүртэл Бүтээгчийн оршихуйгаар дүүрэн байх болсон. Тэрээр өдөр бүрийн минь амьдралд үнэхээр тусалдаг. Тэгээд би Ариун Сүнсийг авахын төлөө өглөө бүр мөн цаг тутамд залбирдаг болсон. Энэ нь яг л хэрэв та диваажинтай ойр байвал үүнийг ямар гэдгийг мэдрэдэгтэй адил юм.

Номыг уншиж байх явцад сургуулийн сурагчид минь ч мөн адил энэ зүйлийг сүраад, бусдад хуваалцаасай гэсэн бодол орж ирэв. Би Австрийн Ворарлберг дэх Елиша Адвентист сургуульд 10-15 насны хүүхдүүдэд хичээл заадаг. Тэгээд би Бурханд хандан боломж өгөөч хэмээн залбирлаа. Удалгүй би Ариун Сүнс залуу хүмүүсийн зүрх сэтгэлд хэрхэн ажилладаг талаар гайхалтай гэрчлэлтэй болсон юм.

13 настай Руфиан хүү ба Ариун Сүнс

Энэ явдал Ариун Сүнсний талаар товхимол уншихаас жилийн өмнө тохиолдож билээ. Нэгэн шинэ сурагч манай сургуульд шилжин ирсэн бөгөөд хэдхэн өдрийн дотор бидний амар тайван орчин зодоон нүдээнтэй шуугисан орчин болж хувирлаа. Хүү 13 настай бөгөөд бусад хүүхдүүдээс том биетэй түүндээ таарсан хүчтэй. Хичээлийн жилийн турш зааж, үр дүнгээ өгч байсан зүйл хормын дотор алга болох шиг л санагдав.

Хүүгийн үгийг сонсоход тэрээр: “Энэ сургуульд шилжиж ирэхэд, намайг юу хүлээж байсныг би мэдээгүй. Хичээлийн хоёр дахь өдөр зүгээр баймааргүй санагдаж, ангийнхаа нэг хүүхдийг хуучин сурсан зангаараа хоргоон зодолдов. Хэдийгээр тэр надаас сүл дорой байсан ч би түүнийг цохиж, дахин хэзээ ч уулзахыг хүссэнгүй. Дараа нь би өмнө хийж заншсанаараа алдаагаа ухаарч түүнээс уучлалт гуйлаа.

Тэр явдлын дараа би сургуулийн захиралтайгаа ярилцаж, дараагийн сард надад өөрчлөлт гарч эхэллээ. Энэ нь намайг пасторын хүү болох тэр үеэс биш харин одоо эхэлж байгаа нь гайхалтай. Тэгээд би Есүстэй илүү их цаг өнгөрөөдөг болсон юм” гэж ярих.

Энэ хүүд онцгой анхаарал хэрэгтэй гэж би бодов. Тэрээр алдаагаа ойлгож үүндээ гэмшсэн ч дахиад л давтдаг байлаа. Тэрээр өөрийн хүч чадлаар амжилтанд хүрэхгүй байв. Анхандаа түүнд зодоон хийхгүй байх нь хэцүү байсан ч аажмаар илүү дээр боллоо.

Зургаан сарын дараа тэрээр Бурхантай ойртсон нь залбирлынх нь хариу гэж бодсоноо хэлсэн юм. Тэрээр өглөө бүр хүч чадал гуйн залбирч

эхэлсэн байжээ. Түүний уур уцаар, зодоон нүдэн нь багасав.

Тэрээр манай сургуульд ирснээс хойш 11 сар өнгөрчээ. Бид одоо ч илүү их өсөлт харж байна. Гэхдээ түүний уур уцаар, хараал хэлэх мөн нудрага зангидах нь бүрэн арилаагүй л байгаа.

Заримдаа зөвхөн өөрийн ойлголт, хүч чадлаар ялахыг оролдох нь байдаг л зүйл юм. *Бидний залбирал үр дүнгээ өгсөн бөгөөд хэдийгээр түүний оюун санаа нь төлөвшөөгүй байгаа ч Ариун Сүнсийг хүлээн авсаар байна.*

Би өөрийнхөө оюун ухаанд найдаж байгаагаа ухаарах яг тэр мөчид энэхүү номыг хүлээн авсан юм. Энэ нь надад яг л хэрэгтэй цагтаа ирсэн бөгөөд бид яг юу алддагийг ухааруулсан нь Ариун Сүнсний хүч байсан юм. Бид Ариун Сүнснээс туслаач ч гэж гуйдаггүй!

“Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” хэмээх энэ номоос ухаарал авснаас хойш надад тэр хүүгээс Ариун Сүнсийг гуйхаар залбирсан эсэх талаар нь асуумаар санагдав. Тэрээр үгүй- хэзээ ч асууж байгаагүй гэж хариулж билээ. Тэгээд би түүнд энэ ном ямар сайхан сонирхолтойг хэллээ. Гэсэн хэдий ч би түүнд номоо өгсөнгүй. Учир нь тэрээр өөрөө эхлээд хүсэх хэрэгтэй. Гэвч удалгүй хүү надаас номыг асуусан юм.

Дараа нь тэрээр ингэж хэлсэн юм: “2012 оны 11 сард багш минь надад “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” гэдэг ном өгөв. Би үүнийг идэвхтэй гэгч нь уншиж эхэлсэн. Анх уншихдаа би Ариун Сүнс хэрхэн ажилладгийг тийм ч сайн мэддэггүй байсан.”

Эхний хоёр өдөр тэрээр бараг хоёр бүлэг уншсан байсан ба би хэдэн удаа унших вэ хэмээн асуусан юм. Товхимолд 6-10 удаа унших хэрэгтэй гэснийг нь биелүүлэх хэрэгтэй гэхэд тэрээр бүлгүүдийг дахин уншиж эхэлсэн байлаа.

Түүнээс хойш маш олон зүйлс өөрчлөгдсөн. 2012 оны 12 сараас хойш ямар ч зодоон нүдэн байхгүй болсон ба би энэ өөрчлөлтөнд арай ядан итгэж байв. Өдөр бүр зодуулдаг байсан хөвгүүд түүний найзууд болж, тэд эв найртай нөхөрлөдөг болсон юм.

Тэрээр бүрэн өөрчлөгдөж, эелдэг, тусч мөн амар тайван болж, түүний түрэмгий зан чанар ор мөргүй алга болсон байв. Ангийнхан нь ч Бурхан түүнийг дотроос нь өөрчилж байгаа гэдгийг баталж чадна. Та бүхэн ийм үр жимсийг өдөр бүр харж болно. Бурханы алдрын төлөө тэр хүү 2013 оны 6 сард усан баталгаа хүртэх шийдвэр гаргасныг би дурдмаар байна. Хэрэв Ариун Сүнс байгаагүй бол энэ боломжгүй байсан. ...

Би үргэлж өөрийгөө хүүхдүүдтэй хамт байж тэднийг юмны учир ойлгодог болгож чадна гэж боддог байлаа. Тэвчээр, анхаарал, мөн маш их ярилцсаны үндсэн дээр амжилттай болдог боловч энэ нь удаан үргэлжилдэггүй. Харин Бурхан надад боломжгүйг боломжтой болгодог Түүний Сүнсээр хийх хэрэгтэйг зааж өгсөн юм. Нэгэн өдөр энэ хүү

диваажинд байвал Бурхан түүнийг авч ирсэн гэдгийг би ойлгоно. Би аргаа барж, энэ хүүг өөрчилж чадахгүй юм байна гэж шантрах үед Бурхан түүний төлөө ажиллаж эхэлсэн. Бурханы хувьд ямар ч найдлагагүй болсон зүйл гэж байдаггүйг хараад урам орж билээ. С.Р.

Залбирал: Тэнгэрийн Эцэг минь ээ, Есүсийн бидэнд хандан Ариун Сүнснийг яаралтай гуй гэсэн уриалгын төлөө талархаж байна. Ариун Сүнсний дутмаг байдлаас болж амсаж байсан гарз хохирлуудыг минь уучлаач. Есүс миний хувьд хамгийн эрхэм нандин Нэгэн болохын тулд надад тусламж хэрэгтэй байна. Амьдралын минь бүхий л хэсэгт Түүний тусламж хэрэгтэй байна. Ариун Сүнс миний зан чанарыг өөрчилж, Бурханы хаанчлалд бэлтгэж байгаад баярлалаа. Би байгаа бүхнээрээ танд бууж өгч байна. Намайг хүлээн авч, ивээж байгаад баярлалаа. Ариун Сүнсний талаарх мэдлэгээр өсөхөд минь туслаач. Амен.

БИДНИЙ АСУУДАЛЫН ГОЛ ШАЛТГААН ЮУ ВЭ?

*Бидний асуудалд сүнсэлг шалтгаан байна уу?
Энэхүү шалтгаан нь Ариун Сүнс дутагдсанаас болдог уу?*

ХОМСДЛЫН ШАЛТГААНУУД

Библийн хариултууд: “Та нар гуйдаггүй учраас та нарт байдаггүй. Та нар гуйгаад хүлээн авдаггүй. (махан биеийн бодлын дагуу, Ром. 8:5-7), Учир нь та нар өөрсдийн тааламжинд зарцуулъя хэмээн буруу гуйдаг байна.” (Иаков 4:2-3). Бидний Эзэн Есүс Ариун Сүнсийг үнэнчээр, тууштай гуйхыг уриалсан. (Лук 11:9-13). Үргэлж Ариун Сүнсийг гуйх хэрэгтэй гэдгийг бид мэддэг. Гуравдугаар бүлэгт бид энэ талаар илүү ихийг сурах болно.

“Тэд Христийн тухай мөн Ариун Сүнсний тухай ярьдаг ч ямар ч ач тус хүртдэггүй. Тэд зүрх сэтгэлээ бурханлаг зүйлсээр удирдуулан чиглүүлэхээс татгалздаг.”⁷

Бид заримдаа сэргэлтийн төлөө залбирдаг. Энэ нь үнэхээр үр дүнтэй. Элен Уайт: “Өнөөдөр Сүмүүдэд Ариун Сүнсний баптисм нэн чухал хэрэгтэй байна” гэж хэлжээ.⁸ “Хүч чадал өгдөг Ариун Сүнсний бэлгүүдээр бид яагаад өлсөж цангахгүй байна вэ? Бид яагаад энэ талаар ярихгүй, залбирахгүй мөн номлолдоо ч оруулахгүй байна вэ?”⁹

7 Элен Уайт, Үе үеийн хүслэн (1898), х. 672

8 Элен Уайт, Гар бичмэлүүд, Боть. 7 х. 267

9 Элен Уайт, Сүмүүдэд өгөх гэрчлэл 8-р боть (www.egwwritings.org), х.

Сэргэлт шинэчлэлийн төлөө залбирах нь сайн боловч зөвхөн залбирах нь хангалтгүй бөгөөд харин Марк Финлигийн **“Сэргэлт шинэчлэлийн зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй”**¹⁰ гэж хэлснийг үйлдэл болгох хэрэгтэй. Би танаас сэргэлт шинэчлэлийн алхмуудыг хэрэгжүүлээд үзээч хэмээн чин сэтгэлээсээ хүсч байна. Энэ нь таныг бүрэн төгс, илүү хүчирхэг амьдрал руу чиглүүлэх болно.

Эхлэхийн тулд бид асуудлаа тодорхойлох хэрэгтэй. Бид анхнаасаа маш сайн эхлүүлэх учиртай. Үгүй бол бид тийм ч чухал биш зүйлсийг өөрчлөхөөр хүч цаг заваа үрэх аюултай. Үүний дараа гайхалтай ивээлүүдийг санал болгодог Бурханы шийдлийн талаар ярилцана. Тэгээд эцэст нь хэрхэн хэрэгжүүлж, амьдралдаа мэдрэх талаар үзэх болно.

Ариун Сүнсний дутмаг байдал нь бас ч бүх зүйлийг үр дүнгүй хийж байна гэсэн үг биш юм. Хүмүүс маш олон сайн төсөл төлөвлөгөө хэрэгжүүлдэг. Эзэн бидний хүчин чармайлтуудыг ч сайн ивээдэг. Гэвч бид Ариун Сүнстэй илүү дотно амьдарч чадвал ямар агуу үр дүн, илүү сайн нөхцөл байдалтай байх байсан бол гээд бодоорой. Гэхдээ үүнийг зөвхөн Бурхан мэднэ.

Хэнри Т. Блакаби энэ талаар ийн хэлжээ:

“Бурхангүйгээр жаран жил хийх байсан зүйлийг Өөрийнх нь (Бурханы) төлөө байсан хүнд зургаан сарын дотор илүү давуу хийж өгч чадна”¹¹

Энэ бол Бурханы удирдамжид шууд шилжүүлэх асуудал бөгөөд тэгснээр илүү үр дүнтэй байх болно. Гэхдээ зөвхөн Ариун Сүнсээр дүүргэгдсэн үед л бий болох боломжтой.

Жишээлбэл хэн нэгэн сургаал номлолоо гэж бодъё. Түүнийг номлож дуусахад, магадгүй нэг ч биш эсвэл хэдэн хүн эсвэл бүгд хүлээн авч болох юм. Хэрэв бүгд сургаал номлолын санааг хүлээн авч амьдралдаа хэрэгжүүлбэл энэ нь маш сайн үр дүн гэсэн үг юм. Энэ бол тэрхүү Ариун Сүнсний өгдөг зүйл билээ.

10 Марк А. Финли, *Биднийг дахин шинэчлээч*, х. 25

11 Хэнри Т. Блакаби, *Den Willen Gottes erkennen und tun (Бурханыг мэдрэх нь: Бурханы хүслийг мэдэж мөн үйлдэх нь)*, (Кассел, 2002), х. 31

ГУРВАН БҮЛЭГ ХҮМҮҮС БА ТЭДНИЙ БУРХАНТАЙ ХАРИЛЦАХ ХУВИЙН ХАРИЛЦАА

Гурван өөр бүлэг хүмүүсийн тухай авч үзье. Тэдний Бурхантай харилцах харилцааны хувьд Бурханы үг тэдэнд тус бүр ялгаатай тусч байлаа. Эдгээр бүлэг тус бүрт эцэг эхийн хүмүүжил, зан чанар, өөрийгөө хөгжүүлсэн байдал, нас хүйс, соёл, боловсролоос эхлээд ялгаатай талууд байв. Гэхдээ ялгаатай тал олон хэдий ч тэдэнд **Бурхан руу хандсан гурван үндсэн хандлага байна:**

- ▶ Харилцаагүй – Библийнхээр бол үүнийг натурал буюу **төрөлх** хүн гэж нэрлэнэ.
- ▶ Дүүрэн, жинхэнэ харилцаа холбоотой – Библийнхээр бол **сүнслэг** хүн
- ▶ Тусгаарлагдсан эсвэл дүр эсгэсэн харилцаа –Библи үүнийг **махан биеийн хүслээр байгч** хүн гэж тодорхойлдог.

Бурханы Үгэн дэх “төрөлх”, “сүнслэг”, “махан биеийн” гэсэн нэр томъёонууд нь тэднийг үнэлж байгаа хэрэг биш юм. Эдгээр нь зөвхөн тэдний Бурхантай харилцах хувийн харилцааг нь тодорхойлдог.

Эдгээр гурван бүлэг нь 1 Коринт 2:14-16 болон 1 Коринт 3:1-4-д дүрслэгдсэн байдаг. Бүгдээрээ “Натурал буюу төрөлх” хүний талаар маш товчхон авч үзье. Тэрээр дэлхийд амьдардаг. Харин бусад хоёр бүлгийн хүмүүс сүмд хамаарагдана. Хамгийн чухал ойлгох хэрэгтэй зүйл бол та өөрөө аль бүлэгт хамаарч байгаагаа мэдэх юм. Бидний энэхүү шалгах тест нь өөрсдийгөө оношлоход тусална. Бид бусдын биш өөрсдийнхөө амьдрал руу харах хэрэгтэй.

Бүлгүүд хоорондоо ямар ялгаатай байна вэ? Гурван бүлэг маань гурвуулаа Ариун Сүнстэй харилцах хувийн харилцааныхаа улмаас тодорхойлогддог болохыг бид авч үзэх болно.

Төрөлх хүн

*“Харин төрөлх хүн **Бурханы Сүнсний зүйлийг хүлээж авдаггүй.** Сүнслэг зүйлс нь ийм хүнд мунхаглал бөгөөд сүнслэгээр цэгнэгдэх учиртай эл зүйлсийг тэр мэдэж чаддаггүй.” (1 Коринт 2:14)*

Төрөлх хүн бол үнэхээр Бурхантай ямар ч харилцаагүй байдаг. Тэрээр дэлхийн амьдралаар амьдардаг бөгөөд Бурханы талаар огтхон ч асуудаггүй эсвэл маш ховор асуудаг.

Сүм доторх сүнслэг болон махан биеийн дагуу байгч гишүүд

Энэ хоёр төрлийн хүнийг 1 Коринт 2 болон 3 дугаар бүлэг мөн Ром 8:1-17, Галат 4 болон 6 дугаар бүлэгт танилцуулдаг. Энэ хоёр бүлэг хүмүүсийн гол шалгуур нь Ариун Сүнстэй харилцах харилцаа гэдгийг анхаарах хэрэгтэй. Ариун Сүнс бол тэнгэртэй холбогдох цорын ганц холбоос гэж Бурхан тогтоосон. (Үе үеийн хүслэн, х. 322; Матай 12:32) “Зүрх сэтгэл Ариун Сүнсний нөлөөлөлд нээлттэй байх ёстой ба эс тэгвээс Бурханы ивээлийг хүлээн авч чадахгүй.”¹²

Сүмийн Сүнслэг гишүүн

1 Коринт 2:15-16-г уншаарай:

“Сүнслэг нэгэн нь бүх зүйлсийг шүүдэг боловч тэрээр өөрөө хэнээр ч шүүлгэхгүй. Хэн ЭЗЭНий Сүнсийг удирдан, эсвэл Түүний зөвлөх нь болж, Түүнийг сургасан бэ? (Исаиа 40:13) **Гэвч бидэнд Христийн оюун ухаан бий.**” (NKJV)

“Сүнслэг нэгэн нь бүх зүйлсийг шүүдэг боловч Эзэний оюун бодлыг мэддэг нэгэн зүгээр нэг хүнээр шүүлгэнэ гэж үү. Хэн ЭЗЭНий Сүнсийг удирдана, эсвэл **гэвч бидэнд Христийн оюун ухаан бий.**” (NIV)

Сүнслэг нэгэн бол жинхэнэ Христэд итгэгч юм. Түүнийг Сүнслэг гэж хэлдэг учир нь тэрээр Ариун Сүнсээр дүүрсэн нэгэн билээ. Ариун Сүнстэй харилцах харилцаа нь сүнслэг хүний гол шинж чанар ажээ. Тэрээр Ариун Сүнстэй ойр бөгөөд өсөж төлөвшсөн харилцаатай. Есүс түүний **“амьдралын төвд”** байдаг ба бид заримдаа Есүс бидний зүрх сэтгэлийн сэнтийд залардаг ч гэж ярьдаг. Сүнслэг хүний гол зарчим нь өглөө бүр бүх талаараа Есүст бууж өгөн, өдөр бүр өөрийгөө Түүнд даатгадаг тийм л хүн юм. Лаодикчуудад бичсэн захидалд тийм хүнийг “Халуун” гэж дуудсан бол арван ариун бүсгүйн сургаалт зүйрлэлд түүнийг “Мэргэн” гэж дуудсан байдаг. Ром 8:1-17 болон Галат 5 бүлэгт энэхүү сүнслэг хүний талаар илүү их бий. Тэрээр амьдралыг **“Илүү элбэг хангалуунаар мэдэрдэг”** (Иохан 10:10). Мөн Паул үүнийг **“Та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай”** хэмээн илэрхийлжээ. (Ефес 3:19; Колоссай 2:9)

Махан биеийн дагуух сүмийн гишүүд

Ийм хүн сүмд богино хугацаанд эсвэл олон жил байсан байж болох юм. Яг энэ мөчид магадгүй та ч мөн адил махан биеийн итгэгч байж болох юм. Гэхдээ бүү сэтгэлээр унаарай. Харин ч баяртай байх хэрэгтэй. Учир нь танд үүнийгээ даруй өөрчлөх боломж байна. Та Ариун Сүнстэй хамт алхсанаар агуу баяр хөөрийг мэдрэх болно.

12 Элен Уайт, *Христэд хүрэх зам*, Leuchtende Spuren (Hamburg, 1959), х. 69

Ихэнх махан биеийн итгэгчид өөрийн мэдэлгүй ийм нөхцөл байдалд орсон хэдий ч итгэлийн амьдралдаа Бурханыг мэдрэх хүсэлтэй байдаг. Гэвч энэ байдлаа мэдээгүй нь тэдний буруу биш юм. Ариун Сүнсний тусламжтайгаар зүрх сэтгэлдээ Христийг оруулж, гайхалтай баяр хөөрийг мэдэрч болно. Иохан 15:11-д: “Баяр хөөрөөр дүүрэх болтугай.” гэж Есүс хэлдэг. Энэхүү өөрчлөлтөөр та бялхам амьдралын амтыг (Иохан 10:10-д энэ талаар дэлгэрүүлж үзэх болно) бага багаар мэдэрч мөнхийн амьдралын баттай найдварыг олох болно.

Залбирал: Тэнгэрийн Эцэг минь, өөрөөсөө энэхүү асуултыг асуухад минь туслаач. Хэрэв би махан биеийн итгэгч бол даруйхан өөрчлөхөд минь туслаач. Таны хүсдэг бүх зүйлсийг хүсэн тэмүүлдэг нэгэн болмоор байна. Намайг тэрхүү мөнхийн амьдрал руу болон бялхам дүүрэн амлагдсан аз жаргалтай Христэд итгэгчийн амьдрал тийш удирдан чиглүүлээч. Зүрх сэтгэлийг минь шинэчлээч. Залбиралд минь хариулдагт баярлалаа. Амен.

1 Коринт 3:1-4-т элч Паул махан биеийн дагуу байгч сүмийн гишүүдийн талаар юу гэж бичсэнийг уншицгаая. “Ах дүү нар аа, сүнслэг хүмүүстэй ярихын адил би та нартай ярьж чадсангүй. Харин махан биеийн хүнтэй, Христ доторх балчир хүүхэдтэй ярихын адил ярьсан. Би та нарт сүү өгсөн. Бор хоол өгөөгүй. Тэгэхэд та нар чадваргүй байсан. Одоо ч гэсэн та нар чадваргүй байна. Учир нь та нар одоо хүртэл махан биеийнхээ дагуу байна. Та нарын дунд атаархал, маргаан байгаа нь та нар махан биеийнхээ дагуу, хүний ёсны дагуу явдаггүй гэсэн хэрэг үү? Учир нь нэг нь “Би Паулынх” гэхэд, нөгөө нь “Би Аполынх” гэж буй та нар тийм хүмүүс биш үү?”

Энэхүү хэсэг бүлэг хүмүүсийг тодорхойлох шалгуур нь Ариун Сүнстэй харилцах тэдний хувийн харилцаа гэдгийг та тодорхой ойлгож байгаа болов уу. Элч Паул энэ цөөн ишлэлд тэднийг махан биеийн дагуу байна гэдгийг дөрвөн удаа дурджээ. Махан биеийнх гэдэг нь яг юу гэсэн үг вэ? Энэ нь хүний өөрийнх нь төрөлх хүч болон чадвар бөгөөд тухайн хүн тэрхүү махан биеийн төрөлх хүчээрээ амьдардаг гэсэн үг юм. Цаашилбал тэр хүн Ариун Сүнсээр дүүрээгүй эсвэл Ариун Сүнсээр хангалттай дүүрч амжаагүй гэсэн үг юм.



Зарим хүмүүс эдгээр хэсэг бүлэг хүмүүсийг илэрхий гэм нүгэлтэн гэж боддог. Гэвч энэ нь тэдний сүүдэртэй олон байдлын зөвхөн нэг нь юм. Эдгээр гурван бүлэг хүмүүсийн дунд маш олон ялгаатай талууд байдаг гэдгийг цохон дүрдмаар байна.

Паул махан биеийн дагуу байгч “Хүмүүст ах дүү нараа” гэж хандсан нь сүмийн гишүүдтэй харьцаж байгааг илэрхийлж байна. Паул тэдэнтэй “Сүнслэг хүмүүстэй ярихын адил” ярьж чадаагүй. Энэ нь **тэд Ариун Сүнсээр дүүрээгүй эсвэл Ариун Сүнсээр хангалттай дүүрч амжаагүй** гэсэн үг юм. Тэрээр тэдэнтэй “Христ доторх балчир хүүхэд” адил ярих хэрэгтэй байв. Энэ нь тэднийг байх ёстой итгэлээр өсөж чадаагүйг харуулдаг. Тухайн хүн Библийн асар их мэдлэгтэй боловч сүнслэгээр өсөх хэрэгтэй. Энэ нь тэднийг байх ёстой итгэлээ дүүрэн амьдрал болон бүрэн дүүрнээр Есүст өөрийгөө зориулахыг шаарддаг.

Махан биеийн дагуух Христэд итгэгчид байнга хичээвч сүнслэг амьдралдаа зорилгогүй, урам хугарсан мөн сэтгэл хангалуун бус байдлыг мэдэрч байдаг. Зарим махан биеийн итгэгч нар энэ нөхцөл байдалдаа сэтгэл хангалуун үлддэг. Магадгүй тэд өөртөө “Бид зүгээр л нүгэлтнүүд! Бидний хийж чадах юм байхгүй! гэж хэлж болох юм.

Мөн зарим махан биеийн итгэгчид үүндээ баяр хөөртэй ч байж болно. Тэд Библийн үнэнийг мэддэгтээ баяртай байдаг. Махан биеийн гишүүд маш идэвхтэй бөгөөд сүмийнхээ удирдлагын дунд ч байж болно. Тэд Бурханы төлөө ихийг хийж байгаа харагддаг байж ч болно.

Матай 7:22-23: “Тэр өдөр Надад олон хүн “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?” гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ!”

Есүс тэднийг танихгүй гэж хэлсэн. Яагаад юм бол? Учир нь тэд Есүстэй жинхэнэ биш хуурамч харилцаатай байжээ. Мөн чин сэтгэл эсвэл үйлдэл байгаагүй. Ариун Сүнсээр дамжин Есүс тэдний зүрх сэтгэлд нэвтрэн орж чадаагүй ажээ. Тэд Есүстэй хувийн харилцаагүй байв. “Тэгэхээр тэд Есүстэй өнгөцхөн харилцаатай байсан гэсэн үг.”¹³ Хэзээ Христ бидний дотор байдаггүй вэ? Миний бие энэ талаар их чухал зүйл олж уншсан юм. Өмнө нь миний дурдсанаар хэрэв бид Ариун Сүнсэтэй амьдарч чадах аваас доорх зүйлээс ангид байж чадна:

“Сүсэг бишрэлээс үл хамааран хүний сүнс Христийн Сүнсний эсрэг Түүнийг үгүйсгэж байдаг. Хүмүүс Христийг бузар яриа, балмад үгс, худал яриа мөн харгис байдлаараа үгүйсгэдэг байж болох юм. Мөн тэд өнгөц тансаг амьдрал, нүгэлт таашаалаа дагаснаар Христийг үгүйсгэж болно.

“ *Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн.* ”

Тэд дэлхийтэй эвлэрч, эелдэг бус авирлаж, өөрсдийн бодлыг тэргүүнд тавьж, өөрсдийгөө зөвтгөж, эргэлзэж, асуудал үүсгэж мөн харанхуйд оршин байснаараа Христийг үгүйсгэж болох юм. **Энэ бүх замаараа тэд Христ өөрсдийнх нь дотор байхгүй гэдгийг харуулдаг.**¹⁴

Гэвч энэ нь Бурханы нигүүлслээр хурдан өөрчлөгдөж болно. Бид энэ талаар дахин гурав болон тавдугаар бүлэгт үзнэ.

Яагаад бид Бурханд бүх зүйлээрээ бууж өгч, амлалт өгөх нь чухал вэ?

Бурханы үгэнд: “Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн” хэмээн хэлсэн. Ром12:1.

“Бурхан биднийг [амин хувиа хичээх болон нүглийн хүлээснээс] чөлөөлж, эдгээхийг хүсдэг. Гэвч энэ нь төрөлх байдлаа бүхлээр нь шинэчлэн бүрэн өөрчлөгдөж, тэр чигээрээ Бурханд бууж өгөхийг шаарддаг.”¹⁵ Бидний амин хувиа хичээсэн байдал гомдож, хардах, уурлах, өс санах гэх мэт олон шинжээр илэрдэг. Бурхан биднийг энэхүү хандлагаас чөлөөлөхийг хүссээр байна.

14 Элен Уайт, Үе үеийн хүслэн (1898), х.357.2 - Das Leben Jesu, 349 [357]

15 Элен Уайт, Христэд хүрэх зам (1892), х. 43.2

“Тэрээр [Бурхан] биднийг Өөр лүү нь ирээсэй гэж хүсч байдаг бөгөөд хэрэв бид өөрсдийгөө Түүнд бүрэн өгч чадваас Бурхан бидний дотор ажиллах болно. Энэ нь бидэнд Бурханы хөвгүүдийн алдар хүндийг хуваалцах эсвэл нүглийн боолчлолд байх эсэх талаар сонголтыг үлдээдэг.”¹⁶

Бурхан бидний “Дахин төрөх” хэмээх гол чухал асуултанд хариулдаг. (Иохан 3:1-21). Үүний дараагаар даруу болон бүүж өгөх хэрэгтэй (Иохан 15:1-17). Бид үүний талаар гуравдугаар бүлэгт илүү үзэх болно.

Моррис Вендэн хэрхэн Бурханд амьдралаа даатгах талаар ийн өгүүлжээ:

“Ер нь хүн тодорхой зарим нэг зүйл дээр хэсэгчлэн буулт хийнэ гэж огт байхгүй. Зарим талаараа хэсэгчлэн бууж өгснөөс хугацаа нь болоогүй жирэмсэн эмэгтэй хүүхдээ төрүүлэх нь илүү хялбар юм. Ямартай ч дундыг сонгоно гэж байхгүй.”¹⁷

Өдөр бүр Эзэнд бууж өгөх талаар Элен Уайт:

Зөвхөн Христийн хамтрагч нар, зөвхөн Эзэн гэж дууддаг тэдгээр хүмүүс, надад байгаа бүхэн болон би өөрөө бүхлээрээ Таных гэж хэлдэг тэдгээр хүмүүс Бурханы охид хөвгүүд хэмээн хүлээн зөвшөөрөгдөх болно” гэж хэлжээ.¹⁸

Сүмд явдаг атлаа алдагдсан хүмүүс бий. Энэ нь ямар эмгэнэлтэй гээч! (Мөн энэ тухай арван ариун бүсгүйн сургаалт зүйрлэл болон Лаодикийн сүмд бичсэн захидалд өгүүлдэг)

Яагаад махан биеийн итгэгчдийг таньж мэдэхэд хэцүү вэ?

Мажан биеийн итгэгчийн амьдрал “шашнаар” дүүрсэнээс хойш тэрээр ихэвчлэн ямар нэгэн чухал зүйл байгаа гэдгийг ухаардаггүй. Энэ чухал зүйл нь Бурхантай харилцах авралын дотно харилцаа юм. Хэрэв бид Христээр бүхий л амьдралаа захируулахыг зөвшөөрөхгүй бол Тэрээр хаалга тогшин зогссоор л байдаг. (Илчлэлт 3:20). Мөн Тэрээр: Хэрэв бидэнд өөрчлөлт байхгүй бол Би чамайг амнаасаа нулимж гаргана гэж хэлсэн.

16 Элен Уайт, *Христэд хүрэх зам* (1892), х. 43.4

17 Морис Вендэн, *95 Итгэлээр зөтгөгддөг онол* (Pacific Press, 1987), х. 63

18 Элен Уайт, *Үе үеийн хүслэн*, х. 523

Библид үндэслэсэн хүчирхэг сургаалтай учраас бид хүчтэй итгэл үнэмшилтэй байдаг. (Мөн бид цаашид мэдлэгээ ахиулахыг хүсээр л байдаг) Бид үнэнийг мэддэг хэмээх итгэл үнэмшилтэй. Энэ нь ч биднийг баяр хөөртэй болгодог. Бид тал бүрийн мэдлэгтэй. Бид зөв зүйл хэлдэг. Энэ бүх зүйл л махан биеийн асуудлыг олж илрүүлэхэд маш хэцүү болгодог байна.

Нэгэн пасторын бичсэнээр: “Би 40 өдрийн залбирлын цуглаанд хамрагдаж байсан эмэгтэйгээс дөнгөж сая дуудлага хүлээн авлаа. (5-р бүлэгт 40 өдрийн залбирлын талаар илүү тодорхой дурдах болно.) Тэрээр хэлэхдээ, энэ ном түүний амьдралыг өөрчилсөн гэжээ. **Тэрээр амьдралынхаа туршид сүнслэг байдалд нь юу дутагдаж байгааг гайхдаг байсан бөгөөд одоо тэрээр Ариун Сүнсийг мэддэг болсон байна.** Та түүний гэрчлэлийг сонссон ч болоосой. Тэрээр амьдралдаа анх удаагаа Бурхантай харилцаатай байгаагаа анзаарсан гэж хэлсэн юм. ... Бусад хүмүүс ч мөн адил түүний амьдрал дахь өөрчлөлтийг аль хэдийнээ анзаарсан байна.”¹⁹ Хүмүүс ямар нэгэн зүйл дутагдаж байгаагаа анзаардаг боловч яг юу гэдгийг нь мэддэггүй. Маш олон хүн их зүйл хүсдэг ч яг юуг хайж эсвэл хэрхэн авахаа мэддэггүй.

1 Коринт 3:1-4-т “байсаар” гэсэн үгийг гурван удаа ашигласанд би их талархдаг. “*Та нар махбодынхоо дагуу байсаар байгаа.*” Энэ нь махбодын дагуу байгч хүн бүр сүнслэг болох боломжтой гэдгийг харуулж байна. Хэн ч махан биеийн дагуу хэвээр үлдэх шаардлагагүй. Тэрээр сүмд байгаа учраас үүнийгээ ухаарч, өөрчлөх сайхан боломж байгаа. Бид дараа нь хэрхэн сүнслэг болох талаар ярилцах болно.

Анхаарал хандуулах өөр нэг зүйл бол атаархал, маргаан юм: “*Та нарын дунд атаа жетөө болон хэрүүл маргаан байна.*” Энэхүү зан чанар нь Паулд махан биеийн дагуу гишүүдийг Бурханы Сүнсээр бус харин бусад хүмүүс шиг махбодын хүслээр үйлдэж байгааг баталж өгдөг. Тэд яг л төрөлх хүн мэт үйлдэл гаргадаг; шашны үйл ажиллагаан дээр ч мөн адил. Тэгэхээр сүмд болж буй асуудлын ихэнх нь махан биеийн дагуу байгч гишүүдээс үүдэлтэй гэсэн үг үү? (Иуда 19) Есүсийн цаг үед Фарисайчууд болон Садукайчууд нэг нэгэнтэйгээ өрсөлдөж байгаагүй гэж үү? Энэ нь аль дээр үед л хуучинсаг үзэл болон либерал (эвлэрэнгүй) үзэлтэнгүүдийн дунд хурцадмал асуудал байсан гэсэн үг юм. Нэг бүлэг нь аливаа зүйлд хэт ягшмал нөгөөх нь сул ханддаг байна. Гэхдээ аль аль нь өөрсдийгөө Библийн заавар болон үнэний дагуу явж байна гэж боддог. Гэвч Есүс хоёр бүлгийг хоёуланг нь махбодын дагуу буюу Ариун Сүнсээр дүүрээгүй хэмээн хэлжээ. Өнөөдөр ч мөн адил ийм зүйл байх боломжтой. Хуучинсаг итгэгчид ч махан биеийн итгэгчид байж болно.

19 2012 оны 2 сарын 15-нд Х.Хаубэйлд ирсэн имэйл

Харамсалтай нь хүмүүс хуучинсаг эсвэл либерал (эвлэрэнгүй) байдлын нүдний шилээр ихэвчлэн харж байна.” Хэдийгээр “Махан биеийн эсвэл Сүнслэг” гэсэн Библийн ангилал байгаа ч бид сүнслэг зүйлсийг мөшгөхөөр дуудагдсан. Бид үүнийг өөрсдийн сайн сайхны төлөө хийх хэрэгтэй. Бурхан Галат 6:7-8-д бидэнд маш тодорхой хэлсэн зүйлийг уншаарай:

“... Юу гэвэл хүн юу тарьснаа л хурааж авдаг. Яагаад гэвэл өөрийнхөө махан биед таригч нь махан биеэсээ ялзралыг хурааж авна. Харин Сүнсэнд таригч нь Сүнснээс мөнх амийг хурааж авна.”

Махан биеийн хүн Есүсийг дагаж, Түүнд таалагдахыг хүсдэг боловч бүхий л талаараа бүрэн бууж өгдөггүй. Хэрэв бууж өгвөл ямар нэг байдлаар эргэж буцдаг. (Галат 3:3; Илч. 2:4-5) Энэ нь тэрээр нэгэн зэрэг өөрийн хүсэл болон Бурханы хүслийн дагуу амьдрахыг хүсдэг гэсэн үг юм. Гэвч энэ нь огт бүтэхгүй. Эцэст нь тэрээр өөрийнхөө амьдралыг гартаа авдаг. Өөрөөр хэлбэл түүнд хоёр сэтгэл оршиж байна. Иймэрхүү тохиолдолд Бурхан Ариун Сүнсээ илгээх болов уу? Иаков 4:3-т энэ асуултанд хариулдаг: “Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулья хэмээн буруу хандлагаар гуйдаг байна.” Би үүнийг махан биеийн хандлагаар гуйдаг гэж үздэг. Иймэрхүү хүсэлтэд хариу өгөх нь зөвхөн амин хувиа хичээсэн үзлийг хөөргөн дэвэргэнэ. Тиймээс энэ төрлийн гишүүд нь энгийн хүний хүч, чадваруудаар амьдардаг. Илчлэлт 3:16-д ийм хүмүүсийг “бүлээн” мөн Матай 25-д “мунхаг” гэжээ.

Яагаад Есүс махан биеийн итгэгчдийг бүлээн гэсэн юм бол?

Яагаад маш олон итгэгч Ариун Сүнсээр дутагдаж байдаг вэ? Энэ асуултанд хариулахаас өмнө эхлээд Лаодикт болсон зүйлийг харцгаая. Есүс яагаад Лаодик дахь чуулганы гишүүдийг бүлээн гэж дуудсан вэ? Тэрээр бидэнд маш тодорхой чиглэл өгсөн: “Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна.” (Илч. 3:20) Есүс тэдгээр итгэгчдийн амьдралын төвд биш харин гадна талд нь байжээ. Тэрээр гадаа хаалганы өмнө зогсож байв. Тэр яагаад дотогш ороогүй юм бол? Яагаад гэвэл Түүнийг уриагүй юм. Есүс дотогшоо орох гэж хүчилдэггүй. Учир нь Тэрээр бидний чөлөөт сонголтыг хүндэлдэг.

Яагаад итгэгчид Есүсийг хаалганы гадна үлдээсэн юм бол? Үүнд олон учир шалтгаан бий. Зарим нь Никодем шиг сүнслэг амьдралдаа дан ганц оюун ухаанаараа болон танин мэдэхүйн мэдрэмжээрээ ханддаг төдийгүй Христэд итгэх итгэлийн амьдрал чухам ямар болохыг ойлгож амжаагүй. (Иохан 3:1-10-тай харьцуулаарай). Харин зарим нь баян залуу удирдагч

шиг маш ихийг гаргах хэрэгтэй учир дагалдагч байх үнэ цэнэ дэндүү их гэж үздэг (Матай 19:16-24-тэй харьцуулаарай). Харин бусад нь Есүсийг дагах нь өөрийгөө үгүйсгэхийг, амьдралаа өөрчлөхийг (Матай 16:24-25-тай харьцуулаарай) мөн Бурханд бүхий л талаараа бууж өгөхийг шаарддаг гэж үзнэ (Ром 12:1). Тэд Түүнтэй нөхөрлөх хангалттай цаг гаргадаггүй, цэвэр хайнга байдлаас болж Есүсийг гадна орхидог.

Би дахин давтъя: Илчлэлт 3:20 дээрх бүлээн байдлын шалтгаан нь: *“Харагтун, Би хаалганы дэргэд зогсож байна.”* Есүс тэдний амьдралын төвд биш харин гадна эсвэл хажуу талд нь байдаг. Бүлээн байдал нь Христтэй харилцах хувийн харилцаанаас шууд хамаардаг.

Жишээ нь: Ажил хэрэгтээ илүү их санаа тавин хөрөнгө оруулдаг залуу байж болно. Тэрээр харин эхнэрээ үл хайхардаг. Тэр ажилдаа амжилттай байх боловч гэр бүлийнх нь харилцаа бүлээн байна. Аливаа хүн идэвхтэй сүмийн гишүүн, хичээнгүй сүмийн удирдагч, пастор эсвэл ерөнхийлөгч байж болох ч Христтэй бүлээн харилцаатай байх боломжтой. Тухайн хүн маш их ажил хэргийг хийж гүйцэтгэхэд өөрийгөө зориулсан ч Христтэй харилцах хувийн харилцаагаа үл хайхарч болно. **Есүс энэ бүлээн байдлыг арилгахыг хүсдэг.** Аливаа хүн Бурханы ажлыг хийгээд (сүм ба чуулганы) тун завгүй атлаа энэ бүхний ЭЗЭНийг нь үл хайхардаг нь эмгэнэл юм.

АРВАН АРИУН БҮСГҮЙН СУРГААЛТ ЗҮЙРЛЭЛ

Арван ариун бүсгүйн талаарх Есүсийн сургаалт зүйрлэл нь сүнслэг болон махан биеийн итгэгчдийг хэрхэн ялгах талаар өгүүлдэг:

- ▶ Арвуулаа онгон байсан
- ▶ Бүгд Библийн итгэл үнэмшилтэй байсан
- ▶ Бүгд дэнлүүтэй байсан
- ▶ Бүгд Библитэй байсан
- ▶ Бүгд шинэ хүргэнтэй уулзахаар ирсэн
- ▶ Бүгд дахин ирэлтийг хүлээж байсан
- ▶ Бүгд нойрмоглож унтсан
- ▶ Бүгд чимээ сонсоод сэрсэн
- ▶ Бүгд дэнлүүгээ бэлтгэсэн байсан
- ▶ Бүгдийнх нь дэнлүүнүүд асаж байсан
- ▶ Тэдний тал нь дэнлүү унтрах гэж буйг анзаарсан

Бүгд дэнлүүгээ бэлтгэсэн бөгөөд бүгдийнх нь **дэнлүү асаж байв: Гэхдээ асаж буй дэнлүүнд тос хэрэгтэй. Гэрлийн эх үүсвэр хүч нь дууссан.** Хэсэг хугацааны дараа тэдний тав нь **дэнлүү унтарч буйг анзаарсан.** Мунхаг бүсгүйчүүдийн дэнлүү хэсэг хугацаанд асдаг нь тэдэнд Ариун Сүнс тодорхой хэмжээгээр байгааг харуулж байна. Гэвч тос хангалттай байсангүй. Маш бага байлаа. **Ганцхан ялгаа нь энэ байсан юм.**

Өнөөх таван бүсгүй ирж, биднийг оруулаач хэмээн гуйхад Есүс **“Би та нарыг танихгүй”** гэж хариулдаг. Тэд Ариун Сүнс буюу тосноос хочорсон байлаа. Тэгээд хаалга хаагдав.

Есүсийн бидэнд хэлэх гэсэн санаа нь Бурхантай харилцах харилцаа нь Ариун Сүнстэй хамааралтай зүйл гэдгийг ойлгуулахыг хичээсэн. Ариун Сүнсээр удирдуулдаггүй хэнийг ч боловч Есүс хүлээн зөвшөөрөхгүй. Ром 8:8-9: **“Махан бие дотор байгсад Бурханд таашаагдаж чадахгүй. ... Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш”** гэж хэлдэг.

Бид зөвхөн Ариун Сүнсээр дамжуулан Есүстэй жинхэнэ харилцаатай байж чадна. 1 Иохан 3:24 **“Түүний тушаалуудыг сахигч нь Түүний дотор байж, Тэр түүний дотор байна. Бидний дотор Тэр байгааг Түүний бидэнд өгсөн Сүнсээр дамжуулан бид мэддэг”** гэж хэлдэг. Ариун Сүнсээр дүүрсэн гэдэг баталгаа бол би өөрөө Есүсийн дотор Тэр миний дотор байна гэсэн баталгаа юм.

Энэ бол 40 өдрийн залбиралд хамрагдсан эмэгтэйн ойлгож мэдэрсэн зүйл юм. Тэрээр Ариун Сүнсний оршихуйгаар Бурхантай харилцах

харилцаагаа маш өөр арга замаар мэдэрсэн бөгөөд бусад хүмүүс ч түүний амьдрал дахь өөрчлөлтүүдийг анзаарсан байна. Өмнөд Германы нэгэн эмэгтэй энэхүү номыг судалсныхаа дараа ингэж бичсэн байна: Деннис Смитийн “Дахин ирэлтэд бэлтгэх мөргөл, залбирлын 40 өдөр” болон энэхүү товхимол хоёр миний амьдралд удаан хүлээсэн гайхалтай ивээл болсон юм. Манай сүмийн маш олон ахан дүүс болон гишүүдийн итгэлийн амьдралд ямар нэгэн зүйл үргэлж дутагддаг. Харин одоо Есүс бидний амьдралд орж ирээд өөрчилдөг хэмээх таатай мэдээ байна. Тэрээр бидэнтэй ажилласаар байгаа бөгөөд алхам алхмаар Өөртөө ойртуулдаг.”²⁰

Нэгэн залуугийн сэтгэгдэл: *Хувийн сүнслэг сэргэлтийн алхам* хэмээх энэ ном миний сэтгэлд маш гүн хүрсэн юм. Ялангуяа арван ариун бүсгүйн сургаалт зүйрлэл болон Ром 8:9 дээрх “Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш” хэмээх энэ хэсэг ихэд хүрсэн. Энэхүү ишлэл намайг цохилтонд оруулж билээ. Гэнэт, надад Ариун Сүнс байгаа эсэх талаар эргэлзээ төрж эхлэв. Учир нь би амьдралдаа зохистой “Үр жимсийг” эрж хайж байсан юм. Ингээд Шаббатын дараа номоо унших үед хязгааргүй их гүниг намайг бүрхэж билээ. Тэгээд би 98 дугаар хуудасны залбирлыг хэлэхэд, Ариун Сүнс буун ирж, Бурхан Эцэгийн хүслийн дагуу зүрх сэтгэлээ өөрчлүүлэх чин хүсэл надад бий болов. ... Сэтгэлийг минь маш их хөдөлгөсөн таны энэ номонд маш их талархаж байна.” А.Р

Махан биеийн итгэгчдийн хамгийн эмгэнэлтэй зүйл бол тэд энэ нөхцөл байдлаа өөрчлөхгүй бол мөнхийн амьдралыг өвлөж авахгүй. Ром. 8:9: “Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш.”

Одоо дүгнэе: Сүнслэг болон махан биеийн итгэгчдийн гол ялгаа бол Ариун Сүнс юм. Сүнслэг итгэгчид Ариун Сүнсээр дүүрэн байдаг. Харин махан биеийн итгэгчдэд огт үгүй эсвэл хангалттай дүүрээгүй.

Та өөрийгөө махан биеийн итгэгч гэдгээ олж мэдэв үү? Тэгвэл бүү гонсоогоорой. Бурхан танд анагаах арга санал болгож байна. Энэ бол Ариун Сүнс юм.

Зарим тохиолдолд Ариун Сүнсийг илүүтэй онцолж анхаарч байхад заримдаа Ариун Сүнсийг үл хайхардаг. Эзэн Бурхан биднийг Библийн арга замаар удирдах болтугай.

ХАРЬЦУУЛАЛТ: ЭРТНИЙ БОЛОН ДЭЛХИЙН ТӨГСГӨЛИЙН ҮЕИЙН СҮМҮҮД

Эртний болон одоогийн сүмийг харьцуулахад, эртний сүмүүд сүнслэг хүмүүсээр давамгайлж байсныг харах боломжтой. Үйлс номноо тэдний хурдан, эерэг хөгжлийн шалтгаан нь сүнслэг хүмүүс байсныг ч илтгэдэг. Тэдэнд өөр тусламж байсангүй. Тэдэнд Ариун Сүнс л байлаа. Бидэнд хамгийн шилдэг тусламж байгаа ч бид Ариун Сүнсээр дутагдсаар хомсдолд орсоор байна.

А. В. Тозерийн юу гэж хэлснийг санаарай: “Хэрэв өнөөдөр манай сүмээс Ариун Сүнс явсан бол бидний хийж буй зүйлийн 95%-г хэн ч анзаарахгүй. Хэрэв эртний сүмд Ариун Сүнс байгаагүй бол тэдний хийж байсан зүйлийн 95% нь (энэ бараг бүгд гэсэн үг) зогсож, ямар ч үр дүнгүй байгааг хүмүүс анзаарах байсан.”²¹

Бид Ариун Сүнсгүйгээр аливааг хийж чадна гэж үү? Өнөөгийн сүм чуулганууд ихэнхдээ махан биеийн итгэгчдээс бүрддэг юм бол уу?

Гэвч бид ихэвчлэн хүчин мөхөсдөж, бүх талаараа ялагддаг. Махан биеийн хандлага нь сул дорой сүм чуулган оршин байгаагийн шалтгаан гэж үү? Маш олон ноцтой асуудлууд махан биеийн хандлагаас үүсэн бий болдог юм бол уу? Цаашид бидний хувийн болон бусад асуудлын гол нь Ариун Сүнсний дутмаг байдал гэдэг талаар илүү их судлах болно. Гэхдээ бид өөрт тохиож буй хувийн асуудлаа Бурханы тусламжтайгаар даруй өөрчилж чадна.

Жоханнес Магер ийн хэлжээ: “Паул сүнслэг болон махан биеийн, Ариун Сүнсээр дүүрсэн эсвэл Ариун Сүнсэнд орон зай өгдөггүй тэдгээр хүмүүсийн хоорондын ялгааг гаргажээ. Тэд Ариун Сүнсээр баптисм хүртсэн боловч Ариун Сүнсээр дүүрээгүй ажээ.

Би шашин судлалаар сурч, Библийн утга санааг сайн ойлгож, үүнийгээ амьдралдаа үлгэр жишээ болгон харуулж, Библийн агуу үнэнийг хүлээн авч, зуун дамжин ирсэн теологийн ягшмал ойлголтуудыг сайн мэддэг мөн ойлгомжтой бодит номлол хийдэг ч Ариун Сүнс байхгүй байж болно. Ном, боловсрол, техникийн дэвшилтэт багаж хэрэгслүүд мөн сэтгэл татах зүйлс зэрэг нь дутагдаж буй сүнслэг амьдралыг орлож болох юм.

Номлох, олон нийтийн дунд залбирах, сүм чуулган зохион байгуулах, баярт мэдээнд бэлтгэх, пасторын зөвлөгөө өгөх гэх мэт үйлс нь Ариун Сүнсгүйгээр явагдаж болно. Элен Уайт энэхүү болзошгүй аюулыг ийн

21 Др. С. Жозеф Киддер, *Anleitung zum geistlichen Leben* (Andrews University), PPP Folie 2

дүрсэлжээ: “Бурханы Сүнс маш бага илэрдэг шалтгаан нь үйлчлэлүүдээ Ариун Сүнсгүйгээр хийж сурсан явдал юм.” (Элен Уайт, Сүмүүдэд өгөх гэрчлэл, 1 дүгээр боть, (1868), х. 383.1)

Жоханнес Магер пастор байсан төдийгүй олон жил шашин судлалын професор, сайн мэдээ түгээгч байв. Тэрээр Швейцарын Бернд Евро-Африкийн бүсийн үйлчлэлийн хэлтсийн нарийн бичгийн дарга хийж байсан байна. Одоогоор тэтгэвэртээ гараад Германы Фрэйденсауд амьдардаг.²²

Дүгнэлт: Махан биеийн дагуу байна гэдэг нь хангалттай эсвэл огт Ариун Сүнсгүйгээр энгийн хүний хүч, чадвараар амьдарч байна гэсэн үг юм.

МАХАН БИЕЙН ХРИСТЭД ИТГЭГЧДИЙН ГОЛ БЭРХШЭЭЛ

Библийн агуу ёс суртахуун болох дайснаа хайрлах, хүмүүсийг бүхий л зүйл дээр уучлах, гэм нүглээ ялах гэх мэт олон зүйл нь хүний хүч чармайлтаар бус зөвхөн Ариун Сүнсний хүч чадлаар бий болдог зүйлс юм. Махан биеийн Христэд итгэгчдийн гол асуудал нь гагцхүү хүний хүчинд суурилсан амьдрал юм. Бид Бурханы хүслийг дан өөрсдийн хүчээр хийж чадахгүй. Энэ сэдэвтэй холбоотой Библийн хэдэн ишлэл уншицгаая:

Исаиа 64:6: “Бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт байдаг.”

Иеремиа 13:23: “Етиоп хүн арьсаа, ирвэс толбоо өөрчилж чадах уу? Мууг үйлдэж зүршсан чи ч бас сайныг үйлдэж чадна.”

Езекиел 36:26-27: “Түүнээс гадна, Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна. Би та нарын махан биеэс чулуун зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө. Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно.”

Ром 8:7: “Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хуульд **захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй.**”

22 Жоханнес Магер, Auf den Spuren des Heiligen Geistes (Following the Steps of the Holy Ghost), (Lüneberg, 1999), pages 102-103.

Элен Уайт үүнийг маш тодорхой хэлж өгсөн байна:

“Хэн нэгэн хуулийг сахиж, өөрийн үйлсээрээ диваажинд очихыг оролдож байгаа бол тэрээр боломжгүйг мөшгөж байна. Хүний дуулгаваргүй байдал, **түүний үйлс авралд хүргэж чадахгүй. Харин Христ түүний дотор ажиллаж сайн сайхныг бий болгодог.**”²³

Миний бодлоор Ариун Сүнсгүйгээр Бурханы хүслийг биелүүлэх боломжгүй гэдгийг эдгээр жишээнүүд хангалттай харуулж байна. Бидний гол асуудал бол үргэлж Бурханы хүслийн дагуу шийдвэр гаргах хэрэгтэй хэдий ч Бурхан энэ бүхнийг хийж гүйцэтгэх хүчийг өгдөг юм. Итгэлээр энэхүү зөвт зарчмыг ойлгох нь туйлын чухал бөгөөд эрх чөлөөг олгодог.

ХЭН НЭГЭН ӨӨРИЙН ХЭРЭЭС ХЭТЭРСЭН ЗҮЙЛИЙГ ХИЙХ ГЭЖ ОРОЛДОХ ҮЕД ЮУ БОЛДОГ ВЭ?

Өөрийн хүчээр хийж чадахгүйгээ ухаарах үед ихэвчлэн юу болдог вэ? Би үүнийг хийж чадахгүй юм байна! Дахиад л бүтэлгүйтчихлээ! Тэгээд бид урам хугардаг.

Энэхүү асуудал нь ахмад хүмүүсээс илүүтэйгээр залуучуудад их тохиолддог гэж би бодож байна. Ахмад хүмүүс ажил, сүргүүл мөн гэр бүлийн асуудалд илүү тэвчээртэй байдаг. Тэд урам хугарах, сэтгэл гонсойсон зүйлс тохиолдох үед залуус шиг амархан уурлаж бухимддаггүй. Гэвч хөгшин залуу ялгаагүй бүгдэд асуудал тулгардаг. Гэхдээ залуучууд үүнийг илүү тод олж хардаг. Итгэлийн замаар өөрийн хүчээр алхана гэдэг бол махан биеийн итгэгчдийн хувьд нэн түрүүний чухал асуудал юм.

Бид энэ асуудлыг хэрхэн шийдэж болох вэ? Хэн нэгэн магадгүй Бурханы тусламжийг эрчимтэй залбиран гуйж, маш их хичээх шийдвэр гаргаж болох юм. Өөр зарим нь өөрсдийгөө хэт өчүүхэн ухаантай байж болохгүй хэмээн шүүмжилж болно. Мөн зарим нь магадгүй итгэлээ бүрэн орхиж, үүндээ сэтгэл хангалуун байж болох юм. Гэвч эдгээр өнгөц шийдэл нь хуурмаг шийдлүүд бөгөөд үр дагаврууд нь даруй ирдэг. Зөв арга зам нь гэвэл Бурханы хуулийг чин сэтгэлээсээ нухацтай авч үзэх юм. Учир нь хуулийг бидний сайн сайхны төлөө өгсөн юм. Тиймээс бидэнд Бурханы хүч хэрэгтэй. Зөв арга зам бол баяр хөөр, урам зориг, хүч чадал, үр жимс, ялалт амжилтаар дүүрэн Ариун Сүнтэй хамт амьдрах явдал юм.

23 Элен Уайт, *Review and Herald*, July 1, 1890

ГОЛ АСУУДАЛ

Энэ нь ихэвчлэн махан биеийн итгэгчдийн асуудал гэдгийг ойлгож мэдлээ. Есүс яагаад бүлээн дагалдагчдыг хүсдэггүй нь тодорхой харагдаж байна уу? Бурханы бидэнд хүсдэг шиг тийм бялхам дүүрэн амьдрал тэдэнд байдаггүй бөгөөд бусдад муу үлгэр дуурайл болдог гэдгээ ихэнх нь мэддэггүй. Энэ асуудал бидний бодож байгаагаас илүү ноцтой. “Хагас зүрхтэй Христэд итгэгчид шашингүй үзэлтнүүдээс дор юм: Тэдний хуурамч үгс, хариуцлагагүй байдал маш ихээр төөрөгдүүлдэг.”²⁴

Артүр Ж. Даниелсийн бичсэн *Христ бидний зөвт байдал* хэмээх номонд: “Хэт албархуу, шашны хатуу дэг нь хамгийн хуурмаг мөн хор хөнөөлтэй зүйл юм. Энэ нь зуун зуун дамжин сүмүүдийг нурааж буй үл үзэгдэх, санаанд оромгүй саад тотгор юм. Паул Бурханы хүчгүй мухар сүсэг нь сүүлчийн өдрүүдийн нэг аюул байх болно хэмээн сануулсан. Мөн хуурмаг болон увидас, ид шидийн зүйлсээс болгоомжлохыг анхааруулсан байдаг.”²⁵

Махан биеийн Христэд итгэгч болоход нөлөөлж буй хүчин зүйлс

Дараах хүчин зүйлс болон шалтгаанууд махан биеийн Христэд итгэгч болоход нөлөөлдөг:

- 1. Үл хайхрах** – Бид “Ариун Сүнстэй амьдрал” хэмээх энэ зүйлд өөрсдийгөө хангалттай зориулаагүй эсвэл амьдралдаа хэрэгжүүлэх аргаа олоогүй гэсэн үг юм.
- 2. Үл итгэх эсвэл өчүүхэн итгэлтэй байх** – Ариун Сүнсээр дүүрсэн байна гэдэг нь бүхий л талаараа Есүс Христэд бууж өгөхийг шаарддаг. Энэ мөн адил үл хайхрахаас шалтгаалж болно. Магадгүй Эзэн бидний хүсдэгээс өөрөөр биднийг чиглүүлэх вий гэж айснаас ч болж болох юм. Энэ нь Бурханы хайр болон мэргэн ухаанд хангалттай итгэхгүй байна гэсэн үг юм.
- 3. Буруу ойлголт** – Тухайн хүн бодит байдал дээр Ариун Сүнсээр дүүрээгүй атлаа өөрийгөө Ариун Сүнсээр дүүрсэн гэж боддог. Энэ асуудал маш элбэг тохиолдож буй нь харагддаг.

24 Элен Уайт, Захидал 44, 1903, Библийн тайлбар, боть.7, х.963
Илчлэлт 3:15-16

25 Артүр Ж. Даниелс, Христ бидний зөвт байдал, х. 30, - Christus unsere Gerechtigkeit (Hamburg 1962), S.20

4. Их завгүй байх –Христтэй харилцах харилцаандаа хангалттай цаг байхгүй эсвэл бүр огт завгүй гэж өөрсдийгөө боддог хүмүүс. Эсвэл тэд цаг гаргадаг ч Бурхантай холбоотой байх тал дээр ямар ч хичээл зүтгэл гаргадаггүй.

5. Нуугдмал гэм нүглүүд. Гэм нүглээ хүлээн зөвшөөрөхгүй байх нь Бурханы хүчийг мэдрэхгүй байх нэг шалтгаан юм.

6. Ихэвчлэн өөрсдийн хүсэл мэдрэмжээ дагадаг. Бурхан “Зөвт хүн итгэлээр амьдардаг” хэмээн хэлсэн байдаг. Би Бурханд итгэж шийдвэр гаргаж байна уу эсвэл өөрийн мэдрэмжинд тулгуурлан шийдвэр гаргаж байна уу? Рожер Морнеагийн бичсэн илэрхийлэл нь миний сэтгэлийг ихэд татсан юм. “Бузар сүнснүүд Бурханы эш үзүүлэгчид болон Христийн үгийг сонсохын оронд өөрсдийн мэдрэмжээ сонсохыг хүмүүст уриалдаг. Тэдгээр сүнснүүд юу болж байгааг ухааруулалгүй хүмүүсийн амьдралыг хяналтандаа авдаг нь тодорхой юм.”²⁶

Ариун Сүнсээр аль хэдийн дүүрсэн атлаа яагаад Ариун Сүнсийг гуйх ёстой бэ?

Нэг талаас харвал Ариун Сүнс бидэнтэй хамт байхаар өгөгдсөн. Нөгөө талаас авч үзвэл, бид итгэлээрээ Ариун Сүнсийг гуйсаар байх хэрэгтэй. Энэхүү илэрхий хоёр эрс тэсийг хэрхэн ойлгох вэ?

Иохан 14:17-д Есүс ингэж хэлжээ: “Тэр (Ариун Сүнс) та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна.” Үйлс 2:38-д: “Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно.”

Мөн Есүс залбирлын талаар заахдаа, Лук 11: 9-13-т “... Тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв!” Ефес 5:18-д: “... Сүнсээр дүүрэн бай.” гэж хэлдэг. Анхны Грек хувилбарт ч мөн адил үргэлжлүүлэн гуйсаар бай гэсэн байдаг.”

26 Рожер Морнеа, A Trip into the Supernatural, Review and Herald 1982, p. 43

Шийдэл:

Элен Уайт ийн хэлжээ: “Сүнсний ажил үйлс нь Бурханы үгстэй үргэлж зохицож байдаг. Тэрээр дэлхий болон сүнслэг ертөнцийн аль алинтай нь зохицдог. Дэлхийн амьдрал нь бурханлаг хүчний тусламжтайгаар үргэлжилж байдаг боловч энэ нь шууд гайхамшгаар биш харин ивээлээр тэтгэгдэн оршдог. Хэрэв Христийн дагалдагчид төгс нэгэн болтлоо өсөж, Христийн дүүрэн байдлын хэмжүүр (Ефес 4:13) хүртлээ өсөхийг хүсвэл тэрээр авралын үс ууж, амийн талхийг идэх ёстой. Тэрээр бүх зүйл дээр Бурханы үг, зааварт анхаарлаа хандуулан, залбирч амьдрах ёстой.”²⁷

Бид төрөхдөө амь амьдрал хүлээн авдаг. Энэхүү амьдралыг тэтгэхийн тулд бид идэж, ууж мөн дасгал хөдөлгөөн гэх мэт зүйлс хийх хэрэгтэй. Бидний сүнслэг амьдрал яг адил юм. Бид усан баталгаагаар дамжуулан Ариун Сүнсийг хүлээн авч дахин төрсөн. Тиймээс энэхүү сүнслэг амьдрал нь бидний дотор бүх л амьдралын минь туршид үлддэг. Энэхүү сүнслэг амийг тэтгэхийн тулд Бурханаас хангаж өгдөг Ариун Сүнс, Бурханы үгс, залбирал, бидний гэрчлэл гэх мэт сүнслэг зүйлсийг зайлшгүй ашиглах ёстой.

Иохан 15:4–т Есүс ийн хэлжээ: “Хэн Миний дотор байна Би түүний дотор байна.” Элен Уайт: “Христ дотор байна гэдэг нь Түүний Сүнсийг тасралтгүй хүлээн авч, Түүний төлөө бүхий л зүрх сэтгэлээрээ бууж өгсөн амьдрал юм” гэж тайлбарлажээ.²⁸

Тийм л учраас бид өглөө бүр бүх зүйлээрээ Эзэний өмнө өөрсдийгөө даруу болгож, итгэлээрээ Ариун Сүнсийг өдөр бүр гүйх хэрэгтэй юм.

БИ АЛЬ ТАЛД НЬ БАЙНА БЭ ?

Одоо хамгийн чухал зүйл гэвэл өөрийгөө ямар бүлэгт байгаагаа олж харах явдал юм. Би хаана нь байна вэ?

Ээжийг маань 20 настай байхад нь нэгэн залуугийн асуусан асуултад итгэл бишрэлийн талаар огт сонирхдоггүй хэмээн хариулсан гэдэг. Тэр залуу “Хэрэв та өнөө шөнө нас барвал яах вэ?” хэмээн эргүүлээд асуусан нь ээжид минь маш хүнд туссан байна. Гэхдээ маш эерэгээр нөлөөлсөн юм. Ээжийг минь Есүс болон сүмийн талаар шийдвэр гаргахад нөлөөлжээ. Магадгүй энэ асуулт танд ч мөн тусалж болох юм:

*Өнөөдөр та нас ... барлаа гэж бодъё...! (зүрхний шигдээс? осол?)
Танд Есүстэй хамт мөнхөд амьдрах баталгаа байна уу?
Тодорхой хариулт өгөөрэй.*

27 Элен Уайт, *Элч нарын үйлс* (1911), х. 284.2

28 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 676.2

Түгшүүрийн Дохио

Энэхүү асуудал ямар чухал болохыг ойлгож эхэлснээсээ хойш би маш их түгшив. Би энэ хэсгийг үнэхээр нэмж бичих эсэх талаараа бодож, залбирсан юм. Энэ нь бидний одоогийн болон ирээдүйн мөнх амьдрал мөн гэр бүл, сүм чуулган, ажил албатай холбоотой чухал асуудал билээ. Би өөрөө тусламж авсан учраас бусад хүмүүсийн асуудалд тусалмаар байна. Махан биеийн бүх хүн үүнийг ухамсарлах нь маш чухал юм: Өөрөөр хэлбэл тэд Бурханы тусламжгүйгээр өөрчлөгдөж чадахгүй. Ариун Сүнсний тусламжтайгаар Есүс Христтэй харилцаатай болж энэхүү ойр дотно харилцаагаар дамжуулан Бурхан биднийг агуу хайраараа бялхам ихээр ивээхийг хүсдэг. Үүний үр дүнд хэмжээлшгүй их ивээлийг мэдрэх болно. Тэгээд хамгийн гайхалтай нь бид Бурханы тусламжтайгаар нөхцөл байдлыг маш хурдан залруулах боломжтой юм. (3, 5-р бүлгүүдэд дэлгэрэнгүй үзнэ).

Махан биеийн Христэд итгэгчдийн асуудлыг Библийн номноо янз бүрээр тайлбарладаг. Сүнслэг болон махан биеийн итгэгчдийн бүлгийн гишүүн бүр өөр өөрийн гэсэн анхаарах асуудалтай боловч ерөнхийдөө гол асуудал нь адил юм. Ялгаатай тодорхойлолтууд:

- ▶ **“Махан биеийн”** – Ром 8:1-17; 1 Коринт 3:1-4, Галат 5:16-21 мөн бусад бичвэрүүд бий.
- ▶ **“Мунхаг”** – Арван ариун бүсгүйн сургаалт зүйрлэл Матай. 25:1-13 “Мунхаг эмэгтэйгээр сүмийн байдлыг харуулдаг. Энэ нь мөн Лаодикийн нөхцөл байдлаар илэрдэг.”²⁹
- ▶ **“Бүлээн”** – Лаодикчуудад бичсэн захидал. Илчлэлт 3:14-21 “Би чамайг халуун эсвэл хүйтэн байгаасай гэж хүсч байна.” (Илчлэлт 3:15). Энэ гайхалтай биш гэж үү? Есүс хүйтнийг бүлээнээс дээр үзсэн. Тэрээр яагаад ингэж үзсэн юм бол? “Хагас зүрх сэтгэлтэй Христэд итгэгчид нь шашингүй хүмүүсээс ч дор юм. Учир нь тэдний хуурмаг үгс болон итгэлгүй үйлдэл нь олон төөрөгдөл рүү чиглүүлдэг. Шашингүй хүмүүс өөрсдийнхөө үнэн өнгө төрхийг илт харуулдаг. Харин бүлээн Христэд итгэгч аль алиныг нь мэхэлдэг. Тэрээр энэ дэлхийн сайн хүн байж ч чадахгүй. Мөн сайн Христ итгэгч ч байж чадахгүй. Сатан тэдгээр хүмүүсийг хэний ч хийж чадахааргүй тийм ажилд ашигладаг.”³⁰

29 Элен Уайт, *Review and Herald*, 1890 оны 8 сарын 19

30 Элен Уайт, *Захидал 44*, 1903, Долоо дахь өдрийн Адвентист Сүмийн Библийн тайлбараас иш татав. Боть.7, х. 963 Илчлэлт 3:15.16

- ▶ **“Дахин төрөөгүй”** – Иохан 3:1-21 “Шинэ төрөлт гэдэг бол энэ үед маш ховор тохиолдол. Энэ бол сүмүүдэд байдаг олон ээдрээтэй асуудлын гол шалтгаан юм. Маш олон, бүр дэндүү олон хүн Христийн нэрийг ариун бус, бузар байдлаар харуулж байна. Тэд баптисм хүртсэн боловч, амьдаараа бүлшлагдсан хүмүүс юм. Өөрсдийгөө бүрэн ялан дийлж үхүүлээгүй учраас тэд Христ дотор шинэ амьдрал руу босч чаддаггүй.”³¹
- ▶ **“Бурханлаг байдал”** – “Бурханлаг байдлын дүртэй боловч Бурханы хүчийг үгүйсгэдэг.” 2 Тимот 3:5 Артур Даниелс
“... Хэлбэрдэлт нь туйлын худал хуурмаг бөгөөд хор хөнөөлтэй зүйл юм. Энэ нь сүмийг олон зууны турш, олон удаа устгахаар заналхийлж байсан үл үзэгдэх, гэнэтийн хад юм. Энэ нь “Бурханлаг байдлын дүр төрх” юм гэж Паул бидэнд анхааруулжээ. (2 Тимот 3:5). Бурханы хүчгүй байх нь (Ариун Сүнсээр дүүрээгүй байх) сүүлчийн өдрүүдийн аюулуудын нэг юм. Амар хялбар байдлыг эрэлхийлсэн, өөрийгөө хуурч мэхлэх хандлагаас ангид байхыг бидэнд сануулдаг.”³²

Мөн Элен Уайтын хурц илэрхийлсэн ишлэлүүд ч бий:

- ▶ **Маш, маш цөөхөн**
“Нэгэн чухал байшингийн үүдэнд харуул зогсоод, орох гэж ирсэн хүн бүрээс та Ариун Сүнсийг хүлээн авсан уу? хэмээн асууж байна гэж зүүдэллээ.” Түүний гарт хэмжүүр байсан бөгөөд бүр маш цөөхөн хүн л байшин руу орох зөвшөөрөл авлаа.”³³
- ▶ **Хориос нэг нь ч бэлэн байгаагүй**
“Сүмийн бүртгэлд нэрс нь бичигдсэн хорин хүнээс нэг нь ч дэлхийн намтар түүхээ эцэслэх бэлтгэл хийхгүй, Бурхангүй, итгэл найдваргүй энэ дэлхийд амьдардаг гэм нүгэлтэн хэвээр байгааг цохон дурдмаар байна.”³⁴
- ▶ **Бид яагаад маш нойрмог байна вэ?**
“Яагаад Христийн цэргүүд унтаа, хайхрамжгүй байна вэ? Учир нь тэд Христтэй чин сэтгэлийн өчүүхэн харилцаатай бөгөөд Ариун Сүнсээр туйлын их хомсдсон байна.”³⁵

31 Элен Уайт, MS 148, 1897, *Долоо дахь өдрийн Адвентист Сүмийн Библийн тайлбараас* иш татав. Боть. 6, х. 1075.

32 А.Ж. Даниелс, *Христ бидний зөвт байдал*, х. 20

33 Э.Ж. Уайт, *Сонгомол захидал*, Боть. 1 (1958), х. 109.2

34 Э.Ж. Уайт, *Христэд итгэгчдийн үйлчлэл* (1925), р. 41.1

35 Э.Ж. Уайт, *Агуу тэмцэл* (1911), х. 507.3

► Том аюул

“Би дэлхийн амьдралын тодорхойгүй, түр зуурын байдалд итгэл найдвараа тавихгүй. Гэвч тэр бүр ойлгоод байж чадахгүй аймшигтай аюул байна. Тэр аюул нь Ариун Сүнсний дуу хоолойг сонсоход саад болж гэм нүгэлт байдлыг сонгох зам руу түлхдэг Нүглийн гол үндэс нь юу вэ? “Учир нь тэд Надад итгэдэггүй.”³⁶ (Иохан16:9) Есүст итгэж найдахын гол шинж тэмдэг бол бид өөрсдөө Түүнд бүрэн дүүрэн бууж өгөх явдал юм. Бүрэн бууж өгөх гэдэг нь бүх зүйлд Түүнийг дагах бидний хүсэл юм.

Бидний одоогийн болон мөнхийн амьдралын аз жаргал мөн сүм чуулган, гэр бүл, гэрлэлтийн харилцаанд нөлөөлөх чухал зүйл учраас энэхүү сэдвийг бичих шийдвэр гаргасан гэдгээ дахин хэлмээр байна.

Асуултууд бас дахин асуултууд

Хамгийн чухал асуулт бол та Ариун Сүнсээр дүүрсэн үү? Эсвэл амжаагүй байна уу? Хүн хэзээ Ариун Сүнсээр дүүрдэг вэ? Зайлшгүй хийх шаардлагатай ямар зүйл байдаг вэ? Ариун Сүнсээр дүүрэн амьдралын эерэг үр дүнгүүд нь юу вэ? Өөрийгөө Ариун Сүнсээр дүүрсэн хэмээн андуурч бодоход юу тохиолддог вэ?

Дохио өгч байгаад талархаарай

Сэргэлт шинэчлэлийн сэдэвт өөрсдийгөө зориулах боломж олгож байгаа Бурхан Эзэнд талархъя. Агуу гайхамшгийн Бурхан биднийг сэргээн шинэчлэхийн төлөө Ариун Сүнсийг байнга өгсөөр байгаа нь олон шалтгаантай гэж бодож байна. Доорхи зүйлс тэрхүү шалтгаан байж болох уу?

- Тэрээр бидний дутагдлыг арилгаж, Лаодикийнх шиг нөхцөл байдлаас гаргахыг хүсдэг.
- Тэрээр биднийг удахгүй болох Есүсийн хоёр дахь ирэлтэнд бэлтгэхийг хүсдэг.
- Тэрээр “Бурханы хуулиудыг болон Есүсийн гэрчлэлийг сахидаг” (Илчлэлт 12:17) мөн “Есүст итгэдэг” хүмүүсээр дамжуулан сүүлчийн өдрийн (Илчлэлт 18:1-2) талаар мэдүүлэхийг хүсдэг.

Махан биеийн итгэгч бүр хурдан хугацаанд сүнслэг итгэгч болох боломжтой учраас Эзэн Бурханд талархъя. Ариун Сүнстэй амьдардаг хэн боловч Христийн дотор бүрэн дүүрэн болж чадна. Энэ бол бидний дараагийн хийх ажил юм. Энэ бүлгийн төгсгөлд дахин нэг гэрчлэл оруулж байна.

³⁶ Элен Уайт, *Сонгомол захидал*, Боть. 1 (1958), х. 109.2

Шинэ урам зориг болон дотоод амар тайван

“Манай сүмийн нэг эмэгтэй надад “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” хэмээх энэхүү номыг өгсөн юм. Энэхүү номонд бичигдсэн зүйлс миний сэтгэлд их хүрч билээ. Би яг үүн шиг ямар нэгэн зүйл хайж байсан бөгөөд эцэст нь оллоо. Би сүнслэг амьдралаа цэгцэлж эхэлсэн бөгөөд нэгэн зүйлийг ухаарсан юм. Энэ нь өөрийгөө бүхлээр нь Есүст даатган бүүж өгөх явдал байв. Түүнээс хойш Бурхан Эзэн намайг эрт сэрээж, би өглөөний мөргөлийн цагийг өөртөө гаргадаг болсон. Өдөр бүр би “40 өдрийн номын” бүлгүүдийг судаллаа. Тэгээд Есүстэй харилцах харилцаа минь өсөж байгааг маш тод анзаарсан юм. Бурхантай харилцах миний харилцаа маш гүн бөгөөд дотно болсон байв. Ариун Сүнс миний дотор оршин ажлаа хийсээр байлаа. Би 40 өдрийн номыг уншиж дууссаны дараа, энэ цуврал номноос дахин нэг номыг нь уншсан бөгөөд түүнээс хойш би энэ номуудыг дөрвөн удаа уншиж судалсан. Өдөр бүр Бурханаас харилцаа холбоо гуйхгүйгээр би юу ч хийж чадахгүй. Энэ номыг уншсаны үр дүн үнэхээр гайхамшигтай байсан бөгөөд миний урам зориг, дотоод амар тайван анзаарахгүй байхын аргагүй сайжирсан. Энэ хугацаанд би Бурхантай маш сайхан цаг хугацааг өнгөрүүлсээр ирлээ. Мөн би өөрийн гэрчлэлээ хуваалцах олон боломжийг олж харсан. Есүстэй ойр дотно харилцаа нь шийдэж чадахгүй байсан маш олон асуудлыг шийдэж өгдөг. Олон хүн над шиг зүйлийг мэдрээсэй хэмээн найдаж мөн залбирч байна.” Х. С.

БИДНИЙ АСУУДЛЫГ ШИЙДЭЖ БОЛОХ УУ? ХЭРХЭН ШИЙДЭХ ВЭ?

*Бид хэрхэн хүчирхэг, аз жаргалтай
Христэд итгэгчид болох вэ? Ариун Сүнс хэрхэн бидний амьдралыг
гүүжээдэг вэ?*

Есүс: “Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна” гэж хэлжээ. (Иохан 15:4) “Христ дотор байна гэдэг нь Түүний Сүнсийг тасралтгүй хүлээн авч, Түүний төлөө бүхий л зүрх сэтгэлээрээ бууж өгсөн амьдрал юм.”³⁷

Бидний асуудлын голыг шийдэх энэхүү бурханлаг хоёр шийдэл бол (Ариун Сүнсийг байнга хүлээн авсаар байх ба бүрэн бууж өгөх) Христэд итгэх итгэлийн аз жаргалтай амьдралын арга зам юм. Яагаад? “Миний баяр баясгалан та нартай хамт байж, та нарын баяр баясгалан дүүрэн болохын тулд үүнийг би та нарт хэлье” хэмээн Есүс хэлжээ (Иохан 15:11). Энэхүү хоёр алхмаар (Ариун Сүнсийг хүлээн авсаар байх мөн бүрэн бууж өгөх) Христ бидний дотор орших бөгөөд бид төгс аз жаргалд хүрэх юм. Колоссай 1:27-д алдрын баялгийн талаар өгүүлдэг Христ таны дотор бий. Үгүй гэж үү?

37 Элен Уайт, Үе үеийн хүслэн (1898), х. 676.2

Есүс бидэнд Иохан 16-р бүлэгт Ариун Сүнсний ажлын талаар мөн Иохан 14-р бүлэгт Ариун Сүнс илгээх амлалтын талаар усан үзмийн сургаалт зүйрлэл үлдээсэн нь үнэхээр гайхалтай.

Хамгийн чухал асуудал (дүрэм) бол өдөр бүр байгаа бүхнээрээ Бурханд бууж өгч байна уу? Мөн өдөр бүр итгэлээрээ Ариун Сүнсийг хүлээн авч байна уу? гэдэг асуулт юм.

ЯАГААД ӨДӨР БҮР ЕСҮСТ БУУЖ ӨГӨХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Есүс Лук 9:23-д: “Тэр тэдэнд бүгдэд нь хандаж -Хэрэв хэн нэгэн Миний араас явахыг хүсвэл, тэр хүн өөрийгөө үгүйсгэж, **өдөр бүр** загалмайгаа үүрч Намайг дага” гэж хэлсэн.

Есүсийн шавь байна гэдэг нь өдөр бүрийн хичээл зүтгэл ажээ. Өөрийгөө үгүйсгэнэ гэдэг нь Есүст амьдралынхаа удирдлагаа бүрэн өгнө гэсэн үг юм. Загалмайгаа үүрнэ гэдэг нь өдөр бүр асуудалтай байна гэсэн үг бишээ. Паул өөрийгөө “Би өдөр бүр үхдэг” гэж хэлсэн шиг бид амин хувийн хүслээ өдөр бүр үгүйсгэж, Есүсийг өөрийн хүслээр баяр хөөртэйгөөр дагах гэсэн үг юм. Есүсийн үед хэн нэгэн загалмай үүрсэн бол үхэх ял эдлэхээр цаазын газар руу явдаг байжээ. Тэгэхээр Есүсийг дагахаас үүдэн бий болсон хүнд хэцүү зүйлсийг хүлээж авдаг байх хэрэгтэй.

Бид энэ дэлхийд хүн болж төрөөд махан биеийн амьдралаа хүлээж авдаг. Бид эрүүл, хүчтэй байхын тулд өдөр бүр хоол идэх хэрэгтэй. Харин бид дахин төрөхдөө сүнслэг амьдралаа хүлээн авдаг ажээ. Сүнслэг амьдралаа эрүүл хүчтэйгээр нь хадгалахын тулд бид доторх хүнээ өдөр бүр зайлшгүй анхааран халамжлах хэрэгтэй. Хэрэв бид махан бие болон сүнслэг амьдралаа халамжлахгүй бол сульдэн доройтож, өвдөж бүр үхэж ч болох юм. Удаан хадгалж муудсан хоол иддэггүй шиг Ариун Сүнсийг бид хадгалж чадахгүй.

“Элч нарын үйлс” хэмээх номонд үнэ цэнэтэй зөвлөгөө бий. “Сүнс нь дэлхий болон сүнслэг ертөнцийн аль алинтай нь зохицдог. Дэлхийн амьдрал нь бурханлаг хүчний тусламжтайгаар үргэлжилж байдаг; Гэвч энэ нь гайхамшгаар тэтгэгддэггүй бөгөөд бидний авч болох ивээл ерөөлүүдээр тэтгэгддэг байна.”³⁸

38 Элен Уайт, *Элч нарын үйлс* (1911), х. 284.2

Үе үеийн хүслэн номноо бичигдсэн энэхүү илэрхийлэл миний сэтгэлд маш тод хүрсэн юм. “Бид Христийг өдөр бүр дагах хэрэгтэй. Бурхан маргаашийн тусламжийг өнөөдөр өгдөггүй юм.”³⁹

Элен Уайт:

“Есүсийг дагах нь эхнээсээ л бүх зүрхээрээ өөрчлөгдөн, **өдөр бүр** гэм нүгэлдээ харамсан гэмшихийг шаарддаг.”⁴⁰ “Бид **өдөр бүр** өөрчлөгдөн шинэчлэгдэхгүй л бол хичээл зүтгэл нь ямар ч ашиггүй юм.”⁴¹

“Өглөөд өөрийгөө Бурханд зориулахыг хамгийн эхний хийх ажлаа болго. Харин залбирал тань, “Өө Эзэн минь намайг бүхлээр нь Өөртөө аваач. Би таны өмнө өөрийн бүх төлөвлөгөөгөө тавья. Өөрийн ажилдаа өнөөдөр намайг ашиглаач. Миний дотор байгаач, ажил үйлс минь бүгд Таны төлөө байх болтугай.” Энэ бол өдөр бүр хийх ёстой зүйл юм. Өглөө бүр тухайн өдрийнхөө төлөө өөрийгөө Бурханд зориулаарай. Түүний элбэг хангалуунаас хүртэж, ерөөгдөхийн тулд өөрийн бүх төлөвлөгөөгөө Бурханы өмнө тавиарай. Өдөр бүр амьдралаа Бурханы гарт даатгах аваас таны амьдрал Христийн амьдралтай илүү төстэй болон өөрчлөгдөх болно.”⁴²

Моррис Вендэн:

“Хэрэв та өдөр бүр зайлшгүй өөрчлөх зүйлсээ олж нээгээгүй байгаа бол энэ нь таны амьдралын хамгийн том шинээр хийх алхам байж болно. Ерөөлийн уулан дээрх сургаал номын 101-р хуудсанд бичсэн зүйлээс энэ амлалтыг харж болно: ‘Хэрэв та Эзэнийг өдөр бүр эрэлхийлэн өөрчлөгдөх аваас ... таны бүхий л чимээ шуугиан, орилоонтой зүйлс арилж, хэцүү бүх асуудлууд тань цэгцэрч, одоо танд тулгараад буй төвөгтэй асуудлууд ч шийдэгдэх болно.’⁴³

Түүнд буулт хийн өдөр бүр шинэчлэгдэж, Есүстэй хамт үлдэх нь бидний анх Түүн рүү очиж байсан үе шиг чухал юм.

Моррис Вендэн цааш хэлэхдээ: “Бурхантай өдөр тутмын тогтмол харилцаатай байх нь хором мөч бүрт Түүнээс хамаарч, үргэлж буулт хийх хандлагатай болгодог.”⁴⁴

39 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 313.4

40 Францис Д. Николь, *Адвентист Библийн тайлбар* боть 1 (Review and Herald, 1976), х. 1113

41 Элен Уайт, *Review and Herald*, Нэгдүгээр сарын 6, 1885

42 Элен Уайт, *Христэд хүрэх зам* (1892), х. 70.1

43 Моррис Вендэн, *95 Итгэлээр зөвтгөгдөх онол* (Pacific Press, 1987), х. 96

44 Моррис Вендэн, *95 Итгэлээр зөвтгөгдөх онол* (Pacific Press, 1987), х. 233

Тэрээр: “Над уруу ир ...” (Матай 11:28) мөн “Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй” (Иохан 6:37) хэмээн хэлсэн учраас бид өглөө бүр Есүст ухамсартайгаар бууж өгснөөрөө Түүний хүслийг биелүүлж байдаг.

“Эзэн бидний төлөө агуу зүйлс хийхийг хүсч байна. Бид ялалтыг тоо хэмжээгээр олж авахгүй харин бүх зүрх сэтгэлээрээ Есүст бууж өгөх үед ялдаг. Бид Түүний хүчээр урагшилж, зөвхөн Израилийн агуу Бурханд итгэх ёстой хүмүүс юм. ...”⁴⁵

Жон Веслигийн: “99 хувиа л Бурханд зориулсан бүхэл бүтэн армиас 100% өөрийгөө Түүнд зориулсан ганц хүнээр илүү их зүйлийг хийдэг”⁴⁶ хэмээн тодорхойлсонтой адил бид өөрсдийгөө Түүнд бүрэн зориулах аваас Бурхан биднээр дамжуулан агуу нөлөөлөл бий болгодог.

Элен Уайт:

“Зөвхөн Христийн хамтрагч нар байж чадах, мөн Эзэн минь надад байгаа бүхэн болон би өөрөө бүхлээрээ Таных гэж хэлдэг хүмүүс л Бурханы охид хөвгүүд хэмээн хүлээн зөвшөөрөгдөх болно.”⁴⁷ “Бурханд бие махбод, оюун ухаан, зүрх сэтгэлээ зориулдаг бүх хүмүүс оюун ухаан болон бие махбодын шинэ хүчийг үргэлж хүлээн авсаар байдаг. ... Ариун Сүнс хүний зүрх сэтгэл, оюун бодолд нь маш хүчтэй ажилладаг. Бурханы нигүүлсэл тэдний авьяас чадварыг өсгөн үржүүлж, бурханлаг байдлын төгс бүхэн зүрх сэтгэл болоод сүнсийг аврах ажилд нь туслалцаа болон ирдэг. ... Тэгээд хүний сул дорой байдал нь Бүхнийг чадагчийн үйлсийг хийх боломжтой болдог.”⁴⁸

Бид өдөр бүр “Зориулалт”, “Үйлдэл”, “Амьдралаараа бууж өгөх” мөн “Өөрчлөн шинэчлэгдэх” гээд маш олон зүйл хийх хэрэгтэй болдог.

Яагаад өдөр бүр Ариун Сүнсний баптисм хүртэхийг гуйх ёстой вэ?

Ариун Сүнсээр дүүрэх хүсэлт нь Есүс миний дэргэд байгаач гэсэн хүсэлт юм. Учир нь Тэрээр миний дотор Ариун Сүнсээр дамжин оршин байдаг. Гэвч яагаад өдөр бүр гэж?

45 Элен Уайт, *Бурханы охид хөвгүүд*, х. 279

46 Др. С. Жозеф Киддер, *Anleitung zum geistlichen Leben* (Андрюсийн их сургууль), PPP slide 14

47 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 523.1

48 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 827.3

Элч нарын үйлс номноо Элен Уайт хэлэхдээ: Христ ч мөн адил дэлхий дээр амьдарч байх хугацаандаа Эцэгээсээ хэрэгцээт зүйлсийг өдөр бүр хүсэн залбирдаг байсныг мэдэх нь **өөрсдийгөө зориулж буй ажилчдад гайхалтай тайтгарал болдог** ... Есүс Өөрөө үлгэрлэн чинхүү итгэлтэйгээр Бурханд хандан чин сэтгэлээсээ, шаргуу гуйхыг харуулсан. Тэрхүү итгэл нь Бурханаас бүрэн хамаардаг бөгөөд Бурханы ажил үйлчлэлд чин сэтгэлээ хандуулдаг төдийгүй нүглийн эсрэг дайнд хүмүүсийг Ариун Сүнсний тусламжтайгаар дагуулдаг тийм итгэл юм.⁴⁹

Хэрэв энэ нь Есүсийн хувьд өдөр тутам зайлшгүй шаардлагатай байсан юм бол бидэнд хэр зэрэг чухал байх бол.

2 Коринт 4:16-д нэгэн чухал илэрхийлэл бий:

“... Доторх хүн маань **өдрөөс өдөрт** шинэчлэгдэж байна.”

Бидний дотоод хүнд өдөр бүрийн анхаарал халамж хэрэгтэй. Ямар аргаар энэхүү өдөр тутмын сэргэлт шинэчлэл бий болдог вэ? Ефес 3:16-17,19-д бичсэний дагуу Ариун Сүнсээр дамжин бий болдог: “Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу **Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай**. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, ... та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.”

Үр дүнд нь:

- ▶ Ариун Сүнсний сэргэлтийн төлөө өдөр бүр зайлшгүй залбирдаг болно.
- ▶ Үр дүнд нь Христ бидний дотор амьдардаг.
- ▶ Тэрээр бидний дотоод хүнд алдрын баялгийнхаа дагуу хүч чадал өгдөг. Тэрхүү Бурханы хүч нь ер бусын хүч юм.
- ▶ Бурханы хайр бидний зүрх сэтгэлд дүүрдэг.
- ▶ Мөн энэ нь “Бурханы бүхий л бүрэн бүтэн байдалтай” Амьдралд хүрэх арга юм. (Иохан 10:10; Колоссай 2:10-г харна уу)

Өөр нэгэн чухал ишлэл Ефес 5:18-д бий: “... Сүнсээр дүүрэн бай.” Энэ нь зүгээр нэг зөвлөгөөнөөс илүү зүйл гэдгийг анхаараарай. Бурхан биднийг Ариун Сүнс дүүрэн амьдрахыг хүсэн хүлээдэг. Энэхүү ишлэлийг Грек хэлээр маш тодорхой ойлгомжтой илэрхийлсэн гэж үздэг. Жоханнес Магер ийн хэлжээ: “Тогтмол өөрийгөө Ариун Сүнсээр дүүргэж шинэчилж байгаарай.”⁵⁰

49 Элен Уайт, *Элч нарын үйлс*, (1911), х. 56.1

50 Зохиолч Вернер Е. Ланг, *Unser größtes Bedürfnis* (Luneburg, 2011), х.

Харин бидний номонд: “Ариун Сүнсээр баптисм хүртэнэ гэдэг нь Ариун Сүнсний нөлөөнд бүрэн орж, Түүгээр бүрэн дүүрнэ гэсэн үг юм. Паул Ефес 5:18-д “дүүргэгдэх” хэмээх Грек үйл үгээр үүнийг зөвхөн нэг удаа мэдрээд орхих биш харин үргэлжлүүлэн давтан дахин дахин хийх ёстой зүйл хэмээн илэрхийлдэг.”⁵¹

Элч Паул үүний талаар Ефес 5 болон Ефес 1:13-д мөн “Түүнд итгээд, амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан байв” гэж бичжээ: Ефесчүүд Ариун Сүнсийг хүлээж авсан нь тодорхой харагдаж байна. Ийм учраас тэд зайлшгүй “Түүний Сүнсээр хүчирхэгжсэн” мөн “Сүнсээр дүүрсэн” мөн “Өөрсдийгөө шинэ Сүнсээр тогтмол тасралтгүй, үргэлж дүүргэсэн” байх ёстой. Мөн Ефес 4:30-д Ариун Сүнсийг гомдоон доромжлохгүй байхыг анхааруулсан.

Элен Уайт:

“Өдөр бүр үйлчлэлийн ажилтан бүр Ариун Сүнсний баптисм хүртэх гүйлт залбирлаа Бурханд хэлэх ёстой.”⁵²

“Бид Христийн зөвт байдлыг авахын тулд бурханлаг оршихуйн нэг хэсэг байж, Сүнсний нөлөөгөөр өдөр бүр шинэчлэгдэх хэрэгтэй. Тухайн хүнийг бүхий л талаар нь сайн сайхан болгож, зүрх сэтгэлийг нь ариусгаж, хүчийг нь нэмэгдүүлэх нь Ариун Сүнсний ажил юм.”⁵³

Мөн Эзэн Элен Уайтаар дамжуулан: “Бурханы үг буюу Ариун Бичээсүүдээр хөглөгдөж, заавруудыг нь дагах хүсэлтэй тэдгээр хүмүүс нь Ариун Сүнсний бэлгээр өдөр бүр дүүрч жинхэнэ итгэгчид мэт өдөр бүр суралцаж, өдөр бүр сүнслэг гал халуун байдал болон хүч чадлыг хүлээн авдаг” гэжээ.⁵⁴

Тэрээр цааш нь: “Бид Христийг өдөр бүр дагах хэрэгтэй. Бурхан тусламжаа маргааш гэж хойшлуулдаггүй юм.”⁵⁵

Мөн өөр нэг номноо: “Хором мөч бүрт бурханлаг хүчин зүйлстэй холбогдох нь бидний хөгжил, дэвшилд зайлшгүй хэрэгтэй юм. Бидэнд магадгүй Бурханы Сүнс тодорхой хэмжээгээр байж болох ч итгэл болон залбирлаар үргэлжлүүлэн Ариун Сүнсийг илүү ихээр эрэлхийлэх хэрэгтэй.”⁵⁶

51 2014 оны 7 сарын 17-ны *Шаббат хичээлийн ном*

52 Элен Уайт, *Элч нарын үйлс* (1911), х. 50.2

53 Элен Уайт, *Сонгомол захидлууд* 1, (1958), х. 374.1

54 Элен Уайт, *Цаг хугацааны шинж тэмдгүүд* нэгдүгээр хэсэг 1910 оны 3 сарын 8,

55 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 313.4

56 Элен Уайт, *Тойм мэдээ*, 1897 оны 3 сарын 2, 5-р хэсэг

Мөн доорх гайхалтай гэрчлэлийг олж мэдсэн: “Танд элч нарын үед тэднийг бүгдийг нь нэгтгэж байсан тэрхүү хайрын баптисм өдөр бүр хэрэгтэй.”⁵⁷

Ром 5:5-д Бурханы хайр Ариун Сүнсээр дамжуулан бидний зүрхэнд бялхсан гэдгийг хэлдэг. Мөн бид Ефес 3:17-с Ариун Сүнсээр өдөр бүр баптисм хүртэнэ (Ариун Сүнсээр дүүргэгдсэн байх) гэдэг нь хайраар баптисм хүртсэнтэй адил гэдгийг олж уншдаг. Галат 5:16-д үр дүнд нь нүглийн хүч устана гэж хэлжээ.

ХУВИЙН МӨРГӨЛИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ

Хэрэв өдөр бүр Есүст бууж өгч, Ариун Сүнсээр дүүргэгдсэн байх нь чухал юм бол хувийн мөргөлийн чухал зүйл нь юу байх вэ?

Сүнслэг амьдралын үндэс бол өдөр бүрийн мөргөл болон Шаббат сахиx юм.

Бид үүний талаар аль хэдийн Библийн ишлэлүүд болон өөр олон гэрчлэл уншсан. Эдгээр нь бидний дотоод хүн өдрөөс өдөрт шинэчлэгдэх ёстойг харуулдаг. **Мөн бидний өдөр бүрийн хувийн мөргөлд тод гэрэл болдог.**

Ариун ордон дахь мөргөлийн үйлчлэл нь бүхэлдээ өглөө оройны шатаалт тахил байсан. Харин Шаббат өдөр нэмэлт Шаббатын шатаалт тахил өргөдөг байжээ (Тооллого 28:4,10). Шатаалт тахилын юу нь чухал байсан вэ?

“Шатаалт тахил нь нүгэлтэй хүн бүрэн бууж өгч буй байдлыг Эзэнд илэрхийлдэг байв. Тухайн хүн өөрт нь юу ч байхгүй бөгөөд бүх зүйлээрээ Бурханд хамааралтай гэдгээ харуулдаг байжээ.”⁵⁸

“Өглөө оройд товлогдсон мөргөлийн цагууд нь ариун гэж тооцогддог ба Еврей үндэстэн хотлоороо товлосон цагт мөргөлдөө ирдэг байв. ... Энэ ёс заншлын дагуу Христэд итгэгчдэд өглөө болон оройны залбирал хийдэг. Ариун Сүнсгүй мөргөлийн ёс заншил төдий зүйлийг Бурхан буруутгадаг ч Тэрээр Түүнийг хайрладаг, хийсэн гэм нүгэлдээ гэмшиж өглөө оройд Эзэний өмнө бөхийдөг мөн хэрэгтэй ивээлүүдээ Түүнээс гуйдаг хүмүүсийн дээрээс ихэд тааламжтайгаар ширтэн байдаг.”⁵⁹

57 Элен Уайт, *Сүмүүдэд өгөх гэрчлэл* (1904), боть 8, х. 191

58 Fritz Rienecker, *Lexikon zur Bibel* (Wuppertal, 1964), p. 1017

59 Элен Уайт, *Эцэг өвгөд ба эш үзүүлэгчид* (1890), х. 353.3

Бидний сүнслэг амьдралын үндэс болох өдөр бүрийн мөргөл нь Шаббаттай холбогдож буйг та анзаарав уу? Мөн энэ нь Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор амьдрахаар уригдсан Есүс Христэд өдөр бүр бүүж өгөхтэй ч холбоотой гэдгийг тодорхой харуулж байгааг анзаарсан уу? Та өөртөө өдөр бүр бүх зүйл дээр Бурханыг нэн түрүүнд тавина хэмээх хамгийн чухал сүнслэг зарчмыг бий болгож чадсан уу? Есүс уулан дээрх сургаалдаа:

“Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” Матай 6:33.

Яг одоо таны зүрх сэтгэлд Христ байгаа бол энэ нь Бурханы хаанчлал юм. Ийм учраас л бид өдөр бүрийн мөргөлийн цагаараа Түүнд бууж өгөн, Ариун Сүнсийг гүйх хэрэгтэй. Төгсгөл болж Бурханы өмнө зогсоход энэ нь бидний хувьд эцсийн шийдвэрлэх мөч байх болно: Бид Христтэй харилцах харилцаагаа хадгалж мөн Түүний дотор байж чадсан уу? (Иохан 15:1-17). Та итгэлийн амьдралаа илүү төгс төгөлдөр болгохыг хүсэхгүй байна гэж үү?

Бурханд маш бага цаг зарцуулж, чимээгүй цаг гаргалгүй мөн дутуу дүлмаг мөргөл үйлдсэн хэн боловч тэдгээр хичээл зүтгэлийнхээ үр дүнд долоо хоногтоо ганц хоёр удаа л хүч чадлыг мэдэрч магадгүй юм.

“

Бидэнд Христийн зөвт байдал байж болох ч Бурханлаг оршихуйн нэг хэсэг байхын тцлд өдөр бүр Ариун Сүнсний нөлөөнд өөрчлөгдөх хэрэгтэй.

”

Энэ нь яг л долоо хоногт ганц удаа хоол идэж буйтай адил юм. Харьцуулалт хийе: Долоо хоногт нэг удаа хооллох нь утгагүй биш гэж үү? Тэгэхээр мөргөлгүй Христэд итгэгчид нь махан биеийн дагуу гэсэн үг биш гэж үү?

Энэ нь тэр хүн ийм нөхцөл байдалдаа үлдэх аваас аврагдахгүй гэсэн үг. Хэрэв бид махан биеийн итгэгчид бол мөргөл нь зүгээр л үүрэг даалгавар болно. Хэрэв бид сүнслэг итгэгчид бол мөргөл нь бидний хувьд зайлшгүй хэрэгцээ байх болно.

Олон жилийн өмнө би Жим Ваусийн “Би атаман байсан” хэмээх номыг уншиж байсан юм. Тэрээр өөрчлөгдөн шинэчлэгдсэн гэмт хэрэгтэн байлаа. Тэрээр чин зүрхнээсээ худал ярих, хулгай хийх гэх мэт олон гэм нүглүүддээ гэмшжээ. Тэгээд маш гайхамшигтай бурханлаг нөлөөг мэдэрчээ.

Энэ нь миний сэтгэлийг ихэд хөдөлгөсөн бөгөөд би өөртөө: Би бүх зүйл дээр энгийн л байсаар ирсэн ч би дахин ийм байхыг хүсэхгүй байна гэж хэлээд Эзэнд хандан “Тэнгэрийн Эцэг минь би мөн адил өөрийн бүх хийсэн гэм нүгэлдээ болон Таны мэдүүлэх гэм нүглүүддээ гэмшихийг хүсч байна. Би Библи уншиж, залбирахын тулд эрт босох болно. Тэгээд Таныг миний амьдралд орж ирэх эсэхийг хармаар байна” хэмээн залбирлаа.

Бурханыг магтъя! Тэрээр миний амьдралд орж ирсэн юм. Түүнээс хойш Шаббаттай холбогдсон миний өглөөний мөргөл Бурхантай хамт байх амьдралын минь үндэс суурь болсон.

Өдөр бүр Бурханд өөрийгөө буулгаж өгөх болон өдөр бүр Ариун Сүнсээр дүүрэн байх нь бидний амьдралыг гайхамшигтайгаар өөрчлөх болно. Гэвч энэ нь зөвхөн хувийн мөргөлийн цагийн үеэр бий болдог зүйл юм.

ҮНЭНЭЭР БОЛОН СҮНСЭЭР МӨРГӨХ НЬ

Мөргөлийн зорилгын талаар бодоод үзэцгээе. Хүн төрөлхтөнд өгсөн Бурханы сүүлийн захидалд (Илчлэлт 14:6-12) Бүтээгчид мөргөх ба араатанд мөргөх хоёрыг харьцуулсан байдаг. Мөргөлийн гадаад ил шинж чанар бол Шаббат (Бүтээгчид мөргөх) юм. Харин мөргөлийн дотоод шинж чанарыг Иохан 4:23-24-д ийн бичжээ: “Харин үнэн мөргөгчид нь **сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөх цаг** ирж байгаа бөгөөд одоо ирчихээд байна. Учир нь Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг эрж байна. Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой гэж айлдлаа.”

Сүнсээр **мөргөнө** гэдэг нь гарцаагүй ухаалгаар мөргөнө гэсэн үг. Мөн Ариун Сүнсээр дүүрсэн байх гэсэн үг. Харин **үнэнээр мөргөнө** гэдэг нь хүн хэлбэрээр оршин байсан үнэн болох Христэд бүрэн бууж өгч амьдрах гэсэн үг юм. Есүс “Би бол үнэн” (Иохан 14:6) гэж хэлсэн. Энэ нь Бурханы үг, тушаалын дагуу амьдрахын тулд Есүсийн дотор оршино гэсэн үг юм. Учир нь тэрээр “Таны үг бол үнэн юм” (Иохан 17:17) мөн “Таны тушаал бол үнэн” (Дуулал 119:142) гэж хэлжээ. Хэрэв бид одоо л үнэнээсээ мөргөхгүй бол чухал мөчид унах аюулд орохгүй гэж үү? Энэ нь махан биеийн бүх итгэгчдэд том асуудал болох болно.

Бид бүгд Бурханы тусламжтайгаар мэдлэгээ өсгөж, ахиц дэвшил гаргахыг хүсч байгаа гэж би бодож байна. Магадгүй доор бичигдсэн худал итгэл үнэмшлүүд зарим хүмүүсийг урагш ахихад нь саад болдог байх.

БАПТИСМ БОЛОН АРИУН СҮНС

Зарим хүмүүс өөрсдийгөө Ариун Сүнсээр дүүрсэн гэж боддог. Учир нь тэд баптисм хүртсэн тул бүх зүйл зүгээр мөн тэдэнд илүү зүйл хэрэггүй гэдэг ажээ. Энэ талаар Д. Л. Мүүди ингэж хэлсэн байна: “Маш олон хүн нэг удаа дүүргэгдсэн бол үүрд дүүргэгдсэн гэж боддог. Өө найз минь, бид яг л цоорхой сав шиг бөгөөд дүүрэн байхын тулд үргэлж усны ундаргын дор зайлшгүй байх шаардлагатай.”⁶⁰

Жосеф Х. Вагонер:

“Баптисм нь Ариун Сүнс бууж ирсэн баталгаа болдог ч, гэмшсэн гэм нүгэлтнүүд махбодын байдалдаа байсаар байна. Тэрээр дан ганц баптисмаа Бурханы нигүүлслийн шинж тэмдэг гэж итгэдэг. Дан ганц баптисм болон **зүрхэндээ Сүнсгүй байдал** түүний шинж чанар болон “гэрчлэл” байх болно....”⁶¹

Усан баталгаа нь ач холбогдолтой шийдэл гэдэг нь тодорхой. Энэ нь Бурханы хүсэлтэй нийцдэг. Мөн агуу ач холбогдолтой бөгөөд үүнийгээ хадгалсаар ч байдаг. Гэвч бид Ариун Сүнсээр дүүрсэн хэмээх өнгөрсөн тэр үеийн үйл явдал руу эргэж харах ёсгүй. Харин оронд нь бид яг **одоо** Ариун Сүнсээр дүүрэн эсэхээ мэдэрч сурах хэрэгтэй.

Зарим хүмүүс баптисм хүртэхээсээ **өмнө** Ариун Сүнсийг хүлээж авсан байдаг. Жишээ нь: Корнелус эхнэртэйгээ мөн Саул. Зарим хүмүүс баптисм хүртсэнийхээ дараа Ариун Сүнсийг хүлээн авсан байдаг. Жишээ нь: Самаричууд мөн Ефесийн 12 эрчүүд. Хүн ер нь усан баталгааны **дараа** эсвэл **өмнө** нь Ариун Сүнсийг хүлээн авсан гэдгээрээ бус харин Ариун Сүнсийг хүлээн аваад зүрх сэтгэлд нь Бурхан байгаа эсэх нь чухал юм.

Танд дахин сануулья: Бид төрөхдөө махан биеийн амьдралаа хүлээн авдаг. Бид тэрхүү биеэ өдөр бүр хоол, ус мөн дасгал хөдөлгөөн гэх мэт зүйлсээр тэтгэдэг. Үгүй бол бид удаан амьдарч чадахгүй. Бидний махан биеийн амьдрал шиг сүнслэг амьдрал маань мөн адил зүйл шаарддаг. Бид Есүст бүрэн бууж өгөх үед Ариун Сүнсээр дамжуулан шинэ амьдралыг хүлээн авдаг. Бидний сүнслэг амьдрал Бурханы үг болон залбирал гэх мэт зүйлсээр тэжээгдэж байдаг. Элен Уайт: “Бидний амьдрал хором мөч бүртээ бурханлаг хүчээр тэжээгдэн байдаг. Энэ нь гайхамшгаар бус харин бидний хүрч болох ивээл ерөөлүүдээр дамжуулан тэтгэгддэг” гэж хэлжээ.⁶²

60 Д. Л. Мүүди, *Тэд нууцыг олсон*, х. 85, 86; Деннис Смитийн

“Залбирал болон Мөргөлийн ном ... 10 дахь өдөр” 23-р хуудаснаас иш татав.

61 Жосеф Х. Вагоннер, *Бурханы Сүнс* (Баттл Грек, Мичиган 1 877), х. 35f, Карри Ф. Виллиамсын, *Erfüllt vom Heiligen Geist* (Luneburg, 2007), S. 58 иш татав.

62 Элен Уайт, *Элч нарын үйлс* (1911), х. 284.2

Махан биеийн болон сүнслэг амийн аль аль нь бидний дотор аандаа үлддэггүй. Харин Бурханаас бидэнд хангаж өгдөг зүйлсийг зайлшгүй ашиглах хэрэгтэй.

Биднийг дахин төрөхөд, Ариун Сүнс бидэнтэй хамт байхаар ирдэг. Гэвч Ариун Сүнсэнд байхын тулд өдөр бүр Эзэнээс ханган өгч буй зүйлийг хэрхэн ашиглаж байгаагаас шалтгаална. Хэрэв бид тэдгээр “зүйлсийг” ашиглаж чадахгүй бол ямар үр дүн гарах вэ?

Ариун Сүнс бол энэ бүх “зүйлсээс” хамгийн чухал нь билээ. Нэмж хэлэхэд: Мөргөл болон бусад зүйлсэд Бурханы үг болон залбирал их чухал юм.

Үүнийг би дотоод хүнээ **өдөр бүр** халамжлахад зайлшгүй хэрэгтэй дүрэм хэмээн хүлээн зөвшөөрнө гэж бодож байна. Хэрэв бид үүнийг хийхгүй бол харамсмаар үр дагавруудыг амсах болно. Бид Ариун Сүнсийг идэж ч мөн хадгалж ч чадахгүй. “Бурхан маргаашийн тусламжийг өгдөггүй”⁶³ Харин өдөр бүр Есүст бүрэн бууж өгөн, Ариун Сүнсийг урих нь зайлшгүй тодорхой шалтгаан байх болно гэж би үзэж байна.

Энэ хоёр асуудал нь адил зорилготой ба яг л нэг зоосны хоёр тал юм. Христэй ойр дотно харилцаа холбоотой байх хэрэгтэй. Өөрийгөө Түүнд бүрэн буулгаж өгөх болон Ариун Сүнсийг гуйх залбирлаараа Түүнийг зүрх сэтгэлдээ урьдаг.

Библийн ишлэлүүдэд 1 Иохан 3:24 (мөн Иохан 14:17,23-г хар)-д “Бидний дотор Тэр байгааг Түүний бидэнд өгсөн Сүнсээр бид мэддэг” хэмээн Есүс бидний дотор Ариун Сүнсээр дамжуулан амьдардгийг илэрхийлжээ.

АРИУН СҮНСНИЙ НӨЛӨӨЛЛҮҮД

Ариун Сүнс миний дотор байхад Тэрээр Христийн хийснийг миний дотор гүйцээж өгдөг. Ром 8:2 “Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ.” Бид “Сүнсний хууль”-г Ариун Сүнс зүрх сэтгэлд ажиллаж, биднийг бүхлээр нь Бурханы өмнө буулт хийлгэдэг хэмээн тайлбарлаж болно. Зөвхөн Ариун Сүнс л Христ юу хийснийг надад ойлгуулж чадна. Элен Уайт үүнийг ийн тайлбарлажээ: **“Ариун Сүнсийг сэргээн босгох хүчин зүйл болгон илгээсэн бөгөөд үүнгүйгээр Христийн золиос боломжгүй байсан юм. ... Аврагчийн дэлхий дээр хийсэн зүйлийг үр дүнтэй болгосон нь Ариун Сүнс юм. Тэрээр зүрхийг ариун болгодог Сүнс юм. Ариун Сүнсээр дамжуулан итгэгчид тэнгэрлэг зүйлсийн нэг хэсэг болдог ...”**⁶⁴

63 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х.313.4

64 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898) х. 671.2 мөн 672.1

Томас А. Давис энэ үйл явцыг ийн дүрсэлжээ: “Энэ нь хүмүүсийн төлөөх Христийн ажлын үр дүн нь хүртэл Ариун Сүнснээс хамаардаг гэсэн үг юм. Ариун Сүнсгүйгээр Христийн дэлхий дээрх үйлдлүүд болох Гетсамены зовлон, загалмай, дахин амилалт болон тэнгэр дэх тэргүүн тахилчийн үйлчлэлүүд бүгд амжилтгүй болох байсан юм. Христийн ажлын үр дүн нь дэлхийн зарим шашин шүтлэг эсвэл ёс зүйтэй удирдагчдын үйлсээс дээрдэхээргүй зүйл байх байсан юм. Христ Өөрийн сургаал болон үлгэр жишээгээр хүн төрөлхтнийг аварч чадахгүй байх байлаа. Хүмүүсийг өөрчлөхийн тулд зайлшгүй тэдэнтэй ажиллах шаардлагатай байдаг. Гэвч энэ ажил нь хүмүүсийн зүрх сэтгэлд Есүсээс илгээсэн тэрхүү Ариун Сүнсээр хийгддэг үйлс юм.”⁶⁵

“Бурханы Сүнс зүрх сэтгэлд байр сууриа эзлэхэд, амьдрал өөрчлөгддөг. Тэгээд нүгэлт бодлууд арилж, бузар үйлдлүүд үгүй болж; уур хилэн, атаа хорсол, тэмцлийн оронд эелдэг даруу байдал, амар тайван ноёлдог. Гуниг зовлонгийн оронд баяр хөөр бий болж, диваажингийн гэгээ царай зүсийг гэрэлтүүлнэ.”⁶⁶

Ариун Сүнс тэй амьдралд маш олон үнэ цэнэтэй үр дүн байдаг бол Ариун Сүнсгүй амьдралд маш их гарз хохирол, дутуу дулимаг байдлын үр дүн бий. Ариун Сүнс тэй болон Сүнсгүй амьдралын ялгааг 4 дүгээр бүлэгт илүү дэлгэрэнгүй тайлбарлах болно.

БИ АРИУН СҮНСЭЭР ДҮҮРСЭН ҮҮ?

Ариун Сүнсээр дүүрсэн эсэх талаар доорх асуултуудыг өөрөөсөө асуугаарай.⁶⁷

- ▶ Таны амьдралд Ариун Сүнсний анзаармаар нөлөөлөл байна уу? Жишээ нь: Есүс таны амьдралд жинхэнэ, агуу Нэгэн байж чадаж байна уу? (Иохан 15:16)
- ▶ Та Ариун Сүнсний дотоод дуу хоолойг ойлгож мөн сонсож эхэлсэн үү? Тэрээр амьдралын аливаа бүх сонголтууд дээр таныг чиглүүлж байна уу? (Ром. 8:14)
- ▶ Миний доторх хүнд хариу үл нэхэх хайр бий болсон уу? Найзаараа сонгохгүй байсан тэдгээр хүмүүст хандах зөөлөн энэрэнгүй, чин сэтгэлийн хандлагыг Ариун Сүнс надад өгсөн үү? (Галат 5:22; Иаков 2:8,9)

65 Томас А. Давис, *Als Christ siegreich leben*, (HW-Verlag), Seite 43 / Хэрхэн ялагч Христэд итгэгч байх вэ?, R&H.

66 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 173.1

67 Катерин Маршалл, *Дэл Хелпер* (Erzhausen, 2002), х. 24

- ▶ Ариун Сүнс хүмүүстэй харилцах харилцаанд минь тусалж байгааг би мэдэрдэг үү? Халамж анхаарал хэрэгтэй болон санаа зовж буй хүмүүсийн зүрх сэтгэлд хүрэхийн тулд Тэрээр надад зөв үгийг зааж өгдөг үү?
- ▶ Ариун Сүнс надад Есүсийн талаар ярих болон Түүн рүү хүмүүсийг дагуулах хүч өгдөг үү?
- ▶ Бурханд зүрх сэтгэлийнхээ гүн бодлуудыг илэрхийлэхэд болон залбирлын амьдралд минь Ариун Сүнс тусалдгийг би мэдэрдэг үү?

Эдгээр асуултуудыг бодоод үзэхэд, Бурханыг илүү их хайрлаж, илүү их танихад Ариун Сүнс дотор өсөх нь ямар их хэрэгтэй болохыг бид олж хардаг.

Нэгэн залуугийн гэрчлэл: Би аавтайгаа эвлэрсэн. *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* болон *Залбирлын 40 өдрийн номын* нэг, хоёрдугаар цувралыг уншиж дууссаны дараа би Ариун Сүнсээр дүүрэх гайхалтай мэдрэмжийг авсан юм. Ариун Сүнс амьдралын минь бүх хэсэгт ажиллахыг мэдэрэх нь миний сэтгэлийг маш их хөдөлгөж байлаа.

ЭЦЭГ ХҮҮ ХОЁРЫН ЭВЛЭРЭЛ

Аав бид хоёрын харилцаа ямар нэгэн байдлаар төвөгтэй байдаг байв. Хүүхэд нас мөн залуу насны минь залбирлын хүсэлт үргэлж аавтайгаа сайхан харилцаатай байх талаар байж билээ. Гэвч энэ нь аажмаар улам дордож байлаа. Ингэсээр зургаа долоон жил өнгөрөв. Бурхан зүрх сэтгэлийн минь гүн хоосон орон зайг дүүргэсэн юм. Ариун Сүнсийг амьдралдаа хүсэн залбирч, уншиж байхдаа Бурханыг маш ихээр мэдэрч байв. Бид гэр бүлийнхээ болон ялангуяа аавынхаа төлөө маш их залбирч байлаа. Энэ хугацаанд би аавыгаа хайрлах шинэ хайрыг хүлээж авсан юм. Би хүүхэд байхаасаа бидний харилцаанд байсан саар бүх зүйлд түүнийг уучлахад бэлэн болов. Одоо аав бид хоёр найзууд болсон. Тэрээр илүү сүнслэг болж байгаа бөгөөд мөн Бурханы талаар хүмүүстэй хуваалцаж эхэлсэн. Энэ цагаас хойш хоёр жил өнгөрсөн ч аавтайгаа маш сайн харилцаатай байгаа. Энэ зүйлийн төлөө би Бурханд их талархдаг. Би ихэнхдээ ганцаардсан, ямар ч хүч чадалгүй мэт санагддаг байсан. Гэвч өдөр бүр Ариун Сүнсийг залбиран гуйж эхэлсэнээс хойш Бурхантай харилцах харилцаа болон шинэ гайхалтай амьдралыг мэдэрч байна.

Залбирал: Эзэн Есүсээ, Ариун Сүнсээр дамжуулан миний дотор байдаг талархаж байна. Өдөр бүр өөрийгөө үгүйсгэж Танд бууж өгөх байдлаар дамжуулан бидний итгэл хайрын харилцаа өсөж байгаад Танд талархъя. Эзэн минь, Ариун Сүнс болон Түүний ажлыг илүү сайн ойлгоход туслаач. Өдөр бүр Ариун Сүнсийг гуйхад Түүнийг хүлээн авдаг хэмээх баталгааг өгөөч. Мөн Ариун Сүнс миний төлөө, гэр бүлийн минь төлөө мөн сүм чуулганы минь төлөө юу хийхийг хүсдэгийг мэдэхийг би хүсч байна. Энэ бүхний төлөө баярлалаа. Амен.

ЕФЕС 5:18-Н САНАА – “СҮНСЭЭР ДҮҮРЭН БАЙХ!”

Ефес 5:18 дээрх уриалгын англи хувилбар нь захиран тушаах хэлбэрт бичигдсэн байдаг. Цаашилбал энэ тушаал нь хүн бүрт зориулан хэлснийг харж болно. Мөн Ариун Сүнсний дүүрэн байдлыг эрж хайх нь бидний үүрэг гэдгийг өгүүлдэг. Гэвч анхны жинхэнэ Грек хувилбар нь үүнийг бүр илүү тодорхой болгодог.

Энэ тал дээр Жоханнес Магер ийн хэлжээ: “Шинэ гэрээний захидлуудад Ариун Сүнсээр дүүрэн байх талаар шууд хэлдэг ганцхан хэсэг бий: ‘Сүнсээр дүүргэгдсэн бай.’ (Ефес. 5:18). Үйлс номоос бид Ариун Сүнсээр дүүрэн байх нь бэлэг гэдгийг ойлгосон. Гэсэн ч Паул Ариун Сүнсээр дүүрэн байх нь тушаал хэмээн үзсэн бөгөөд Есүсийн бүх дагалдагчдад хамаатай гэж хэлжээ. Энэхүү богино, чухал тушаал нь дөрвөн нухацтай илэрхийллийг шингээжээ.

1. “Дүүрэх” хэмээх үйл үг нь захиран тушаах хэлбэрээр бичигдсэн. Паул энд нөхөрсөг зөвлөгөө өгөх юмуу санал болгоогүй. Аливаа хүн хүлээн авах эсвэл хүлээн авахгүй байх тал дээр ч санал болгоогүй. Тэрээр хүчирхэг элч шиг тушаасан. Тушаал нь үргэлж хүний хүсэлд хандсан байдаг. **Христэд итгэгчид Ариун Сүнсээр дүүрэхийг хичээх тушаалд хамаатай бөгөөд Ариун Сүнсээр дүүрэн байх нь бидний үүрэг хариуцлага юм.**
2. Олон тооны хэлбэр дээр бичигдсэн үйл үг. Энэ нь сүмийн онцгой үүрэг даалгавар хашдаг ганц хүнд өгөгдсөн тушаал биш. Ариун Сүнсээр дүүрнэ гэдэг нь хэдэн тусгай хүмүүст өгөгдсөн боломж ч биш юм. **Харин энэхүү дуудлага нь сүмийн харъяалалтай бүх хүмүүст хэзээ ч, хаана ч явсан хамаарах зүйл билээ.** Харин Паулын хувьд бүх хүмүүс Ариун Сүнсээр дүүрэх нь хэвийн гэж үзжээ.

3. Энэхүү үйл үг нь үйлдэгдэх хэв дээр бичигджээ. Энэ нь “Өөрийгөө Сүнсээр дүүргэ” гэж хэлдэггүй. Харин “Ариун Сүнсээр дүүргэгдсэн бай” гэж хэлдэг. Ямар ч хүн өөрөө өөрийгөө Ариун Сүнсээр дүүргэж чадахгүй. Энэ нь гагцхүү Ариун Сүнсний л ажил. Энд Түүний тэнгэрлэг эрх мэдэл байгаа юм. **Гэвч тухайн хүн нөхцөл боломжийг нь бий болгох хэрэгтэй бөгөөд тэгж байж Ариун Сүнс тэр хүнийг дүүргэдэг. Тэр хүний оролцоогүйгээр Ариун Сүнс түүний дотор ажиллахгүй.**
4. Грек орчуулганд бичигдсэн энэхүү захиран тушаах төлөвийн одоо цаг нь үргэлж давтагдан хийх зүйлийг дүрсэлжээ. Үүнээс үзэхэд, **Ариун Сүнсээр дүүрнэ гэдэг нь нэг удаа хийдэг зүйл биш. Харин байнга давтагдаж, өсөж хөгждөг үйл явц юм.** Христэд итгэгчид нэг удаа дүүрээд мөнхөд дүүрэн байдаг сав адил биш юм. Харин үргэлж “Дахин дүүргэгдэж” байх савнууд юм.

“Өөрийгөө тасралтгүйгээр, дахин дахин Сүнсээр дүүрэн байлга.” Баптисм хүртэхэд бидний дээрээс бууж ирсэн Ариун Сүнсээр дүүрэн байдлыг хадгалж үлдэхгүй бол энэ нь алга болж болно. Хэрэв энэ нь алга болж байгаа юм бол дахин олж болно. Ариун Сүнсээр дүүргэгдсэн байх нь дахин дахин давтагдах ёстой бөгөөд тэгснээр Тэрээр бидний амьдралын бүх хэсгийг дүүргэж мөн бид сүнслэг байдлаар хүчирхэг болно. Сүнсээр дүүрэн байна гэдэг нь бидэнд Ариун Сүнс ахиухан хэмжээтэй байна гэсэн үг биш бидэнд Ариун Сүнс илүү ихээр байна гэсэн үг. **Тийм учраас Паул бүх итгэгчдэд хандан үргэлж Сүнсээр дүүрэн бай хэмээн тушаажээ.** Энэ нь Христэд итгэгчдийн хувьд хэвийн нөхцөл юм. Нэг баптисм, харин олон “дүүргэлт”⁶⁸

Эзэн Өөрөө тушаал өгсөн: *
Өөрийгөө тасралтгүйгээр, дахин дахин
Сүнсээр дүүрэн байлга! **

68 Жоханнесс Магер нь пастор байсан бөгөөд сайн мэдээ түгээгч ба олон жил Их Сургуульд шашин судлал зааж байсан. Саяхан тэрээр Швейцарын Берн дэх Евро Африкийн (одоо Европын бүс) бүсийн үйлчлэлийн хэлтсийн захирлын алба хашиж байжээ. Одоогоор тэтгэвэртээ гарсан бөгөөд Фриеденсауд амьдардаг. Энэ хэсгийг түүний номоос иш татав: Auf den Spuren des Geistes, (Luneburg, 1999) хуудас 100-101 (хэвлэлийн газрын зөвшөөрөлтэй.)

* Элен Уайт, Ерөөлийн уулан дээрх сургаал, MB 20.3 (egwwritings.org)

** Жоханнесс Магер, Auf den Spuren des Heiligen Geistes (Luneburg, 1999), Seite 101



БИД ЯМАР ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

*Ариун Сүнс дүүрэн амьдралаар амьдрах нь
ямар гавуу талтай бэ?
Хэрэв бид Ариун Сүнсийг хүсэн
залбирахгүй бол юу алдах вэ?*

МАХАН БИЕЙН БОЛОН СҮНСЛЭГ ИТГЭГЧДИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Махан биеийн Христэд итгэгчдийн итгэлийн үр дагаврууд. Энэ нь дараах байдлаар тэднийг илэрхийлдэг:

- ▶ Тухайн хүн энэ нөхцөл байдалдаа байвал аврагдахгүй. (Ром 8:6-8; Илчлэлт 3:16)
- ▶ Бурханы хайр - агапэ хайр - тэр хүнд байхгүй. (Ром 5:5; Галат 5:22); Тэд хүний хайраас бүрэн хамаардаг: махан биеийн хүслээ үхүүлээгүй байдаг. (Галат 5:16)
- ▶ Тэр хүн Сүнсээр хүчирхэгжээгүй байдаг. (Ефес 3:16-17)
- ▶ Христ энэ хүний дотор амьдардаггүй. (1 Иохан 3:24)
- ▶ Тэр хүн Христийг гэрчлэх хүч хүлээн аваагүй байдаг. (Үйлс 1:8)
- ▶ Тэрээр аливааг амархан сөргөлдөн тэмцэлддэг хүний арга замаар хийдэг. (1 Коринт 3:3)
- ▶ Дүрэм, сануулгыг хүлээж авах нь энэ хүнд хэцүү байдаг.
- ▶ Тэдний залбирлын амьдрал дутуу дутмаг байж болно.
- ▶ Тэрээр уучилж өршөөх болон өс санахгүй байх тал дээр зөвхөн хүний чадваруудтай байдаг.

Махан биеийн Христэд итгэгч нь төрөлх хүн шиг үйлддэг. Паул: “Та нар махан биеийнхээ дагуу, хүний ёсны дагуу явдаггүй гэсэн хэрэг үү?” (1 Коринт 3:3) гэж хэлжээ. Хэдийгээр тэрээр хүний хүч, чадваруудаар амьдардаг ч зарим үед үүний үйлдэл сүнслэг хүн мэт байдаг.

Сүнслэг Христэд итгэгчид Бурханы бүрэн дүүрнийг мэдэрдэг:

“Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар **Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.** Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд алдар нь чуулган дотор, Христ Есүс дотор бүх үеийнхэнд үеийн үед байх болтугай. Амен.” Ефес. 3:16-21

МАХАН БИЕЙН ХРИСТЭД ИТГЭГЧИЙН ИТГЭЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

Би Пастор хийж байх хугацаандаа Ариун Сүнсний дутмаг байдлаас болж гэр бүл, сүм чуулгандаа гаргаж байсан гарз хохирлынхоо төлөө их харамсдаг. Бид өөрсдөөсөө өөр хэнийг ч удирдаж чадахгүй гэдэг нь үнэн. Мөн бид Ариун Сүнсний дутмаг байдал нь хувь хүмүүст, гэр бүлд, сүмийн өсөлтөд болон олон нийтийн дунд байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД

Махан биеийн Христэд итгэгчийн итгэл бол либерал (эвлэрэнгүй үзэлтэн) Христэд итгэгчдийн үржүүлгийн газар юм. Хүмүүс сайн санааны үүднээс чадахгүй зүйлээ мэдэлгүйгээр хийх гэж оролддог. Тэгээд дараа нь гарах арга зам хайдаг. Энэ нь маш олон залуусаа алдах шалтгаан болдог билээ. Бид өөрийн мэдэлгүй эсвэл өөр шалтгаанаар залуучууд, үр хүүхдүүддээ махан биеийн Христэд итгэгчийн итгэлийг үлгэрлэн харуулаад байгаа юм биш биз? Үр дүнд нь тэд маань махан биеийн Христэд итгэгчид болж мөн итгэл алдрах байдалтай тэмцэж байна уу? Энэ нь маш олон хүний сүмдээ ирэхээ болих эсвэл сүмээ орхих шалтгаан болдоггүй гэж үү.

Нэгэн ахмад настан сүмийнхэндээ ийн хэлжээ: Бидний амьдралд болон залууст маань өнөөдөр тохиож буй асуудлуудад шалтгаан бий: Энэ нь ахмад үе нь Ариун Сүнс хэрхэн ажлаа хийдэг болон Түүгээр дүүрэх талаар ойлгоогүй явдал юм.”⁶⁹

69 Kapri Ф. Виллиамс, Erfülltsein vom Heiligen Geist – Wie erfahren wird das? (Lüneburg 2007), S. 8

Танд бүлээн байдлын үр дагаврыг дахин сануулъя (Христэд бүрэн бууж өгөөгүй): “Хагас зүрх сэтгэлтэй Христэд итгэгчид нь шашингүй хүмүүсээс ч дор юм. Учир нь тэдний хуурмаг үгс болон итгэлгүй үйлдэл нь олон төөрөгдөл рүү дагуулдаг. Шашингүй хүмүүс өөрсдийнхөө өнгө төрхийг ил харуулдаг бол бүлээн Христэд итгэгч аль алиныг нь мэхэлдэг. Тэрээр дэлхийн ч сайн хүн байж ч чадахгүйн адил сайн Христэд итгэгч ч байж чаддаггүй. Сатан түүнийг хэний ч хийж чадахгүй ажилд ашигладаг.”⁷⁰

Гэсэн хэдий ч хэрэв бид сүнслэг амьдралаар амьдрах аваас хүүхдүүддээ Бурханы тусламжийн аргыг үзүүлж чадна. Элен Уайт үнэхээр гайхалтай зүйлийг хэлсэн байна:

“Ариун Сүнсний баптисмийг өдөр бүр хүлээн авах нь үнэхээр давуу тал гэдгийг тэдэнд зааж өг. Өөрийнхөө зорилгыг биелүүлэх Христийн мутар таныг олох болтугай. Залбирлаар дамжуулан хүүхдэдээ хийсэн таны үйлчлэл төгс амжилттай болохыг мэдэрнэ.”⁷¹

Бид хөвгүүддээ залбирахыг заасан. Гэхдээ бид тэдэнд өдөр бүр Ариун Сүнсийг авахаар залбирахыг зааж өгсөн үү? Эсвэл бид өөрсдөө ч мэдээгүй байсан үү? Тэр үед эхнэр бид хоёр үүнийг мэдээгүй байсан юм. Энэ удаад бид аль хэсэгтээ мэдлэгээр дутагдаж буйг олж харсандаа талархаж байна. Гэхдээ үр дүнд нь ямар их зүйл алдсан болоо?

Хэрэв өдөр бүр Есүст өөрсдийгөө зориулж, Ариун Сүнсийг гуйдаг бол бид ямар гайхалтай хүүхдүүд, сүнслэг эцэг эхчүүд байна гээч.

Орчин Нөхцөл – Бурханлаг хайр уу эсвэл зөвхөн нэг нэгэндээ сайхан хандах хандлага уу?

Хэрэв дүрэм журамтай амьдралаас Бурханы хүчийг салгаж, Бурханы хайр үгүй болж, гэм нүглийн хүч нураагүй байсан бол сүм чуулган, махан биеийн эсвэл сүнслэг Христэд итгэгчидтэй нөхөрлөх нөхөрлөл болон гэр бүл, гэрлэлтийн орчин нөхцөлд ямар ялгаа байх байсан бэ?

Хуучинсаг (туйлширсан) махан биеийн итгэгчид шүүмжлэх гэж оролддог. Энэ нь муу зүйл юм. Гэсэн ч бид Бурханы сайн удирдамж чиглүүлгийн талаар ярих хэрэгтэй бөгөөд өөрчлөлт нь дотор явагдахад, бүрэн дүүрэн шинэчлэлт бий болдог гэдгийг ойлгох хэрэгтэй.

Либералчууд (эвлэрэнгүй үзэлтэн) дэлхийн арга замд нийцэж, аливаа зүйлсийг нухацтай чухалчлан авч үздэггүй. Бурхан эдгээр хүмүүсийг мөн адил ивээж чадахгүй.

70 Элен Уайт, *Захидлууд* 44, 1903, Адвентист Библийн тайлбараас иш татав, Боть.7, х.963 Илчлэлт 3:15-16

71 Элен Уайт, *Хүүхдийн хүмүүжил* (1954), х. 69

Жосеф Киддер өнөөгийн сүмүүдийн нөхцөл байдлыг ийн тодорхойлжээ: Үлбэгэр сул байдал, өнгөц байдал, дэлхийлэг, өгөөмөр бус, үйлчлэлүүд нь унтарсан, өсвөр насныхан нь сүмээ орхисон, сахилга бат сул, сайн судалгаагүй болон үр дүнгүй төлөвлөгөөнүүдтэй, зориулалт гаргадаг хүчирхэг эрчүүдийн архаг дутагдалтай.”⁷²

Бидний асуудлын шалтгаан бол Есүстэй харилцах харилцааны дутагдал (Иохан 15:1-5) болон хүний хүчин чармайлтад дэндүү найдах (Зехариа 4:6) явдал юм. Киддер мөн Ариун Сүнстэй амьдралын шийдлийг олж харсан байна (Үйлс 1:8).

Есүс бидэнд шинэ тушаал өгсөн:

“Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно гэж хэллээ” (Иохан 13:34-35).

Есүс шиг хайрлана гэдэг нь: тэнгэрлэг хайраар (Агапэ) хайрлах гэсэн үг юм. Бид зөвхөн Ариун Сүнсээр дүүрсэн үедээ л үүнийг хийж чадна.

“Бурханыг хайрлах дээд хайр болон бусдыг хувиа хичээлгүйгээр хайрлах нь тэнгэрийн Эцэгийн өгдөг хамгийн шилдэг бэлэг юм. Энэ хайр нь сэтгэл хөөрөл биш, харин тэнгэрийн хууль, байнгын хүч юм. Ивээл аваагүй зүрх сэтгэл [Ариун Сүнсээр дүүрээгүй хэн боловч] үүнийг гаргаж чадахгүй. Энэ нь зөвхөн Есүс хаанчилдаг зүрх сэтгэлээс л олдоно.”⁷³

“Зөвхөн” нэг нэгэндээ сайхан хандах мөн Бурханы хайраар хайрлах хоёрын хооронд ялгаа бий. Элен Уайт бидэнд чухал тайлал өгчээ:

“Зөөлөн дөлгөөн Сүнсийг чимэг болгон авснаар аймшигтай хорсолт амьдралаас үүдэх зуун асуудлын ерөн ес нь хамгаалагдаж болох юм.”⁷⁴

Бурханы үг 1 Тесалоник 4:3-8-д гэрлэлтийн амьдралын талаар хөнддөг. Эдгээр ишлэлүүд нь гэрлэлтийн ариун журамтай байдал болоод хүндэтгэлийн талаар өгүүлдэг.

72 Др. С Жосеф Киддер, *Anleitung zum geistlichen Leben* (Andrews University), PPP Folie 3+4

73 Элен Уайт, *Элч нарын үйлс* (1911), х. 551.2

74 Элен Уайт, *Сүмүүдэд өгөх гэрчлэл*, боть 4, х. 348.3

Энэ нь харийнхны шунал тачаалаас ялгаатай зүйл юм. Ишлэлд Ариун Сүнстэй байх болон ариун амьдралаар амьдрах талаар гурван удаа дурддаг бөгөөд Ариун Сүнстэй байх нь гэрлэлтийн харилцааг хүртэл өөрчилж чаддаг гэдгийг бид хардаг. Бурхан гэр бүлийн амьдралд бүрэн бүтэн байдлыг болон баяр хөөр өгөхийг хүсдэг. Дур хүслээс илүүтэйгээр хайр энхрийлэлтэй байх тал дээр Бурхан бидэнд туслахыг хүсдэг гэдгийг энэ ишлэл тод харуулж байна.

Есүс дагалдагчдынхаа эв нэгдлийн төлөө залбирсан: *“Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ”* (Иохан 17:21).

Виллиам Г. Жонсон ийн хэлжээ: “Христтэй нэг болох нь чухам юу гэдгийг маш олон Адвентистууд ойлгох хэрэгтэй байна. Өнгөрсөн үед магадгүй бид энэхүү чухал зүйлд хангалттай анхаарал хандуулаагүй эсвэл яг л морин дээр морьдохдоо буруу талаас нь мордох мэт байсан байх.”⁷⁵

Бид Ариун Сүнсээр дүүрсэн үед Христ бидний дотор байдаг. Сүнслэг Христэд итгэх итгэл нь бидний залбирал Эзэнээр хариулагдсан байх тал дээр анхаарлаа хандуулдаг. Элен Уайт хэлэхдээ: “Бурханы хүмүүс Сүнсэн дотор нэгдэхэд, Еврей үндэстний гэм нүгэл гэж тооцогдож байсан Фарисай үзлүүд, бүхий л өөрийгөө зөвтгөсөн байдал нь зүрх сэтгэлээс хөөгдөх болно. ... Тэгээд үе үеийн турш далдлагдсан нууцын мэдлэгийг Бурхан мэдүүлэх болно. Харийнхны дундах нууцлагдсан зүйлсийн алдрын баялгууд гэж юу болох талаар Тэрээр мэдүүлэх болно: Энэ нь алдрын найдвар болох Христ таны дотор байна гэсэн үг юм.”⁷⁶ (Колоссай 1:27).

Засч залруулах зөвлөгөө

Өчүүхэн төдий Бурханы хайр шингэсэн эсвэл огт хайр шингээгүй зөвлөгөөнд үр дүн байх болов уу? Махан биеийн олон итгэгчид мөн махан биеийн пастор ерөнхийлөгчөөс бүрдсэн сүм чуулганууд ямар шийдвэрүүд гаргах бол? Пастораар ажиллаж байсан үеэ бодоход, сүнслэг итгэгч нар минь сүмээсээ явсан гишүүдийг ямар нэгэн аргаар авч ирэх гэж оролддог байсан нь сэтгэлийг минь ихэд хөдөлгөдөг. Аливаа хүн гэмшиж, нүглээ улайх үед бидний зөвлөгөө үр дүнтэй болдог. Заримдаа махан биеийн итгэгчид зөвлөгөөг шийтгэл болгох гэж оролдох эсвэл хүчийг нь буруугаар ашигладаг. (Матай 18:15-17; 1 Коринт 3:1-4; 2 Коринт 10:3; Иуда 19).

75 Виллиам Г. Жонсон, *Adventgemeinde in der Zerreißprobe*, (Luneburg 1996), x. 118

76 Элен Уайт, *Сонгомол захидлууд* 1 (1958), x. 386.1

СҮҮЛЧИЙН ӨДРҮҮДЭД ӨГСӨН БУРХАНЫ ЭШ ҮЗҮҮЛЛЭГИЙН ҮГС

Бурхан Өөрийн эш үзүүлэгчдээрээ чухал зүйлсийг дамжуулсаар ирсэн (Амос 3:7). Тиймээс Тэрээр Элен Уайтаар дамжуулан сүүлчийн өдрүүдэд чухал эш үзүүлэг бүхий захидлуудаа өгчээ. Өнгөрсөн цаг хугацаанаас маш олон зүйл өөр болсон учраас Бурханаас эш үзүүлэгээр нэмэлт мэдээлэл авах нь зайлшгүй чухал байсан юм. Өнөөдөр бид үүнийг “сайжруулалт” хэмээн нэрлэдэг. Элен Уайтын хэлснээр эдгээр захидлууд нь Есүсийг дахин ирэх хүртэл хүчин төгөлдөр байх болно. Түүний зөвлөгөөнүүд амьдралын хэв маяг, зэмлэл сануулга гэх мэт олон зүйлсийг багтаажээ. Сүнслэг нэгэн нь үүнийг махан биеийн итгэгчээс илүү хялбар хүлээж авдаг. (Гэхдээ хэн нэгэн нь эдгээр зөвлөгөөг чухалчлан хүлээж авахад энэ нь тэднийг шууд сүнслэг болгоно гэсэн үг биш юм). Дэд хууль 18:19-д буй “Миний нэрээр түүний хэлэх Миний үгийг сонсохгүй хэн бүхэн Миний шийтгэлийг хүлээх болно” хэмээх үгсийг бодолцох нь мэргэн байх болно.

Жинхэнэ эш үзүүлэгчээс ирсэн үгс нь тухайн хүн өөрөөсөө бус харин Бурхантай хамт хийсэн гэдэг нь бидэнд тодорхой харагддаг. Бид тухайн хүнийг хэрхэн жинхэнэ эш үзүүлэгч гэж мэдэх вэ? Таван шалгах аргыг Бурхан өгчээ. Жинхэнэ эш үзүүлэгч энэ таван зүйлтэй нийцэх ёстой.

1. Тэдний амьдрал – “Тиймээс тэдний үр жимсээр чи тэднийг танина.” Матай 7:15-20
2. Эш үзүүлэгийн биелэл Дэд хууль 18:21-22 (Эш үзүүлэгийн ер бусын тохиолдол жишээ нь Иона.)
3. Бурханд үнэнч байх (Бурханы үг). Дэд хууль 13:1-5
4. Есүсийг жинхэнэ хүн болон жинхэнэ Бурхан гэж таних. 1 Иохан 4:1-3
5. Библийг хүлээн зөвшөөрдөг байх. Иохан 17:17

Бурханы бүх тушаалууд мөн эш үзүүлэгчдээрээ дамжуулан өгсөн Түүний зөвлөгөөнүүд бүгд бидний сайн сайхны төлөө билээ. Тийм учраас онцгой үнэ цэнэтэй юм. Тиймээс сүнслэг хүмүүс баяр хөөртэйгөөр Бурханы хүчинд захирагддаг ба амьдралд нь амжилт авч ирдэг гэдгийг мэддэг. “Итгэл найдвараа өөрсдийн Бурхан ЭЗЭНд өг. Тэгвэл та нар бат бэх зогсох болно. Итгэл найдвараа **Түүний эш үзүүлэгчдэд өг, тэгвэл амжилт олно** гэв” (2 Шастир. 20:20).

Шаббат хичээлийн ном Ариун Сүнстэй амьдрал болон үнэн эш үзүүлэгчдийн үгс хоёрын хоорондын харилцааны талаар ийн өгүүлжээ: “Эш үзүүлэгийн үсгийг үл хэрэгсдэг хэн боловч өөрсдийгөө Ариун Сүнсний заавраас холдуулдаг. Үр дүн нь сөрөг зүйлсэд нээлттэй байх болон Бурхантай харилцах харилцаагаа алдсантай адил юм.”⁷⁷

77 Studienanleitung Standardausgabe, Philip G. Samaan, 10.11.1989, to question 8

ТӨЛӨВЛӨГӨӨ / СТРАТЕГИ

Чухал даалгавар бол сайн мэдээ түгээх ажил болон сүмийн алба үүрэгт сайн шийдэл арга замуудыг олох юм. Энэ бол бидний төлөвлөгөөт хийх ёстой хэсэг. Энэ нь ихэвчлэн сүмийн сүнслэг байдлыг хүчирхэгжүүлж, илүү олон хүн аврах юм.

Би баптисм хүртээд 65 жил болсон. Харин үйлчлэлийн ажил хийгээд 43 жил болж байна. Маш олон хөтөлбөр болон үйл ажиллагаа явуулсан бөгөөд их хөдөлмөрч байсан. Энэ сэдэв дээр 2005 оны Ерөнхий Чуулганы чуулга уулзалтанд Двайт Нелсоны хэлсэн үгсийг давхар бодох хэрэгтэй байх:

“Сүм чуулганууд маань энэхүү сүльдсэн хэсэгтээ сайжруулж боловсруулсан, сонирхолтой хэлбэрийн, төсөл төлөвлөгөө боловсруулахад анхаарах хэрэгтэй. Хэрэв бид олон ахлагч, удирдагчдаас авагдсан сүнслэг дампуурлыг хүлээн зөшөөрөхгүй бол хэзээ ч зүй ёсны Христэд итгэгчид болж чадахгүй.”⁷⁸

Мөн энэ сэдвээр Деннис Смит дараах зүйлсийг хэлжээ:

“Би төлөвлөгөө төсөл болон аливаа арга замуудын эсрэг зогсохгүй. Гэхдээ Бурханы ажлыг урагш явуулахын тулд эдгээр зүйлсээс ихэд хамаардаг болох вий гэдгээс эмээж байна. Програм, төсөл төлөвлөгөө болон аливаа арга замууд нь Бурханы ажлыг гүйцэлдүүлэхгүй. Мөн сайн номлогч, гайхалтай Христэд итгэгчдийн концерт, сансрын радио ч Бурханы ажлыг гүйцээхгүй. Харин Сүнсээр дүүрсэн эрэгтэй эмэгтэйчүүдээр дамжуулан Бурханы Сүнс Өөрөө ярьж, үйлчилж Бурханы ажлыг гүйцээх болно.”⁷⁹

УСАН БАТАЛГАА /ХҮМҮҮС АВРАХ

Ариун Сүнс бол хүмүүсийг Христ рүү авч ирэх гол угтвар нөхцөл гэдгийг Библи бидэнд харуулдаг. (Үйлс номыг уншаарай.) Германд сүмүүд нэг талаасаа өсөж хөгжиж байгаа ч, нөгөө талаасаа зогсож, хатингаршиж байна. Бидний сүмийн гишүүдийн тоо дэлхий дахинд сүүлийн 60 жилд хорь дахин өссөн. Германд тохиож буй энэхүү нөхцөл байдлын шалтгаануудыг бид тодорхой жагсааж болно. Гэвч нэг зүйл надад маш тодорхой байна. Энэ гол шалтгаан нь Ариун Сүнсний дутагдал юм. Энэ асуудал биднийг хүчтэй бүрхэж байгаа нь ойлгомжтой.

78 Хэлмут Хаубелл (Hrsg.), Missionsbrief Nr. 34, (Bad Aibling, 2011) x 3

79 Деннис Смит, *Дахин ирэлтэд бэлтгэх мөргөл залбирлын 40 хоног*. (Wien, 2012), x. 88

Бид маш олон хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж мөн хэрэгжүүлсэн. Бид шаардлагагүй, амжилтгүй арга замуудыг мөшгөн хөөснөөрөө энэхүү их хүчин чармайлтын үр дүнд Ариун Сүнс дутагдаж маш их мөнгө төгрөг, цаг хугацаа алдсанаа харсан.

“*Бурханы хүмүүс Сүнсэн дотор нэгдэхэд, Еврей үндэстний гэм нүгэл гэж тооцож байсан бүхий л Фарисай үзлүүд болон өөрийгөө зөвтгөсөн байдлууд бүх хүний зурх сэтгэлээс хөөгдөх болно.*”

Энэхүү нөхцөл байдлыг Элен Уайт ийнхүү дүрсэлжээ:

“Огт өөрчлөгдөж шинэчлэгдээгүй гишүүд болон өөрчлөгдөөд эргэж буцсан сүмийн гишүүдийн улмаас Эзэн олон шинэ хүнийг үнэн рүү авч ирэхээр явдаггүй. Эдгээр өөрчлөгдөөгүй гишүүд (махан биеийн Христэд итгэгчид) шинэ хүмүүст ямар нөлөө үзүүлэх бол?”⁸⁰

“Хэрэв бид Бурханы өмнө өөрсдийгөө даруу болгож, сайн сайхан, дөлгөөн зөөлөн сэтгэлтэй байх аваас одоо байгаа ганц нь үнэн рүү өөрчлөгдөн шинэчлэгдэж зуу болон үржиж болно.”⁸¹

Нөгөө талаас харахад, бидэнд хангалттай өөрчлөгдөөгүй баптисм хүртсэн хүмүүс л байна гэж Элен Уайт хэлжээ: “Шинэ төрөлт гэдэг бол энэ үед маш ховор тохиолдол. Энэ нь сүмүүдэд байдаг олон ээдрээтэй асуудлын шалтгаан юм. Маш олон, бүр дэндүү олон хүн Христийн нэрийг ариун бус, бузар байдлаар харуулж байна. Тэд баптисм хүртсэн боловч, амьдаараа булшлагдсан хүмүүс юм. Өөрсдийгөө үхүүлээгүй учраас тэд Христ дотор шинэ амь руу босч чаддаггүй.”⁸²

Үүнийг 1897 онд бичиж байжээ. Тэгвэл өнөөдрийн нөхцөл байдал ямар байна вэ? Дахин төрөөгүй хэн боловч Ариун Сүнсээр дүүрээгүй гэсэн үг юм. Есүс: “-Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” (Иохан 3:5) хэмээн хэлжээ. Бүхий л хэсэгтээ Ариун Сүнсний дутмаг байдалтай байгаа гэдэг нь үнэн биш гэж үү?

80 Элен Уайт, *Сүмүүдэд өгөх гэрчлэл*, боть. 6, (1901) х. 370.3

81 Элен Уайт, *Сүмүүдэд өгөх гэрчлэл*, боть. 9 (1909), х. 189.4

82 Элен Уайт, MS 148 (1897)

АРИУН СҮНС БОЛОН НОМЛОЛ

Бурхан Ариун Сүнс болон номлолын талаар бидэнд ийн хэлж байна: “Бурханы үгийг тунхаглах нь Ариун Сүнсний тусламж болон оршихуйгүйгээр боломжгүй юм. Тэрээр бурханлаг үнэний цорын ганц үр дүнтэй багш юм. Үнэн зөвхөн Ариун Сүнсээр дамжин зүрх сэтгэлд хүрсэн үед л үр дүн сайжирч амьдралыг өөрчилдөг. Магадгүй хэн нэгэн Бурханы үгийг сайн ойлгуулан хэлж болох юм. Тэрээр бүх хууль тушаалуудыг сайн мэддэг байж ч болно. Гэвч Ариун Сүнс нь үнэнийг суурилуулаагүй бол ямар ч хүн Есүст бууж өгөн махан биеийн хүслээ үхүүлэхгүй. Ямар ч мэдлэг боловсролын хэмжээ, давуу талууд болон бусад зүйлс Бурханы Сүнсний оролцоогүйгээр нэг ч гэрэлт зам бий болгож чадахгүй.”⁸³

Үг тунхаглах нь зөвхөн номлолд хамаатай биш бөгөөд лекц, Библи судлал мөн бүлгийн цуглаан дээр ашиглагддаг.

Рэнди Максвелл ийн хэлжээ:

“Яг үнэндээ амьд Бурхантай харилцах харилцаагаар бид ангаж цангаж байсан билээ.”⁸⁴

Айдсаас болж Ариун Сүнсний дутагдалд ордог бол уу? Эмилио Кнэтчли энэ тал дээр зөв хэлж чадсан болов уу? “Яагаад энэ завхарсан дэлхийг бид орвонгоор нь өөрчилж чадахгүй байна вэ? Бидний итгэл үнэмшилд ямар нэгэн буруу зүйл байна уу? Бид зөрчилдөөнөөс айдаг, шинэ зүйлээс айдаг, бэрхшээл зовлонгоос айдаг, ажилгүй болохоос ч айдаг, нэр төрөө алдахаас айдаг, мөн амьдралаа алдахаас айдаг. Тиймээс бид чимээгүй, нуугдаж байна. Бид сайн мэдээг дэлхий дахинд хайраар болон эрх мэдэлтэйгээр тунхаглахаас айдаг.”⁸⁵

Энэ асуудлын шийдэл нь Үйлс 4:31-с олддог: “Ийнхүү залбирч байтал тэдний цугларан байсан газар нь доргин чичирхийлэв. Тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үгийг зоригтойгоор ярьж эхлэв.”

83 Элен Уайт, Үе үеийн хүслэн (1898), х. 671.4

84 Рэнди Максвелл, Хэрэв миний хүмүүс залбирдаг бол ... (Pacific хэвлэл, 1995), х.11

85 CD Die letzte Vorbereitung, Teil 6

АРИУН СҮНС БОЛОН БИДНИЙ УРАНЗОХИОЛ

Хүмүүсийн бичдэг уран зохиолын талаар ийн хэлсэн байна: “Хэрэв Бурханы аврал цааснаа буулган бичдэг зохиолчтой хамт байвал уншиж буй хүнд тэр Сүнс мэдрэгдэх болно. Бурханы Сүнсээр бичигдсэн тэр хэсэг нь тэнгэр элч нарт уншигчдын мэдрэсэн тэр л сэтгэгдлийг төрүүлэх учиртай. Харин бичсэн зохиолч нь Бурханы алдрын төлөө амьдраагүй мөн өөрийгөө бүрэн зориулаагүй бол тэнгэр элч нар гуниг гутрал мэдрэх болно. Тэдгээр үгс нь уншигчдын сэтгэлийг хөдөлгөхгүйгээр алга болно. Хэдий сайн сайхан үгтэй ч Бурханы Сүнс дотор нь байхгүй бол Бурханы Сүнсний дулаан нөлөөгөөр дутагддаг.”⁸⁶

Би үүнийг дахин цохож хэлмээр байна: Бидний төрөлхийн хийдэг бүх зүйл буруу байгаагүй. Утгагүй ч байгаагүй. Бид сайн бүр маш сайн зүйлс хийсэн нь Бурхан хүмүүн бидний хүчин чармайлтуудыг ивээсэн нь тодорхой. Гэхдээ чухал асуулт бол: Бид эдгээр үүрэг даалгавруудад сүнслэгээр ханддаг уу, эсвэл махан биеийн Христэд итгэгчид шиг ханддаг уу гэдэг чухал асуулт байсаар байна. Нэг зүйл тодорхой байна: Махан биеийн сууриар шийдэл олох гэж тэмцэлдэх үед бид ямар ч ашиггүйгээр маш их цагийг дэмий гарздах болно гэдэг нь тодорхой байна.

АРИУН СҮНС: АНХНЫ БОРОО БОЛОН СҮҮЛИЙН БОРОО

“Эхний бороо буюу Ариун Сүнсээр дүүрэн байх нь бидэнд зайлшгүй сүнслэг төлөвшлийг авч ирдэг. Ингэж л бид сүүлийн борооноос шимийг нь хүртэнэ.”⁸⁷

“Сүүлийн бороо нь дэлхийн ургацыг боловсруулдаг. Энэ нь хүний Хүүгийн дахин ирэлтэд сүмийг бэлтгэдэг сүнслэг өвс ногоог ургуулдаг. Гэхдээ анхны бороо ороогүй бол тэнд амьдрал байхгүй, өвсний ногоон ширхэгүүд соёолохгүй. Анхны бороо орж ажлаа хийхээс нааш сүүлийн бороо үрээ боловсруулахгүй.”⁸⁸

86 Элен Уайт, РН 016, х. 29.1

87 Деннис Смит, “Мөргөл залбирлын 40 өдөр”, 2 дугаар ном, (Виенна, 2013), х. 175

88 Элен Уайт, Миний амьдардаг тэрхүү итгэл бишрэл, (1958), х. 333.3

АРИУН СҮНС БОЛОН БИБЛИЙН АРИУСГАЛ

“Энэ ажил нь (Библийн ариусал) зөвхөн Бурханы Сүнсний хүчээр Христ доторх итгэлээр биелэлээ олдог.”⁸⁹

АРИУН СҮНСГҮЙ САЙН МЭДЭЭ ТҮГЭЭХ АЖИЛ БАЙХ УУ?

Маш сайн байгууллагууд, амжилттай баярт мэдээний хөтөлбөр болон хүчирхэг миссион стратегиуд Ариун Сүнсгүйгээр хөгжиж чадах уу? Өмнөд Африкийн шилдэг сайн миссионер Анджо Муррай ийн бичжээ:

“Магадгүй Бурханы хаанчлалын болон Бурханы ном дахь зүйлсийг бахдаж, бясалган бодож, бичиж эсвэл номлож болох ч Ариун Сүнсний хүч чадал илэрхий байхгүй байж болно. Христийн сүмүүдээр номлож, үгийг тунхаглахад яагаад маш бага өөрчлөлт, маш их ажиллавч өчүүхэн мөнхийн зорилгод нийцэх үр дүн мөн итгэгчдийг өөрчлөгдөж, шинэчлэгдсэн ариун байдалд дуудах хүч чадалгүй үгс байсаар байгаа гэж бодож байна? Хариулт: Ариун Сүнсний хүч байхгүйтэй холбоотой юм. Яагаад вэ? Яагаад гэвэл Ариун Сүнсний эзлэх ёстой орон зайг хүний хүч, махан бие эзэлсэнээс өөр ямар ч шалтгаан байхгүй.”⁹⁰

АРИУН СҮНС БОЛОН ЭРҮҮЛ МЭНД

“Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн” Ром 12:1.

“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу? Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн” 1 Коринт 3:16-17.

“Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу? Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун” 1 Коринт 6:19-20. (мөн: Е. Гарсан нь 15:26-г харна уу).

Ариун Сүнсээр дүүрэн хүмүүс бол Бурханы сүм юм. Энэ нь таны амьдралд ямар учир утга агуулж байгааг бодож байсан уу? Сүм бол Бурханы орших газар. Бурхан Мосед ийн хэлжээ: “Би тэдний дунд оршин байхын тулд Надад зориулан тэд ариун газрыг бариг” (Е. Гарсан нь 25:8).

89 Элен Уайт, *Агуу тэмцэл*, (1911), х. 469.3

90 Рэнди Максвелл, *Хэрэв миний хүмүүс залбирдаг бол* (Pacific Press 1995), х. 145

Хэрэв бид энэ илэрхийллийг нухацтай авч үзэн эрүүл мэндээ анхаар-
ваас, амьдралын хэвшил дагалдагчийн амьдралын маань тунгаан бодох
нэг хэсэг болно. Бидний бие Бурханд хамааралтай. Та Бурханы өмч
хөрөнгөд болгоомжтой хандахыг хүсч байна уу? Тиймээ, Бурханы зааврын
дагуу бие махбодоо хамгаалж болгоомжтой хандахыг шаарддаг! Энэ
шаардлагад тодорхой хэмжээний сахилга бат хэрэгтэй. Ариун Сүнсээр
дүүрсэн нэгэн нь энэхүү сахилга батыг ихэвчлэн баяр хөөртэйгөөр хийж
гүйцэтгэдэг. Шагнал нь зүрх сэтгэл, сүнслэг байдал болон бие махбодын
эрүүл мэнд юм. Харин Ариун Сүнсээр дүүрээгүй нэгэн нь сул дорой
байдлынхаа улмаас зовж, тэмцэлдэх болно. Бурхан бидний баяр хөөр,
Түүний үйлчлэл, Түүний алдрын төлөө сүнслэг болон бие махбодын эрүүл
мэндээ хамгийн сайнаар арчилж тордоосой гэж хүсдэг. Энэ хэсэгт мөн л
адил Ариун Сүнснээс өөр орлуулах зүйл байхгүй. Есүс Ариун Сүнсээр
дамжуулан бидний дотор амьдрахад, Тэрээр “Та нарыг эдгээгч Эзэн” (Е.
Гарсан нь 15:26) болдог. Эдгэрэл нь Бурханы алдрын болон тухайн хүний
асуудалд үргэлж сайнаар нөлөөлдөг. Эндээс Бурханлаг эмч хүн бүрийг
эдгээдэг үү гэдэг асуулт гарч болно.

“Нэгэн настай Камбож эмэгтэй Тайландын хоргодох лагерийн эмнэлэгт
очсон байна. Тэрээр буддын шашны гэлэнмаа шиг хувцасласан байв.
Тэгээд тэрээр Др. Есүсээр эмчлүүлмээр байна гэж гуйжээ. Тэгээд тэд түүнд
Есүсийн тухай ярьж өгсөн байна. Тэр эмэгтэй итгэлээ бүрэн өгч, бие,
сэтгэлээ эмчлүүлж чадсан юм. Тэрээр Камбож руу буцаж очоод, 37
хүнийг Христ рүү авчирчээ.”⁹¹

Хезекиа хааныг өвчтэй байх үед Эзэн түүнд “*Үнэхээр Би чамайг
эдгээнэ*” (Хаадын дэд 20:1-11) хэмээн мэдээ илгээжээ. Гэвч Эзэн түүнийг
үгээрээ эдгээхийн оронд яагаад зүсэм инжир тавих даалгавар өгсөн юм
бол? Байгалын эмчилгээнүүд, хоол хүнс, дасгал хөдөлгөөн болон амралт
гэх мэт зүйлсээр дамжуулан бидний оролцоог Эзэн хүсэн хүлээдэг байж
болох уу? Бурхан яагаад Паулыг эдгээлгүй “*биед нь өргөстэй*” үлдээсэн
вэ? Паул өөрөө “*Мөнөөх агуу гайхамшигт илчлэлтүүдээс болж, тэрхүү
шалтгааны улмаас намайг өөрийгөө хэт дөвийлгэх вий хэмээн махан
биед минь өргөс өгөгдсөн юм*” (2 Коринт 12:7-10) гэж хэлдэг. Элен
Уайт: “Бурханы Сүнсний нөлөө бол өвдсөн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн
хүлээн авах хамгийн шилдэг эм юм. Диваажин бол тэр чигээрээ эрүүл
мэнд бөгөөд илүү гүн бурханлаг нөлөөллүүдийг ойлгосноор итгэж буй
өвчтөний эдгэрэл илүү түргэн мөн эргэлзээгүй байх болно” гэжээ.⁹²

91 Үл мэдэгдэх зохиолч, Өдөр бүрийн талх– Мөргөлийн ном (RBC
үйлчлэл), 1993 он 11 сарын 26

92 Элен Уайт, *Эмнэлгийн үйлчлэл* (1932) х.12.3

Нэгэн бизнесмены бичсэн гайхалтай бөгөөд ач тустай гэрчлэлээс хуваалцъя: Тэрээр бүх л эрүүл мэндийн сургалт, семинар өөрт нь нөлөөлөөгүй талаар дурджээ. Харин тэрээр өдөр бүр Ариун Сүнсийг гуйж, амьдралын хэвшлээ эрүүл болгож, ногоон хоолтон болохоор сонгосон байна.⁹³ Ариун Сүнсээр дүүрэн байх нь бидэнд эрүүл амьдралын хэвшлийг баяр хөөртэйгээр сонгох хүч болон урам зориг өгнө.

Нэгэн эмэгтэй энэ зүйлийг уншаад, ингэж бичжээ: Өөрийгөө бүхлээр нь Есүст буулгаж өгөх тэр үед Бурхан миний амьдралыг хормын дотор бүхэлд нь өөрчилсөн юм. Маргааш өглөө нь залбирлынхаа дараа би гал тогоондоо ороод, кофенохоо машины дэргэд зогсож, толгойгоо эгсгсэн өөртөө: Үгүй ээ, би дахин хэзээ ч кофе уухгүй гэж хэлэв. Өмнө нь энэ зүйлийг боддоггүй байв. Учир нь кофеноос гарах гэж оролдох үед миний толгой таван өдрийн турш аймшигтай өвддөг байсан ба шинж тэмдгийг нь зогсоож болдоггүй байлаа. Харин энэ удаад би тохиох үр дагаврын талаар бодсонгүй. Би зөвхөн дахин кофе уумааргүй байгаагаа л санаж байлаа. Өнөөдөр надад кофе уух хүсэл огт байхгүй.⁹⁴ Энэ бол түүний олон өөрчлөлтүүдийн нэг билээ. (Би танд “*Andreasbrief*” 5 дахь хэвлэл Архи тамхины донтолтоос чөлөөлөгдөх нь номыг санал болгож байна.) Энэ нь амлалт болон залбирлаар дамжуулан чөлөөлөгдөх арга замыг тайлбарладаг (зөвхөн Герман хэлээр бий).⁹⁵

Ариун Сүнстэй амьдрал бол эрүүл мэндийн өөрчлөлт шинэчлэлийг маш их дэмждэг. Энэ нь эрүүл мэндийн мэдээлэлтэй холбоотой асуудал юм. Калифорни мужийн Вэймар дахь Олон Улсын Шинэ Гараа хөтөлбөрийн захирал Дон Макинтош ийн хэлжээ:

“Бидний өдөр бүрийн хэрэгцээ бол жирийн эрүүл мэндийн боловсрол биш. Харин бидэнд эрүүл мэндийн маш сайн мэдээ бий. Бидэнд юу хэрэгтэй вэ гэвэл өөрчлөх хүч буюу амьдралд хэрэгжүүлэх хүчийг эрүүл мэндийн мэдээтэй хослуулах явдал юм.”⁹⁶

93 Имэйл 7.3.2013

94 2014 оны 11 сарын 18-нд М-с ирсэн Имэйл

95 *Andreasbrief Nr.5, Sieg Über Tabak und Alkohol*, www.missionsbrief.de – *Andreasbriefe*. Man kann ihn auch beziehen bei Wertvoll leben, Adventist Book Center und TopLife – Wegweiser Verlag.

96 Даве Фиедлер, D’Sozo, (Үлдэгдэгсэд хэвлэл), Forward



Др. Тим Хове ингэж хэлжээ:

“Эрүүл мэндийн боловсрол нь дангаараа эрүүл мэндийн баярт мэдээний ажил биш. Эрүүл мэндийн боловсрол нь авралыг санал болгодог Бурханы хуулиас илүү зүйлийг өгч чадахгүй. Эрүүл мэнд болон авралыг ойлгохын тулд Бурханы өөрчлөгч хүчийг мэдэрсэн байх ёстой”⁹⁷

Эцэст нь, би Итгэлийн эдгэрлүүдийн талаар юу гэж бодож байна вэ? Ариун Сүнсээр дүүргэгдэлгүйгээр хэн нэгэн эдгэрлийг хүсэн хүлээж болох уу гэж асуумаар байна. (Марк 16:17-18; Иаков 5:14-16-г хар).

ЕСҮСИЙН ДАХИН ИРЭЛТЭД БЭЛТГЭХ НЬ

Дахин ирэлтэд бэлтгэхийн тулд Ариун Сүнсээр дамжуулан Есүстэй дотно нөхөрлөх нөхөрлөлийг орлуулах өөр юу ч байхгүй. Ариун Сүнсээр дамжуулан Христ миний дотор амьдрахад, би Түүний нигүүлсэлд багтахад бэлэн болдог гэсэн үг юм.

Христтэй харилцах хувийн харилцаа

Есүс: “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) гэж хэлжээ. “Мэдэх” хэмээх энэ үг нь өнөөдрийн англи хэлнээс илүүтэйгээр Библид гүн утгатай байдаг. Энэ нь бүрэн дүүрэн, олон талын мөн хайрын үйлдэл юм. Энэ нь зөвхөн Ариун Сүнсстэй амьдралд бий болдог зүйл ажээ.

“Бид Бурхантай амьд харилцаа холбоотой байх ёстой. Бид өндөр жишигт хүргэдэг Ариун Сүнсний баптисмын хүчээр хувцаслах ёстой. Үүнээс өөр бидэнд туслах ямар ч гарц байхгүй.”⁹⁸ Арван бүсгүйн сургаалт зүйрлэлд Есүс мунхагуудад нь хандан: “Би та нарыг мэдэхгүй” гэж хэлдэг. Яагаад юм бол? Шалтгаан нь тосгүй буюу Ариун Сүнс дутагдсан явдал юм (Матай 25:1-13). Есүсийг загалмайд цовдолсон хүмүүс Хуучин Гэрээний маш их мэдлэгтэй байсан ч өөрсдийн буруу ойлголтын улмаас Есүстэй харилцах харилцааг олж хараагүй юм.

Дэлхийн төгсгөлийн цаг үед амьдарч буй хүмүүс бид Бурхантай дотно харилцаа холбоотой байх хэрэгтэй гэдгээ мэддэг үү?

Итгэлээр зөвтгөгдөх нь

Хүн төрөлхтөнд өгсөн сүүлчийн захидал болох гурван тэнгэр элчийн мэдээнд “Мөнхийн сайн мэдээг” тунхаглах талаар гардаг (Илч. 14: 6-7). Бүх дэлхий сонсох ёстой энэ мэдээний мөн чанар нь юу вэ? Энэ бол зөвхөн Есүс Христийн дотор итгэлээрээ нигүүлслээр зөвтгөгдөх тухай юм (Ефес 2:8-9). Сүүлчийн цаг үеийн энэ мэдээг тунхаглаж буй хүмүүс

97 Даве Фиедлер, D’Sozo, (Үлдэгдэгсэд хэвлэл), Forward

98 Элен Уайт, *Review and Herald*, 1892 он 4 сарын 5

өөрсдөө энэ мэдээний хүч чадлыг мэдэрсэн байх ёстой. Тэд гэм нүглээс аварч, уучилсан нэгэн болох зөвхөн Есүст итгэх итгэлээрээ зөвтгөлийг мэдэрсэн байх хэрэгтэй. Энэ нь зөвхөн Есүс Христээр дамжуулан Ариун Сүнсээр дүүрэн амьдралд л боломжтой юм. Есүс бидний дотор оршиж байгаа нь бид Бурханы бүх хуулиудад дуулгавартай байгаагаар минь илэрдэг. Дэлхий энэхүү мэдээгээр гэрэлтсэн байх болно. (Илчлэлт 18:1).

Үнэний хайр

Амьдралдаа үнэнийг хэрэгжүүлэх, үнэнийг дээдлэх болон Бурханы үгийг судлахад Ариун Сүнтэй эсвэл Сүнсгүй байх нь бидний амьдралд ямар үр нөлөө үзүүлэх вэ? 2 Тесалоник 2:10-т “... учир нь тэд аврагдах үнэний хайраас татгалзсан” гэж хэлдэг. Төөрөлдөөгүй тийм л хүмүүсийн зүрх сэтгэлд үнэний хайр байдаг. Хэрхэн бид энэ хайрыг авах вэ? Бид зөвхөн үүнийг Ариун Сүнсээр дамжуулан бидний зүрх сэтгэлд Есүс Христ оршсон үед л олж чадна. Ром 5:5-д бидний зүрх сэтгэлд буй тэр хайр нь Ариун Сүнснээс ирдэг гэж хэлжээ. Ефес 3:17-д бид Ариун Сүнсээр дамжуулан “хайр дотор үндэслэгдэн, суурилагдах” болно гэж хэлдэг. Иохан 16:13-т Ариун Сүнсийг “Үнэний Сүнс” гэж дууджээ. Энэ нь бидэнд сүнслэг Христэд итгэгч байхын тулд үнэнийг хайрлах хайр байх хэрэгтэй гэдгийг тодорхой харуулж байна. Эш үзүүлэлтийн бичээсүүд, Бурханы үгс болон үнэнийг хайрлах хайрын талаар өнөөдөр бидэнд асуудлууд байна уу? Биднээс өмнөх цаг хугацаануудыг бодож үзье: “Зөвхөн судрыг дуулгавартайгаар суралцдаг мөн үнэний хайрыг хүлээн авсан тэдгээр хүмүүс дэлхийг боолчилдог энэхүү хүчтэй төөрөгдлөөс хамгаалагдах болно. ... Бурханы хүмүүс өнөөдөр өөрсдийн ухаан боолд бууж өгөлгүйгээр Түүний үгэн дээр бат бөх суурилж чадсан уу?”⁹⁹

Бурхан биднээс бүх үнэнийг нээн илрүүлсэн үү гэж асуухгүй харин үнэнийг хайрласан уу? хэмээн асуух болно.

СҮНСНИЙ ҮР ЖИМС БОЛОН МАХАН БИЕИЙН ҮЙЛС

“Ариун Сүнсний нөлөөлөл бол бидний зүрх сэтгэлд буй Христийн амьдрал юм. Бид Христийг хараагүй мөн Түүнтэй шууд ярьдаггүй. Гэвч Түүний Ариун Сүнс бидэнтэй үргэлж ойр байдаг. Энэ нь бидний дотор ажилладаг бөгөөд Христийг хүлээн авсан хүн бүрээр дамжуулан ажлаа хийдэг. **Ариун Сүнсний оршин байдаг талаар мэддэг тэдгээр хүмүүс Сүнсний үр жимсүүдийг гаргадаг. ...**”¹⁰⁰

99 Элен Уайт, Агуу тэмцэл (1911), х. 625.3

100 Францис Д.Никол, Адвентист Библийн тайлбар, боть. 6 (Хагерстовн, 1980), х. 1112

Сүнсний үр жимс: Галат 5:22: хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал. Ефес 5:9: алив сайн, зөвт байдал ба үнэн.

Мөн Галат 5:16-21-д бидний дотор буй гэм нүглийн хүч чадал нь Ариун Сүнсээр дамжуулан устдаг болохыг харуулдаг.

“Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ. Учир нь махан бие Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махан биеийн эсрэг хүсдэг юм. Яагаад гэвэл хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махан бие ба Сүнс нь нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. **Хэрэв та нар Сүнсээр удирдуулдаг бол Хуулийн дор байхгүй байна.** (Ром 7:23 + 8:1-г хар) Эдүгээ махан биеийн үйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар байдал, тачаангуй байдал, шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулья. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй.” (Галат 5:19-21).

СҮНСЛЭГ БЭЛГҮҮД

“Сүнслэг бэлгүүд гэдэг нь Ариун Сүнсний үйлсээр бий болдог бэлгүүд юм. 1 Коринт 12:28 болон Ефес 4:11-д эдгээр бэлгүүдийг бичжээ: Элч нар, эш үзүүлэгчид, багш нар, гайхамшгийг үйлдэх хүч, эдгээх бэлгүүд, туслах, удирдах ба олон янзын хэлээр ярих чадварыг тавьжээ. Тэр заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгожээ.”¹⁰¹ Мөн Ариун Сүнс нь хүмүүст тусгай зорилгоор өөр авьяас чадваруудыг өгдөг: “Би түүнийг мэргэн ухаан, ойлголт, мэдлэг, бүх талын ур чадварт Бурханы Сүнсээр дүүргэсэн” (Е. Гарсан нь 31:2-6). Уран барилгын (Шастирын дээд 28:12,19).

Бид Есүсийн дагалдагч болохыг хүсэх үед Түүний өмнө бүхлээрээ бууж өгдөг. Тийм учраас бидний бүх авьяас чадвар, сурч мэдсэн зүйлс төдийгүй төрөлх зүйлс бүгд Түүнд харьяалалтай байдаг. Мөн Тэрээр бидэнд авьяас чадвар нэмж өгдөг. Мөн бидэнд байдаг төрөлхийн чадваруудыг цэвэрлэж, ариусгадаг.

Бид Ариун Сүнсээр дутмаг байвал сүнслэг бэлэг авьяасуудтай байж чадах уу?

101 Hrsг. Gerhard Rempel, Schlüsselbegriffe adventistischer Glaubenslehre (Hamburg), p. 44

БУРХАНЫ СОНГОЛТ УУ? ЭСВЭЛ ХҮНИЙ СОНГОЛТ УУ?

Манай дэлхийн сүм ардчилсан бүтэц зохион байгуулалттай. Мэдээж хэзээ ч шилдэг сайн ардчилал гэж байдаггүй. Бид сонголтоо хийхдээ, хүн бүр Бурханы дуу хоолойг хувьдаа сонсоод хувийн саналаа өгдөг. Санал хураалтаар Бурханы дуу хоолойг сонсож, Түүний хүслийг олж мэднэ. Бид ямар нэгэн уулзалтанд орохынхоо өмнө залбирдаг нь тодорхой. Ихэнхдээ саналаа өгөхөөс өмнө хувийн залбирлаар Бурхан хүн бүрт хэрхэн сонголтоо хийгээсэй гэдгийг тодорхой болгож өгсний дараа сонголт явагддаг. Нехемиа ийн хэлжээ: *“Санааг миний Бурхан зүрхэнд минь оруулсан...”* (Нехемиа 7:5) мөн Элен Уайт Нехемиа 1-р бүлгийн талаар ийн хэлссэн байна: *“Түүнийг залбирахад, ариун зорилго түүний оюун бодолд бий болж байв. ...”*¹⁰²

Махан биеийн Христэд итгэгч Бурханы дуу хоолойг сонсох болов уу? Хэрэв тэрээр ухамсартайгаар Есүс Христэд бүрэн бууж өгөөгүй бол Бурханы дуу хоолойг сонсохгүй. (Дуулал 66:18; Дуулал 25:12). Хэн нэгэн махан биеийн итгэгч өөрийн мэдлэг чадвараа дайчлан хамаг чадлаараа чин сэтгэлээсээ сонголтоо хийвэл энэ нь хүний л сонголт. Хүний шийдвэр Бурханы хувьд заль мэх эсвэл нүгэл мэт байдаг.

Удирдагчид Бурханы ажилд маш сайн нөлөөлөл үзүүлдэг. Хэрэв Бурханы дуудсан, хүмүүсийн саналаар сонгогдсон ах дүүс маань удирдаж байвал маш сайн үр дагавар болон ихээхэн өөрчлөлт гарах нь тодорхой.

Би ном уншин залбирч байгаад Бурханаас хэрхэн явах арга замаа асуух хэрэгтэйг ойлгов. (Дуулал 32:8) Бурханы дуу хоолойг чимээгүй сонссон нь миний бүх амьдралыг өөрчилсөн юм. Би энэ талаараа “Бизнесийн төлөөлөгчөөс Пастор” (зөвхөн Герман хэлээр унших боломжтой) хэмээх өгүүлэлдээ бичсэн байгаа.¹⁰³ Мөн түүндээ Курт Хаселийн “Хэрхэн зөв сонголт хийх вэ?” (зөвхөн Герман хэл дээр) хэмээх нэгэн сайн номлол оруулсан.¹⁰⁴ Мөн олон жилийн өмнө Хенри Драммондийн бичсэн “Хэрхэн Бурханы хүслийг мэдэх вэ?” (зөвхөн Герман хэлээр) хэмээх номлолыг ч тэндээс унших боломжтой.¹⁰⁵

102 Элен Уайт, Southern Watchman (www.egwwritings.org), 1904 он 3 сарын 1

103 www.gotterfahren.info – Gott verändert Leben – Vom Prokurist zum Prediger

104 www.gotterfahren.info – Wege zum Ziel: Gott erfahren – Gottes Botschaft für unsere Zeit – Thema Nr. 11

105 Missionsbrief.de – Predigten lesen – Henry Drummond: Wie erkenne ich den Willen Gottes? (Deutsch und Englisch)

2014 оны 10 сарын 24 нд болсон нэгэн явдал: Бид Австрийн Каринтия “Хөдөөний амьдрал дээд сургууль” хэмээх сайн мэдээний төв байгуулах уу үгүй юу? гэсэн асуудалтай тулгарсан юм. Энэ үед дэмжсэн зүйлс мөн эсэргүүцсэн зүйл ч аль аль нь л байлаа. Гол асуудал нь Бурханы хүсэл юу вэ гэдэг л байв. Бид барих эсэхээ ярилцахаас илүүгээр энэ тал дээр Бурханы дуу хоолойг сонсож, хариултыг нь 10 сарын 23-ны залбирлын цуглаан дээр шийдэхээр арван өдрийн түрш залбирал хийлээ.

Залбирлын цуглаанд 20 гаруй хүн нэгдсэн юм. Залбирч нөхөрлөсний дараа хүн бүр Эзэнд чимээгүй цаг гарган тэр барилгыг барих уу үгүй юу гэдгийг асуулаа. Бурханаас хүн тус бүрт хариулт ирснийг дараах байдлаар авав: Хэрэв барих хэрэгтэй бол жижиг цаасан дээр “+” гэж бичнэ. Хэрэв барих хэрэггүй бол “-”. Хэрэв хариулт аваагүй бол “0” гэж бичнэ. Хариултандаа итгэлгүй байгаа мөн өөр зүйл давхар орж ирвэл “?” гэж бичнэ хэмээн тохиролцлоо. Үр дүнд нь Бурханы гайхалтай удирдамжийг авсан юм: Хариултанд “+” тэмдэг 14 ширхэг. “+?” тэмдэг 4 ширхэг. “0” тэмдэг 6 ширхэг мөн хоосон цаас болон тоологдоогүй тодорхой бус 3 хариулт байсан юм. Тэгээд барих хэрэгтэй гэдэг дээр Бурханы удирдамж маш тодорхой гарлаа. Энэхүү дэлхийн төгсгөлийн өдрүүдэд бид Бурханы зөвлөгөөг илүү ихээр эрэлхийлж байх хэрэгтэй гэдэгт би итгэдэг.

Иоел 2:28-29–д энэ талаар харуулдаг. Элен Уайт: “Бурхан бидний зүрх сэтгэлд ярьж буйг дотроо сайн сонсох хэрэгтэй. Түүний өмнө чимээгүй хүлээн сууж, бусад бүх чимээ намдахад, зүрх сэтгэл дэх нам гүм байдал нь Бурханы дуу хоолойг илүү тод болгодог. Тэрээр бидэнд ‘Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд’ Дуулал 46:10 хэмээн хэлдэг.”¹⁰⁶

МӨНГӨ

Мөнгөтэй харьцах болон мөнгө олох тал дээр махан биеийн болон сүнслэг итгэгчдийн хооронд ямар ялгаатай вэ? Бид өөрсдийгөө Бурханы нярав эсвэл өөрсдийнхөө эд баялагийн эзэмшигч гэж хардаг уу? “Өнгө үзэмж болон мөнгийг хайрлах нь энэ дэлхийг хулгайч дээрэмчдийн үүр болгодог. Сударт Христийг дахин ирэхээс өмнө шунал дарангуйлал зонхилох болно гэж хэлжээ.”¹⁰⁷

106 Элен Уайт, *Үе үеийн хүслэн* (1898), х. 363.3

107 Элен Уайт, *Эш үзүүлэгчид ба Хаад* (1917), х. 651.1

БУРХАНЫ ЭЛЧ НАР БУРХАНААС ЭМЭЭГЧ ХҮМҮҮСИЙГ ХАМГААЛДАГ

Бурханы тэнгэр элч нар Бурханаас эмээгч хүмүүсийг хамгаалдаг. “ЭЗЭНий тэнгэр элч Түүнээс эмээгчдийн эргэн тойронд байж, тэднийг авардаг” (Дуулал 34:7). “Христийн дагалдагч бүрт хамгаалагч тэнгэр элч томилогдсон. Эдгээр харгалзагчид зөвт нэгнийг бүзар муугийн хүчнээс хамгаалж байдаг.”¹⁰⁸ – Бурханы хамгаалалтанд Түүнээс эмээдэг, Христийг дагадаг, зөвт хүмүүс багтдаг талаар бичсэн байдаг. Энэ нь өөрсдийгөө Христэд итгэгч гэж үздэг бүх хүмүүст хамааралтай юу? Мөн Бурханд өөрсдийгөө бүрэн даатгаж өгөөгүй тэдгээр хүмүүст хамаарах уу? Энэ нь балчир хүүхдүүдийн хувьд хамаатай юу? Учир нь Есүс Матай 18:10-д: “Та нар эдгээр багачуудын нэгийг нь ч бүү басамжил. Би та нарт хэлье. Тэнгэр дэх тэдний тэнгэр элч нар нь тэнгэрт байгаа Миний Эцэгийн нүүрийг байнга хардаг юм” гэж хэлсэн. Амьдралаараа Бурханд итгэж найдсан Давидад айдсын ямар ч үл мөр байхгүй байжээ: “ЭЗЭН бол миний гэрэл болон миний аврал юм. Хэнээс би эмээх юм бэ? ЭЗЭН бол миний амийн хамгаалалт юм. Хэнээс би айх юм бэ?” (Дуулал 27:1)

(Би танд Агуу тэмцэл номын 31-р бүлэгт сайн тэнгэр элч нарын үйлчлэлийн талаар бичсэнийг уншихийг санал болгож байна. Энэ нь Бурханы хүүхэд бүрт маш их баяр бахдалтай зүйл билээ.)

ТӨГСГӨЛИЙН ҮГС

Бид зөвхөн хэдхэн хэсгийг авч үзлээ. Мөн нэмж оруулж болохуйц амьдралын болон итгэлийн олон асуудлууд бий. Гэхдээ энэ олон асуудлууд бүгд дараах үнэнд хамаатай:

Ариун Сүнстэй амьдралд сул тал нэг ч байхгүй. Өөрөөр хэлбэл Ариун Сүнсгүй амьдралд давуу тал нэг ч байхгүй гэсэн үг юм. Энэ нь бидэнд өдөр бүр Ариун Сүнсээр дүүрэхийг гуйх болон Бурханд амьдралаа зориулах маш том шалтгаан биш гэж үү?

“Хэдэн жилийн өмнө Боенг 707 онгоц Токиогийн нисэх онгоцны буудлаас Лондонг чиглэн ниссэн байна. Маш хүчтэй хөөрлөө. Бүх зүйл хэвийн тунгалаг бөгөөд тэнгэр цэлмэг байв. Удалгүй зорчигчдод Фужи уул харагдлаа. Гэтэл онгоцны нисгэгч гэнэт зорчигчдод энэ сайхан үзэгдлийг харуулж, Фужи уулыг тойрон нисэх санаа төрөв. Тэрээр нислэгийн тогтсон чиглэлээ харагдаж буй жимээр өөрчиллөө.

Гэтэл хяналтын холбооноос тасарч, зөвхөн харж буй зүйлээс шалтгаалан жолоодож байв. Нисгэгч доор нь уул байгааг харж байлаа.

108 Элен Уайт, Агуу тэмцэл (1911), х. 512.2

Түүний өндөр хэмжигч 4000 метрийг зааж байжээ. Харин тэрээр юуг харахгүй байсан гэвэл Фүжи уулын эргэн тойронд салхилдаг хүчтэй салхи болон салхины урсгалыг харахгүй байлаа. Боенг 707 салхинд тэссэнгүй. Онгоц агаарт сүйрч, бүх зорчигчид нь нас барсан юм.”¹⁰⁹

Махан биеийн итгэгчид “Харагдах нислэгийн тохиргоон дээр” амьдардаг. Тэрээр бүх шийдвэрийг өөрөө гаргадаг. Маш их зоривч бүтэлгүйдэг. Харин сүнслэг итгэгчид өөрийг нь аюулгүй чиглүүлдэг Эзэндээ итгэж найдсан, хайрын харилцаанд Ариун Сүнснэйгээр амьдардаг.

Залбирал : Тэнгэрийн Эцэг минь бидний ажил болон амьдралд эерэг өөрчлөлтүүдийг хийдэг Ариун Сүнсээр дамжуулан миний дотор орших Есүсийн төлөө талархъя. Ариун Сүнсний ажлыг илүү ихээр олж харахын тулд нүдийг минь нээгээч. Есүсийн бидэнд өгөхийг хүсдэг бүрэн дүүрэн амьдралыг Түүгээр дамжуулан бидэнд өгөөч. Дараагийн бүлэгт энэ асуудлын шийдлийг олж, амьдралдаа хэрэгжүүлэхэд минь туслаарай. Баярлалаа. Амен.



БОДИТ ҮЛГЭР ДУУРАЙЛД ХҮРЭХ ТҮЛХҮҮР

*Бурханы надад зориулсан шийдлийг амьдралдаа
хэрхэн мэдэрч хэрэгжүүлэх вэ?
Ариун Сүнсээр дүүрэхийн тулд
хэрхэн залбирах вэ?*

ЗАЛБИРАЛ БОЛОН АРИУН СҮНСЭЭР ДҮҮРЭН БАЙХ НЬ

Энэхүү замаар явахдаа Ариун Сүнсийг итгэлтэйгээр гүйж, итгэлээр алхах нь чухал юм. Энэ нь Ариун Сүнсийг гүйн залбирсаныхаа дараа Эзэн бидний залбиралд хариулсан гэдэгт эргэлзэлгүй байж мөн биднийг залбирч байхад Ариун Сүнсээ өгсөн гэдэгт итгэх хэрэгтэй.

Галат 3:14-д (АБ2004): “...Ингэснээр бид итгэлээрээ Сүнсний амлалтыг хүлээн авах юм.” Өөр орчуулганд “...Ингэснээр бид Христэд **итгэх итгэлээрээ** Сүнсний амлалтыг хүлээн авах юм” гэж бичжээ.

Бурхан бидэнд маш их тусламж (Библи, амлалтууд) өгсөн тул тэнгэрлэг Эцэгтээ итгэхэд амар болдог. Бид үүнийг **“Амлалтаар залбирах”** гэж нэрлэдэг.

АМЛАЛТААР ЗАЛБИРАХ НЬ

Эхлээд, нэгэн тус болохуйц жишээ дурдъя. Манай хүүхэд Франц хэлэндээ муу гэж бодъё. Би хүүхдээ Франц хэлээ сайн сурах талаас нь дэмжихийг хүсдэг. Хэрэв тэрээр дүнгийн хуудсан дээрээ сайн дүн авбал би 20\$ өгөхөөр амлалаа. Хүүхэд маань маш их хичээж шамдан суралцаж эхэлнэ. Би ч түүнд тусалж, хүү сайн дүн авлаа. Одоо яах билээ? Хүүхэд маань сургуулиасаа гэртээ ирээд, “Ааваа 20\$” гэж чангаар хэлнэ. Яагаад тэрээр 20\$ авна гэдэгтээ тийм итгэлтэй байна вэ?

Учир нь амлалт өгсөн ба тэрээр шаардлагыг биелүүлсэн. Үнэндээ энэ нь ихэнх хүмүүсийн хувьд хэвийн зүйл юм.

Гэхдээ тэр үед надад 20\$ байхгүй байж болно. Харин Бурханы хувьд Түүний амласан ямар нэг зүйл нь байхгүй байж болох уу? Энэ нь боломжгүй юм!

Эсвэл би амлалтаа буцааж: “Би хүүхдийн боловсролын талаар ном уншсан, хүүхдээ мөнгөөр сурган хүмүүжүүлж болохгүй гэдгийг олж мэдлээ. Тийм учраас би чамд 20\$ өгч чадахгүй” гэж хэлж болно. Харин Бурхан дараа нь бодлоо өөрчилдөг болов уу? Үгүй, Тэр хэзээ ч хэлсэн үгнээсээ буцдаггүй юм!

Бид Бурханаас амлалт аваад, шаардлагыг нь хангахад амлалтыг хүлээн авах гэсэн ганцхан сонголт бий.

Бурхан амлалтаараа биднийг тодорхой чиглэл рүү урамшуулан дэмжихийг хүсдэг. Жишээ нь: Бидний амьдралд Бурханы хүчийг өгдөг Ариун Сүнсийг өгөхөөр амласан. Тэрээр Өөрт нь итгэх нь хялбар байгаасай гэж хүсдэг. Итгэж найдах нь Христэд итгэх итгэлийн төв юм.

Одоо бүгдээрээ амлалтаар залбирах зарим Библийн түлхүүр ишлэл уншъя: 1 Иохан 5:14-15:

“Бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйсан, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм.”

Бурхан Өөрийнх нь хүслийн дагуу залбиралд хариулдаг гэх ерөнхий амлалт өгдөг. Бурханы хүсэл нь Түүний тушаалууд болон амлалтаар илрэн харагддаг. Бид залбирахдаа тэр бүхэнд найдаж болно. Тэгээд 15-р ишлэлд ийн хэлжээ:

“Бид юуг ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид **мэдвэл**, бид **Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ.**”

Энэ нь юу гэсэн үг вэ? Бурханы хүслийн дагуух бидний залбирал нь **Бурханд хүрэх тэр үед хариулт ирдэг**. Гэхдээ бид ихэвчлэн юу ч анзаардаггүй. Бидний залбирал мэдрэмжээр бус харин итгэлээр хариултаа авдаг. Харин мэдрэмж дараа нь ирдэг.

Архи болон никотинд донтсон хүмүүстэй хамт залбирч байхдаа тэдгээр хүмүүс донтолтоосоо салахын төлөө залбирах мөчдөө ямар нэгэн зүйл анзаардаггүй болохыг ойлгосон юм. Тэд итгэлээр хариултаа хүлээн авдаг. Гэхдээ хэдэн цагийн дараа тэд ямар ч архи тамхины хүсэл байхгүй болсныг анзаардаг. Яг энэ мөчид тэд залбирлынхаа **бодит** хариултыг хүлээн авдаг.

Есүс Марк 11:24-т: “Тийм учир Би та нарт хэлье. Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, **түүнийгээ авсан** гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно” гэж хэлжээ.

Элен Уайт: “Бид ивээл ерөөлийн гадаад нотолгоог харах хэрэггүй. Бэлэг нь амлалтанд байдаг бөгөөд Бурхан амласан зүйлээ хийх чадвартай гэдгийг бид өөрсдийн үйлсээрээ баталж болох юм. Бидний аль хэдийнээ эзэмшсэн **тэрхүү бэлэг нь бидэнд хамгийн их хэрэгтэй үедээ л мэдэгдэх болно.**”¹¹⁰

Тэгэхээр бид гадаад баталгаа хайх хэрэггүй. Энд сэтгэл зүйн мэдрэмж хайх хэрэгтэй нь тодорхой байна. Рожер Ж. Морней хэлэхдээ: “Сүнснүүд [чөтгөрийн] Христийн үг болон Түүний эш үзүүлэгчдийн үгийг сонсохоос илүүтэй өөрсдийнхөө мэдрэмжийг дагахыг уриалан дэмждэг. Тэгээд тухайн хүнд юу болж буйг ойлгуулалгүйгээр амьдралыг нь хяналтандаа авдаг нь гарцаагүй юм.”¹¹¹

Амлалт барин залбирах нь Бурханы баялгийг бидэнд нээн өгч байдаг. Мөн тэнгэрлэг Эцэг маань бидэнд дуусашгүй данс нээж өгдөг. “Хэрэв тэд (дагалдагчид) Түүний амлалтад итгэн залбирваас маш том зүйл хүсэн хүлээж болно.”¹¹²

ХОЁР ТӨРЛИЙН АМЛАЛТ

Мөн Библийн амлалтуудыг болгоомжтой ялгах нь маш чухал. “Сүнслэг амлалтууд болох - гэм нүглийн уучлал, Ариун Сүнснийг өгөх болон Түүний ажлыг хийх хүч чадлын амлалтууд бол **үргэлж боломжтой** байдаг (Үйлс 2:38-39). Харин түр зуурын ивээлийн амлалтууд хааяа л ирдэг.”¹¹³

Жишээ нь: Исаиа 43:2 “Чамайг үс гатлахад Би чамтай хамт байна. Голоор туулахдаа чи живэхгүй. Гал дундуур явсан ч чи түлэгдэхгүй, дөл нь ч чамайг шатаахгүй.” Бурхан энэхүү амлалтаа дүрэлзсэн галтай зууханд хаягдсан гурван найзын төлөө гайхалтайгаар биелүүлдэг. (Даниел 3). Харин нөгөө талаас нь үзвэл, хувьсгалч Хаш болон Жероми нарыг Константины шон дээр шатаасан нь тэдний залбиралд хариулт ирээгүй мэт санагдаж болно. Гэтэл бидний мэддэггүй тийм аргаар тэдний залбирал хариулагдсан байж болно. Яагаад? Католик шашинтай зохиолч эдгээр тарчлан зовж нас барсан хүмүүсийн талаар дараах байдлаар дүрсэлсэн байдаг: “Сүүлчийн цаг нь ойртоход тэр хоёулаа их амгалан тайван байв.

110 Элен Уайт, Боловсрол (1903), х. 258.2

111 Рожер Ж. Морней, *A Trip into the Supernatural*, Review and Herald 1982, х. 43

112 Элен Уайт, Үе үеийн хүслэн, (1898), х. 668.1

113 Моррис Л. Венден, *95 Итгэлээр зөвтөгдөх онол*, (Pacific Press 1987), х. 60

Тэд галд шатахад бэлэн болжээ. Тэд зовлон шаналлаас болж уйлж хашгичсангүй. Галын дөл асаж эхлэхэд, магтан дуу дуулж эхэлсэн. Тэгээд галын хүчтэй дөл тэдний дуулахыг зогсоосон юм.”¹¹⁴

Хэрэв хэн нэгнийг шатаахаар бол зүгээр л хашгирч уйлна. Бидэнд харагдахгүй байгаа ч тэдний байгаа байдал нь Бурхан оролцсон гэдгийг харуулж байна. Энэ нь надад түр зуурын амлалтууд ч гэсэн ач холбогдолтой хэвээр гэдгийг харуулдаг.

ХАРИУЛТАНД ТАЛАРХАХ НЬ

Одоо өөр чухал зүйлийг авч үзье: Бидний хүсэлт гүйсан тэр үед өгөгдөхөд, хариулсаных нь төлөө Бурханд талархах нь зүйтэй. Энэ үед илэрхийлж буй бидний талархал нь яг хэрэгтэй үед залбиралд минь хариулсан Бурханд итгэх итгэлийг илэрхийлдэг. Зарим итгэгчид залбирч дуусангуутаа ямар нэгэн зүйл шууд анзаардаг. Гэвч маш олон итгэгч Елишатай адил зүйл мэдэрдэг. Эзэн хүчтэй салхи, газар хөдлөлт, эсвэл галд ч байгаагүй харин маш намуухан зөөлөн дуугаар сонсогдсон байдаг. (Хаадын дээд 19:11-12). Би ч мөн адил ийм зүйл мэдэрч байсан.

Их удсаны эцэст юу ч болсонгүйдээ гэж би бодов. Гэнэт би миний дотор өөрийн мэдэлгүй маш олон өөр зүйлс орон зайгаа эзэлснийг анзаарсан юм.

МИНИЙ БОДЛЫГ ӨӨРЧЛӨӨЧ

Миний бодлыг өөрчлөөч гэдэг нь яг **энэ мөчид бодлоо өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэсэн үг юм.** “... Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж ...” (Ром 12:2).

Тэгээд Миний залбиралд хариулсанд баярлалаа гэж хэлэх хэрэгтэй. Миний гүйлтыг аль хэдийн өгсөнд баярлалаа. Яг хэрэгтэй цагтаа би хүлээн авах учраас баярлалаа.

Энэ нь арга саам хэрэглэж байгаа гэсэн үг биш. Харин үүгээр өөрийгөө итгүүлж байгаа хэрэг юм. Амлалтаар залбирах үед, бодолд минь бурханлаг үндэс суурь орж ирдэг. Учир нь би итгэлээр аль хэдийн хариултаа авсан юм. Хэрэв би Бурханд итгэхгүй харин өөрийн мэдрэмжиндээ найдаж байгаа бол энэ хандлагаараа би Бурханыг худалч болгож, юу ч хүлээн авахгүй.

Юуг ч анзаараагүй ч үүний дагуу үйлдэх нь бас чухал юм. Бурхан үргэлж итгэхэд шаардлагатай зүйл өгдөг. Тэрээр биднийг Өөрт нь

114 Элен Уайт, *Агуу тэмцэл*, (1911), х. 109.3 Neander, “Kirchengeschichte”, 6.Per., 2. Abschnitt, 2. Teil, §69; Hefele „Konziliengeschichte“ Bd. VI, S.209

итгээсэй гэж хүсдэг. Иордан голыг гаталсан талаар бодоод үзээрэй. Эхлээд тахилчид усан дотор ороход ус хуваагдсан. Нааман эдгэхээсээ өмнө усанд долоон удаа булхдаг.

Магадгүй та: “Би үүнийг хийж чадахгүй. Мөн би үүнийг төсөөлж ч чадахгүй” гэж хэлж болох юм. Бидний тайлбарлаж чадахгүй маш олон зүйл бий гэдгийг санаарай. Энэ өдрийг хүртэл, бид цахилгаан гэж юу болохыг мэдэхгүй. Гэсэн ч бид цахилгааныг ашигладаг. Өнөөдрийг хүртэл, хүүхдүүд хэрхэн хэлд ордог болохыг бид мэдэхгүй. Гэхдээ тэд бүгд ярьж сурдаг.

“Бид байгал дэлхийн төсөөллөөс хэтэрсэн гайхамшгуудаар үргэлж хүрээлүүлэн байдаг. Тэгэхээр бидний ойлгож чадахгүй сүнслэг ертөнцийн нууцуудыг гайхах хэрэгтэй гэж үү?”¹¹⁵

Сургаалт үгс 3:5-6-н талаар бодоцгооё: “Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно.” Эндээс бидний замыг чиглүүлж буй энэ амлалтын талаар Бурханаас тодорхой нөхцөл шаардлагыг олж авдаг. Шаардлага бүр нь мөн тушаал юм. Гэхдээ бид шаардлагыг нь биелүүлсэндээ итгэлгүй байгаа ч, маш их хүслээр гуйвал Эзэн шууд хариулж өгдөг. “... хэрэв та хүсэл бий болгохыг хүсвэл Эзэн чиний төлөө ажиллах болно ...”¹¹⁶

Зарим жижиг зүйл ч мөн адил тусалж болох юм: Бид Бурханд хандан амлалт барин залбирч мөн шаардлагыг нь биелүүлчихээд хариулах эсэхэд нь эргэлзэж байвал юу хийж байгаагаа мэдэж байна уу? Бид Бурханыг худалч болгож буй хэрэг юм. Ямар ч нөхцөлд бид ийм байдлыг хүсдэггүй. Энэ тохиолдолд Эзэн миний итгэлгүй байдалд тусална гэдэгт итгэж байна хэмээн залбираарай. Тэгээд итгээрэй!

Элен Уайтын “Боловсрол” номын “Итгэл болон залбирал” хэмээх бүлэгт амлалтаар залбирах тухай маш сайн зөвлөгөө бий.

АРИУН СҮНСИЙГ ЗАЛБИРАН ГҮЙХ НЬ

Бидэнд Ариун Сүнсээр дүүрч залбирах сайн чадварууд бий. Гэхдээ энэ нь Бурханыг бидний хүсэл биелүүлэгч болгох талаар биш харин Түүний найдвартай байдал болон амлалтанд нь итгэх талаар гэдгийг мартаж болохгүй.

115 Элен Уайт, *Боловсрол* (1903), х. 170.1

116 Элен Уайт, *Ерөөлийн уулан дээрх сургаал* (1896), х. 142.1

Ариун Сүнсийг хүлээн авах амлалтууд

Эзэн бидэнд Ариун Сүнсийг хүлээн авах талаар гайхалтай амлалт өгсөн:

Лук 11:13 “Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг **Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв!**”

Тэнгэрлэг Эцэг минь энд биелүүлэх үүрэг даалгавар өгөөгүй гэж үү? Энэхүү гайхалтай амлалтын шаардлага нь: гуйх юм. Есүс нэг удаа гуйх биш харин тогтмол байнга гуйн залбирч байхыг уриалсан.

Гэсэн хэдий ч, энд гол утгыг харах нь чухал юм. Мөн адил төстэй зүйлийн талаар өгүүлдэг өөр ишлэл унших хэрэгтэй. Жишээ нь:

Үйлс 5:32: “Эдгээрийг бид төдийгүй Түүнийг дагагсдад Бурханы өгсөн Ариун Сүнс гэрчилж байна гэв.”

Шаардлага нь: Дуулгавартай байдал! Ганцхан ишлэл хангалттай гэж бодож болохгүйг харж байна. Мөн тэрхүү амлалтын утгыг нь бодож үзэх хэрэгтэй. Энэ нь бидэнд таатай зүйлийн төлөө нэг удаа дуулгавартай байх талаар биш. Харин бидний найз, гайхамшигт Аврагч болох Түүнийг дуулгавартай дагах асуудал юм. Дуулгавартай байдал нь баяр хөөрийг бий болгодог. Өглөө бүр дуулгавартай зүрх сэтгэлээр залбираарай. Түүний хүсдэгийг хүсэх мөн энэ бүхнийг биелүүлэхэд туслахыг Эзэнээс залбиран гуйгаарай. Энэ нь шаардлагыг хангахад тусална.

Иохан 7:37: “Хэрэв цангасан хүн байвал, Над уруу ирж, уугтун.”

Энэ нь Ариун Сүнсийг хүсэх хүсэлтэй холбоотой зүйл билээ. Хэрэв танд ямар ч хүсэл байхгүй эсвэл маш бага хүсэл байвал Ариун Сүнсийг хүсэх хүслийн төлөө залбираарай. Энэ бол шууд хариулт авах Бурханы хүслийн дагуу залбирал юм. Гайхамшигийн Бурханаас асуухад Тэрээр бидний дотор “Хүсэл болон ололт амжилтыг” бий болгож өгдөг. Бид мөн Бурхантай ойр дотно харилцаатай байх, бүх зүрх сэтгэлээрээ Түүнийг хайрлах, Түүнд баяр хөөртэйгөөр үйлчлэх, Есүсийн төлөө тэмүүлсэн хүсэл, Бурханы хаанчлалын дахин ирэлт, Бурханы үгийг судлах мөн түүнээс суралцах хүсэл, төөрөлдөгсдөд туслахад бэлэн байх гэх мэт зүйлийг залбиран гуйж болно.

Иохан 7:38-39: *“Надад итгэдэг хүн “Түүний дотроос амийн усны гол урсах болно” гэж Сударт хэлсэнчлэн байх болно гэв. Есүст итгэсэн хүмүүсийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ.”*

Нөхцөл шаардлага нь: Итгэл! Бидний Бурханд найдах найдлага болон Есүс Христэд итгэх итгэл бол Ариун Сүнсийг хүлээн авах гол нөхцөл юм. Гэхдээ бид амлалтаар залбирах үед итгэхэд хялбар болдог.

Галат 5:16: *“Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ.”*

Бидэнд тушаал мэт өгөгдсөн амлалт бий. Бурхан намайг Ариун Сүнсээр дүүргэхийг хүсдэг нь Сүнсээр алхуулахыг хүсдэг болох нь тодорхой. Бид Ариун Сүнсээр дүүргэгдсэн үедээ махан биеийн хүслийн дор огт байхаа больдог. Ариун Сүнс бидний доторх нүглийн хүчийг устгадаг (Ром 8:1-17, ишлэл. 2). Ариун Сүнсний хүчээр бидний *“Махан биеийн үйлс”* үхдэг (Ром 8:13). Өөрийнхөө талаар Паул *“Би өдөр бүр үхдэг”* гэж хэлжээ. Энэ бол махбодын үйлсийг үхүүлж (Галат 5:18-21), Сүнсний үр жимсийг ургуулах нь (Галат 5:22) гайхамшигтай үнэ цэнэтэй гэдэг талаар юм.

Өрөөг битүүмжилсэн байхад ямар ч шороо орж ирдэггүйг гэм нүгэл бидний амьдралыг өвчлүүлэхгүй байхтай харьцуулж болно. Энэ нь хаалга нээлттэй байхад агаар гаднаас орж ирдэг. Шороо орж ирдэггүй. Яг үүнтэй адил бид Ариун Сүнсээр дүүрсэн үед *“Махан биеийн хүслээр дүүрэхгүй.”* (Энэ талаар нэмэлт мэдээллийг *“Хүн сүнслэг хэвээр үлдэж чадах уу?”* хэмээх төгсгөлийн бүлгээс уншаарай.)

Ефес 3:16-17&19: *“Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилад, мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай. ... Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.”*

Магадгүй бид маш удаан хугацаагаар ямар нэгэн хүч анзаарахгүй байж болно. Энэ нь яг л байгал шиг юм. Модод өвөл хувхайрч харин зун ногоордог. Энэхүү сэргэн шинэчлэгдэж буй ажилд ер бусын хүч байна. Гэвч үүнийг харж, сонсож чаддаггүй. Харин дараа нь бид үр дүнг нь хардаг. Энэ арга надад нөлөөлсөн юм. Бурхан надад хангалттай хүч өгсөнд талархъя.

Өөр нэгэн жишээ дурдъя: Бидний биед хэдэн арван цахилгааны гүйдэл урсаж байдаг гэдгийг мэднэ. Тэд байх ёстой газраа байж л байдаг. Харин бид тэднийг мэддэггүй.

Ефес 5:18: “... Харин Сүнсээр дүүрэн бай” эсвэл “Өөрийгөө тасралтгүй дахин дахин Сүнсээр дүүрэн байлга.”¹¹⁷

Үйлс 1:8: “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв. ...”

Дагалдагчид хүч иртэл хүлээх үүрэг авсан. Харин тэд хий дэмий хүлээсэнгүй. “Дагалдагчид өдөр бүрийн харилцаандаа гэм нүгэлтнүүдийг Христ рүү чиглүүлэх үгсээр ярьж хүмүүстэй зохицохоор чинь сэтгэлээсээ залбирч байлаа. Бүх ялгаатай талуудаа хойш тавьж, бүх хүслээ үхүүлэн Христийн дотор нөхөрлөн дотносов.”¹¹⁸ Бид мөн энэ амлалтаар залбирч болно.

СӨРӨГ ҮР ДҮН...?

“Нэгэн залуу Ариун Сүнсээр дүүрэхийг хүсэн зөвлөгөө авахыг хүсэж байлаа. Тэрээр үнэхээр дотоод асуудалтай байв. Пастор түүнээс: “Чи Бурханд өөрийн бүх хүслээ өгсөн үү?” гэж асуужээ. Гэтэл тэр “Би бүгдийг нь өгсөн гэж бодохгүй байна” гэв. Тэгтэл пастор “За, тэгвэл чи Бурханд өөрийн бүх хүслээ өгөхөөс нааш залбирахад чинь ямар нэгэн сайн зүйл болохгүй гэж хэлэв. Чи одоо Бурханд өөрийн бүх хүслээ өгөхийг хүсэхгүй байна үү? “Би чадахгүй” гэж тэр хариулав. ‘Тэгвэл үүнийг Бурхан чамд хийж өгөхийг хүсч байна үү?’ гэхэд ‘тиймээ’ гэж тэр хариулав. ‘Тэгвэл одоо үүнийг хийхийг Бурханаас гуйгаач’ гэхэд тэрээр ингэж залбирлаа: ‘Өө Эзэн минь хүслүүдээс минь намайг чөлөөлөөч. Бүх талаараа Таны хүслийг дагахад минь туслаач. Миний хүслийг үхүүлээч. Есүсийн нэр дээр амен гэж залбирлаа.’ Тэгээд пастор: ‘Одоо энэ бүтсэн үү?’ гэж асуухад, ‘Энэ бүтэх ёстой.’ Учир нь ‘Би Бурханы хүслийн дагуу зүйл гуйсан бөгөөд залбирсан зүйлээ би авсан гэдгээ мэдэж байна. (1 Иохан 5:14-15)’. Тиймээ, энэ бүтсэн,- миний хүсэл үхсэн” гэхэд, пастор ‘Одоо Ариун Сүнсний баптисм хүртэхийг хүсэн залбир гэв.’ Тэгээд тэр залуу ‘Өө Эзэн минь одоо намайг Ариун Сүнсээрээ баптисм хүртээгээч. Есүсийн нэр дээр Амен хэмээн залбирлаа.’ Өөрийн хүслээ үхүүлэхэд энэ нь шууд хариултаа авсан юм.”¹¹⁹

117 Johannes Mager, *Auf den Spuren des Heiligen Geistes*, (Lüneburg, 1999), Seite 101

118 Элч нарын үйлс, 37.1. egwwritings.org

119 Reuben A. Torrey, *Der Heilige Geist – Sein Wesen und Wirken* (Frankfurt, 1966), p. 15

ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ТОМ ЯЛГАА

Би их удаан хугацаанд амлалтаар залбирахыг мэддэг байсан ч үүнийгээ зөвхөн онцгой нөхцөл байдалд ашиглаж гайхалтай хариулт авдаг байсан юм. Гэвч олон жилийн турш тодорхой амлалт хэлэлгүйгээр Ариун Сүнснийг гүйж болно гэж боддог байжээ. Олон хүн ийм бодолтой байдгийг ч би мэднэ. Үүнд ямар нэгэн буруу зүйл байгаа гэж би хэлмээргүй байна. Гэхдээ би өнгөрснөө эргээд харахад, залбирахдаа ямар ч амлалт хэлэлгүйгээр залбирдаг байсандаа харамсдаг юм. Одооноос хэдэн жилийн өмнө би өдөр бүр Ариун Сүнснийг амлалт хэлэн залбирч байгаа бөгөөд залбирсаныхаа дараа би Ариун Сүнсээр дүүрсэн гэдгээ баттай мэдэрдэг. 2011 оны 10 сарын 28 нд би амьдралынхаа өмнөх болон дараах ялгааг олж харсан юм.

Амлалт сануулан залбирдаг болсноос хойш Бурхантай харилцах миний харилцаа илүү ойр дотно болж, Есүс надад илүү ойртож, миний хувьд илүү эрхэм Нэгэн болсон. Энэ нь зүгээр нэг мэдрэмж байгаагүй; би үүнийг дараах зүйлстэй холбож дэлгэрүүлэе:

- ▶ Библи уншиж байхад ихэнхдээ шинэ, урам зориг өгсөн гүн ойлголт авдаг.
- ▶ Тэмцэл зөрчилдөөнтэй зүйл дээр ялалт байгуулдаг.
- ▶ Залбирлын минь цаг эрхэм нандин болж, маш их баяр хөөр өгдөг болсон.
- ▶ Бурхан миний маш олон залбиралд хариулсан.
- ▶ Есүсийн талаар бусдад хэлэхдээ, илүү “Зоригтой” (Үйлс 4:31с) мөн баяр хөөртэй болсон.
- ▶ Найзуудтайгаа илүү нийтэч болсон.
- ▶ Бурханы нигүүлслээр илүү аз жаргалтай амьдарч, Түүний мутарт аюулгүй байдлыг мэдэрдэг болсон.
- ▶ Хүнд хэцүү үед Эзэн намайг гайхалтай аргаар дэмжиж мөн дотроос минь хүчирхэгжүүлдэг.
- ▶ Эзэн надад сүнслэг ямар бэлгүүд өгснийг ухаарсан.
- ▶ Шүүмжлэлээ зогсоосон. Бусад хүмүүс шүүмжлэхэд надад тавгүй санагддаг болсон.

Өөрчлөлт аажмаар явагдсан байжээ. Би үүнийг өдөр бүр Библийн амлалтууд барин Ариун Сүнснийг гуйн залбираад хэсэг хугацаа өнгөрсний дараа л анх анзаарсан юм. Түүнээс хойш би арай л өөр төрлийн Христэд итгэх итгэлийг мэдэрч байна. Өмнө нь Бурхантай цуг байсан ч гэсэн миний амьдрал хэцүү бэрх байжээ.

Харин одоо би баяр хөөр болон хүч чадлыг мэдэрч байна. Пасторын ажил хийж байхдаа, Ариун Сүнсний хомсдолоос болж, сүм, гэр бүл

болон гэрлэлтэндээ гаргасан гарз хохирлынхоо төлөө би их харамсдаг. Энэ бүхнийг би ухаараад Эзэнээс уучлал өршөөл гүйсан.

Харамсалтай нь энэ тал дээр бид өөрөөсөө өөр хэнийг ч өөрчилж чадахгүй гэдэг нь үнэн юм. Мөн алдаа дутагдалтай хүмүүс гэр бүл, сүм мөн олон нийтийн дунд байдаг гэдгийг санах хэрэгтэй.

Бусад хүмүүс энэ асуудлаас болж амьдралдаа харамсахгүйн тулд би хэдэн зүйл нэмж хэлмээр байна.

2 Петр 1:3-4-т Есүстэй харилцах дотно харилцаагаар бид *“Агуу ... эрхэм нандин амлалтуудаар ... дамжуулан бид бурханлаг байдлын нэг хэсэг болж болно”* гэж хэлсэн байдаг.

Өөрөөр хэлбэл Ариун Сүнс нь амлалтуудаар дамжуулан өгөгддөг гэсэн үг юм. Та амлалтуудыг банкны чектэй харьцуулж болно. Бид данс эзэмшигчээс нь гарын үсэгтэй чек аваад үүгээрээ хэн нэгний данснаас мөнгө авч болдог. Бурханы хүүхдүүдийн хувьд (Иохан 1:12) бид Есүсийн гарын үсэгтэй чекээр (амлалтуудаар) өдөр бүр гүйлгээ хийж болно.

Бидэнд данс эзэмшигчийн гарын үсэгтэй чек хэрэгтэй. Амлалт барин залбирахыг дэмжих өөр нэгэн шалтгаан байна: Бурханы үгэнд хүч бий. Яагаад Есүс загалмай дээр Дуулал номоос гурван удаа дурдан залбирсан вэ? Яагаад Есүс цөлд Сатанд соригдож байхдаа Библийн үгсээр Сатаныг хөөж Өөрийгөө хамгаалсан вэ? (Матай 4:4,7,10) Тэрээр: *“Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна”* гэж хэлсэн.

Есүс болох Бүтээгч маань Бурханы үгэнд хүч бий гэдгийг мэдэж байсан. *“Бурханы үгийн амлалт бүрт, тушаал бүрт хүч бий. Бурханы амьдрал Өөрөө тушаалуудыг биелүүлж, амлалтуудыг ухааруулсан юм.”*¹²⁰ Ямар гайхалтай илэрхийлэл гээч! Бурханы хүч болон Түүний амь амлалт бүрт нь бий. Бид амлалтууд барин залбирах үед Бурханы үгсийг өмнөө барьдаг. Бурханы үгийн талаар ингэж хэлсэн байдаг: *“Миний амнаас гарсан Миний үг хүслийг минь гүйцэтгэхгүйгээр, илгээсэн зорилгыг минь хэрэгжүүлэхгүйгээр Над уруу хоосон буцаж ирэхгүй. ...”* (Исаиа 55:11). Миний хувьд би Ариун Сүнсийг амлалт хэлж гуйх болно.

1 Иохан 5:15: *“Бид юуг ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид **Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ**”* хэмээх Бурханы амлалт дээр үндэслэн Ариун Сүнсийг гуйсны дараа Түүнийг хүлээн авсан гэдгээ мэднэ. Харин амлалтгүйгээр залбирахад бидний залбирал хариулагдах байх гэж найддаг. Орой нь бүтэлгүйтлийнхээ талаар гомдоллож байхын оронд ивээл ерөөлтэй өдрийн төлөө үүн шиг залбиралд цаг гаргах нь илүү дээр юм. Би маш их баяр хөөртэйгөөр бичсэн нэгэн имэйл хүлээн авсан юм: *“Бүх л өдрийн турш өөрийн үгсээрээ залбирахын оронд Бурханы удирдамжийг авахын тулд Библийн*

120 Элен Уайт, *Христ рүү төвлөрөх хичээлүүд* (1900), х. 38.2

амлалтуудаар залбирах нь ийм том өөрчлөлт гаргах боломжтой гэж би огтхон ч бодоогүй! Амлалтууд миний хувьд маш чухал байсаар ирсэн. Би үргэлж амлалтуудад итгэдэг байсан ч үүний хүчийг өдөр бүр амьдралдаа хүлээн авах тал дээр бүтэлгүйдэг байжээ. Есүстэй харилцах миний амьдрал илүү гүнзгий, илүү баяр хөөртэй, илүү итгэлтэй мөн амгалан тайван болсон юм. Энэ бүхний төлөө би Бурханд талархаж байна.”¹²¹ Үүний улмаас амлалтаар Ариун Сүнсийг гүйх жишээгээ тантай хуваалцъя гэж бодлоо. Бид өөрсдөө Бурханы үгээс шууд авч залбирч сурах нь их чухал. Хамгийн чухал нь биднийг залбирсаны дараагаар Ариун Сүнсийг хүлээн авсан гэдэг баталгаагаар бидний итгэл хүчирхэгждэг. Бид залбирсан зүйлдээ итгэхэд Ариун Сүнсийг хүлээн авдаг.

121 C.S.-Х.Хаубэйл руу бичсэн имэйл

ӨДӨР БҮРИЙН АРИУН СҮНСНИЙ СЭРГЭЛТИЙН ТӨЛӨӨХ АМЛАЛТАЙ ЗАЛБИРЛЫН ЖИШЭЭ

Тэнгэрийн Эцэг минь, би тань дээр Аврагч Эзэн Есүсийн нэрээр ирж байна. **Та зүрх сэтгэлээ Надад өг** (Сургаалт үгс. 23:26) гэж хэлсэн. Би одоо Танд байгаа бүхнээрээ бууж өгөхийг хүсч байна.¹²² Өөрийн хүслийн дагуу энэ залбиралд минь хариулсанд баярлалаа. Учир нь Таны үгэнд Түүний хүслийн дагуу юуг ч гуйсан бид Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ (1 Иохан 5:15) гэж хэлсэн байдаг. Мөн Та Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй (Иохан 6:37) гэж хэлсэн.

Есүс: “Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь **гуйдаг** хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй” (Лук 11:13) гэж хэлсэн.

Мөн та цаашлаад Танд итгэдэг (Иохан 7:38-39), Таныг дагадаг (Үйлс 5:32), өөрсдийгөө Ариун Сүнсээр шинэчилдэг (Ефес 5:18) мөн Сүнсээр ярьдаг (Галат 5:16) тэдгээр хүмүүст Ариун Сүнсийг өгнө гэж амласан. Энэ бол миний хүсэл. Үүнийг надад биелүүлж өгөөч. Ааваа, энэ л шалтгааны улмаас өнөөдөр надад Ариун Сүнсийг өгөөч гэж чин сэтгэлээсээ гуйж байна. Энэ нь Таны хүслийн дагуух гуйлт залбирал учраас одоо надад Ариун Сүнсийг (1 Иохан 5:15) өгч байгаад баярлалаа. Яг одоо Таны бурханлаг хайрыг хүлээн авсандаа баяртай байна. Учир нь Таны үгэнд **“Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг.”** (Ром 5:5; Ефес. 3:17) гэж бичигдсэн. Дуулал ном дахь **“Миний хүч болох ЭЗЭН, Би танд хайртай”** (Дуулал 18:1) хэмээх ишлэлийг хэлмээр байна.

Таны хайраар хүмүүсийг хайрлаж байгаадаа талархаж байна. Ариун Сүнсээр дамжуулан миний доторх нүглийн хүчийг устгасанд (Ром 8:13; Галат 5:16) баярлалаа. Өнөөдөр намайг дэлхийгээс мөн гэм нүглээс авран хамгаалаач, унасан тэнгэр элч нараас хамгаалаач, сорилт уруу татлага мөн хуучин завхарч доройтсон байдлаас минь хамгаалан авраач (1 Иохан 5:18). Үйлдлээрээ үгээрээ Таны гэрч (Үйлс1:8) байхад туслаач. Залбирлыг минь сонссонд талархаж мөн Таныг магтъя. Амен.

122 “Зөвхөн Христийн хамтрагч нар, зөвхөн Эзэн гэж дууддаг тэдгээр хүмүүс, надад байгаа бүхэн болон би өөрөө бүхлээрээ Таных гэж хэлдэг хүмүүс Бурханы охид хөвгүүд хэмээн хүлээн зөвшөөрөгдөх болно.” Элен Уайт, Үе үеийн хүслэн (1898), х. 523.1

Ариун Сүнсээр дамжуулан Есүс бидний дотор амьдрахыг хүсдэг. (1 Иохан 3:24; Иохан 14:23). Элен Уайт: “Ариун Сүнсний нөлөөлөл бол зүрх сэтгэл дэх Есүсийн амьдрал юм.”¹²³ Петр, Паул болон өөр олон хүнийг өөрчилсөн хүч биднийг ч мөн адил өөрчлөх боломжтой. Тэрээр бидэнд “Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай” (Ефес. 3:16) гэж хэлдэг.

Ариун Сүнсээр дүүрсэн байх нь баяр хөөр, хүч чадал, хайрыг мэдэрч, гэм нүглийг ялсан итгэлийн амьдралын түлхүүр юм. “... Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг.” 2 Коринт 3:17б.

Миний хүлээж авсан нэгэн захидалд дараах зүйлсийг бичжээ: “Сүмийн олон гишүүдийн санал болгосон хосоороо залбирах аргаар өдөр бүр залбирч байгаа. Сүүлийн таван сар би найз охинтойгоо хамт залбирч байна. “Агуу тэмцлийн асуудал зөвхөн хувь хүнд биш мөн гэр бүл, харилцаа, гэрлэлт төдийгүй сүмүүдэд хурцадмал хөгжиж байна. Бурхантай илүү ойр дотно болсноос хойш энэ аргаар амьдралыг хялбар болгож буй Бурханы ажлыг хараад бид үнэхээр их биширсэн.”¹²⁴

СҮНСЛЭГ ХЭВЭЭР ҮЛДЭЖ ЧАДАХ УУ?

Тиймээ! Хэрэв бид үл итгэх байдлыг хөгжүүлэхгүй мөн сүнслэгээр амьсгалж, гэм нүгэлдээ гэмшиж, Бурханы хайр, уучлалыг хэрэгжүүлж мөн Ариун Сүнсээр дүүрсэн итгэлийн залбирлаар шинэчлэгдэж байх аваас сүнслэг хэвээр үлдэж чадна.¹²⁵

Энэ нь яг л бидний хүүхдүүдтэйгээ харилцах харилцаатай адил. Хүүхэд маань дуулгаваргүй байсан ч бидний хүүхэд хэвээр байдаг. Гэхдээ бид харилцаандаа саад тотгор мэдэрдэг. Магадгүй хүүхэд бидний нүд рүү харж чадахгүй байж болно. Энэ зөрчил нь гэмшлээр засагдах болно.

Гэхдээ тухайн хүн аажмаар махан биеийн итгэгч болж хувирдаг. Библи “Нэг удаа аврагдаад, үүрд аврагдана” гэж хэлдэггүй. Бидний гэмт чанар байсаар байдаг. “Эш үзүүлэгчид, элч нарын нэг нь ч гэмгүй хэмээн нэрлэгдэж байгаагүй юм.”¹²⁶

123 Францис Д. Николь *Адвентист Библийн тайлбар толь 6*, (Hagerstown, 1980), х. 1112

124 Е.С.-с *Х.Хаубэйл руу бичсэн имэйл*

125 Хэлмут Хаубэйл & Герард Паддерац, *Gott, Geld & Glaube* (Eckental, 2009), х. 97

126 Элен Уайт, *Элч нарын үйлс* (1911), х. 561.1

Ариун Сүнстэй амьдралаар мөн зүрх сэтгэлдээ Есүс Христтэй байгаа цагт гэм нүглийн хүч устаж, бид аз жаргалтай хүчирхэг Христэд итгэгчийн амьдралаар амьдарч чадна. Бидний зөвт байдал бол зөвхөн Христийн дотор байдаг. *"... Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон юм."* (1 Коринт 1:30). Энэ чухал сэдэв илүү дэлгэрэнгүйгээр удахгүй гарах болно.

Хэрэв бид сүнслэг байхаа больж мөн сүнслэг амьдралыг удаан хугацаагаар үл хайхрах аваас бүцаад л махан биеийн итгэгч болно. Тэгээд дараа нь өрөвч энэрэнгүй Аврагч маань биднийг хүлээсээр байгаа гэдгийг мэдэрдэг.

Бурханы нигүүлслээр шинэчлэгдэж, сүнслэг амьдралаар үүрд удирдуулж амьдрах ёстойг мэдэх нь маш чухал юм. Хэн ч махан биеийн итгэгч хэвээр үлдэх шаардлагагүй.

Ренди Максвел нийтэд болон хувь хүнд юу гэж хэлснийг санацгаая: *"Сүнслэг мөхлийн ойр буй Бурханы сүмийн сэргэлт, хичээл зүтгэлгүйгээр гүйцэлддэг гэж бид боддог үү?"*¹²⁷

Мөнхийн амьдрал, энэ дэлхий дээрх хангалуун амьдрал мөн олон хүний авралын төлөө хийсэн Есүсийн золиос бол хамгийн үнэ цэнэтэй зүтгэл байсан юм. Хамгийн чухал зүйл бол Эзэнтэйгээ өглөөний мөргөл дээр уулзах юм. Энэ үед Тэрээр биднийг хүчээр тоноглодог.

Элч Иоханы талаар ингэж бичсэн байна:

*"Багшийгаа хайрлах хайрын улмаас тэрээр өөрийгөө харахаа больж, өдрөөс өдөрт түүний зүрх сэтгэл Христ рүү тэмүүлж байв. Түүний ууртай, ... зан чанар Христийн .. хүчинд бууж өгсөн байлаа. Сэргээн шинэчлэгч Ариун Сүнсний нөлөө түүний зүрх сэтгэлийг шинэчилжээ. Христийн хайрын хүч Түүний зан чанарыг өөрчилсөн байна. Энэ бол Есүстэй нэгдсэний тодорхой үр дүн юм. Христ зүрх сэтгэлд оршиход, бүхий л мөн чанар өөрчлөгдөн хувирдаг."*¹²⁸

"Таны хуулийн гайхамшигт зүйлсийг Надад харуулахаар нүдийг минь нээгээч." (Дуулал 119:18) Намайг удирдан чиглүүлж байгаад баярлалаа. Мөн би: *"Их олз олсон хүн шиг Би Таны үгэнд баясдаг"* (Дуулал 119:162) хэмээн хэлье.

127 Рэнди Максвел, *Хэрэв миний хүмүүс залбирдаг бол* (Pacific Press, 1995), х. 158

128 Элен Уайт, *Христэд хүрэх зам* (1892), х. 73.1

БИДЭНД ЯМАР ГЭРЧЛЭЛҮҮД БАЙНА ВЭ?

Хувь хүн болон чуулган, сүмүүдийн гэрчлэл

НЭГЭН ЗАЛУУГИЙН ГЭРЧЛЭЛ

“Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд би өдөр бүр Ариун Сүнс миний амьдралд буун ирэх талаар залбирч байлаа. Миний хүсэл бол Есүс миний дотор амьдарч өдөр бүр элбэг хангалуун амьдрах байлаа. Энэ хугацаанд Бурхантай хамт алхсан минь итгэмээргүй байв. Өдөр бүр Ариун Сүнсээр шинэчлэгдэхийг, Түүний хүслийг биелүүлэхийг мөн Есүсийг миний амьдралд орж ирэхийг гуйснаас хойш миний амьдралд Галат 5-д гардаг Сүнсний үр жимс илүү тод харагдах болов. Би Библи уншихдаа илүү баяр хөөртэй болж, бусадтай Христийн талаар хуваалцаж, мөн бусдын төлөө залбирах дэврүүн хүсэлтэй болсон юм. Цаашлавал, амьдралын минь хэвшил гайхалтайгаар өөрчлөгдсөн. Энэ бүхэн Ариун Сүнсийг өдөр бүр гуйсан болон Бурханыг өдөр бүр эрэн хайсны баталгаа гэдгийг би харж байна.” С.Х. Тэрээр цааш нь гэрчлэлдээ:

“Би таныг зургаан долоо хоногийн турш Ариун Сүнсээр дүүргэгдэхийн төлөө өдөр бүр залбиран гуйгаарай гэж уриалмаар байна. Тэгээд юу болохыг нь хараарай.”

СЕРБИ ДАХЬ 40 ӨДРИЙН ЗАЛБИРАЛ

“2010 оны 9 сард бид “Дахин ирэлтэд ээлтгэх мөргөл залбирлын 40 өдрийн номыг” орчуулан хэвлэлтэнд өгсөн юм. Тэгээд бүсийнхээ сүмийн бүх гишүүдэд тараах боломжтой боллоо. Удалгүй бид орон нутгийн сүм, айл өрх болон гишүүдэд 40 өдрийн номын дагуу Ариун Сүнсний сэргэлтийн төлөө өдөр бүрийн болон долоо хоногийн залбирлын цуглаанууд зохион байгууллаа.

Үүнийг хэрэгжүүлэхэд, цуглаануудад бүхэлдээ өөр уур амьсгал бий болж эхэллээ. Идэвхгүй гишүүд идэвхтэй болж, бусдад үйлчлэх илүү сонирхолтой болов. Олон жил бие биетэйгээ маргалдаж байсан тэдгээр (зарим нь бүр хоорондоо ярихаа больсон байсан) хүмүүс эвлэрцгээж, хамтдаа олон хүнд хүрэхийн тулд төлөвлөгөө зохиож эхлэв.

Тэгээд 2010 оны 10 сард жил тутам явагддаг зөвлөгөөн дээр “Шашны сэргэлт шинэчлэл” хэмээх номоо танилцуулав. Бид үүнийг баяртайгаар хүлээн авч, Бурхан манай бүсийн чуулгануудад юу эхлүүлсний үргэлжлэл гэж харж байлаа.

Энэхүү залбирлын цуглаанууд үр дүнтэй байсан бөгөөд илүү дотно нөхөрлөл, бат бөх нэгдэлтэй сүм болон бүсийн ажилчдын дундах ойлголцсон нэгдмэл харилцаагаар үр дүн нь мэдрэгдэж байлаа.¹²⁹

ШВЕЙЦАРЫН ЗУРИЧ ДАХЬ ЗАЛБИРЛЫН 40 ӨДӨР

“Биднийг үнэхээр баярлуулах номыг Пастор бид хоёр хүлээн авсан юм. Дахин ирэлтэнд бэлтгэх залбирал мөргөлийн 40 өдөр, Деннис Смит, Review and Herald хэвлэлийн хороо гэсэн ном байлаа. Энэ ном бол уншихааргүй, зүгээр л хойш тавьчихмаар ном биш байлаа. Энэ номын үндсэн агуулга нь миний амьдралыг өөрчилсөн юм.

Зурич Волпсвинл дэх сүм (ойролцоогоор 100 гишүүнтэй) маань сэргэлт шинэчлэлийн хэрэгцээ маш их байсан тул бид 2011 оны намар залбирлын 40 өдөр хийхээр төлөвлөлөө. Ном бидэнд маш үнэ цэнэтэй нарийн мэдээлэл болон өдөр бүрийн мөргөлийн 40 сайхан санаа өгөв.

Сэдвүүд нь Ариун Сүнсээр дүүрэх, залбирал, номлол, Есүсийн амьдрал болон сүнсэлг нөхөрлөлийн талаар хөндөж байлаа.

Тэгээд бид 40 өдрийн аялалдаа маш их хүлээлт тавин 2011 оны 10 сарын 1 нд эхэллээ. Гайхалтай нь, сүмийн ихэнх гишүүд хамрагдсан юм. Залбирлын хамтрагчид хоорондоо өдөр бүр уулзан залбирч, өдөр бүр мессэж явуулж, мөн өдөр бүр утсаар залбирч байв. Нэг групп нь өглөө бүр 6 цагт мөргөл, залбирлаа хийх гэж уулздаг байлаа.

Бидний 40 өдөр гайхалтай өнгөрөв. Бурхан маш олон хүний залбиралд хариулж ялангуяа тэр үед явагдаж байсан Библийн зөгнөлийн цуврал семинарыг ивээж байлаа. Эдгээр семинарууд бидэнд гайхалтай ивээл өгч байв. Энд маш олон шинэ хүн байсан ба 20 хүн дараагийн зөгнөлийн семинарт бүртгүүлэв. (Дараагийг нь 2013 оны 3 сард болсон ба 50-60 хүн ирсэн бөгөөд энэ нь Зуричд 20 жилийн турш болж байгаагүй тохиолдол юм).

Бурханы Сүнс сүмд маань өөрчлөлт хийж, жижиг бүлгүүд хэрхэн өсөж буйг харж бас сонирхсон хүмүүст Библи судлалын хичээл явуулж буй

129 М. Тражковска, Өмнөд Европын бүс, Белград, www.revivalandreformation.org

идэвхтэй хүмүүсийг харах ямар их баяр хөөр өгдөг гээч. Тэдгээр оролцсон хүмүүс одоо Бурханы Сүнсний ажлыг үргэлжлүүлэн хийх их хүсэлтэй байгаа. Бид Бурханд чин зүрх сэтгэлээсээ талархал, алдар магтаалыг өгмөөр байна.” Бетрис Еггер, Зурич дахь Адвентист сүмээс.

ГЕРМАНЫ КОЛОГН ДАХЬ 40 ӨДРИЙН ЗАЛБИРАЛ

Пастор Жоа Лоце бол Герман гаралтай Бразил хүн юм. Тэрээр 38 жилийн турш сүмүүдэд мөн Бразилийн эмнэлэгт, мөн Өмнөд Америкийн бүсийн чуулганд ажиллаж байжээ. Тэрээр 2012 оны 3 сард тэтгэвэртээ гарсан юм. Тэрээр эхнэрийн хамт Кологнид Португал болон Испаниар ярьдаг сүмүүдэд “Түүний гар хөдөлгөөнөөр” ажиллахаар иржээ.

“Бид Кологнид сүмийн гишүүдийг дэмжиж, шинэ хүмүүс урихаар бяцхан халамжлагч бүлгүүдтэй ажиллаж эхлэв. Бразилд болсон туршлага дээрээ үндэслэн тэрээр Кологнид 40 өдрийн залбирлын товхимол авч ирсэн юм.

Эдгээр материалууд нь Португаль хэлээр байсан бөгөөд Герман, Испани болон Португаль гишүүдтэй сүмүүд баяртайгаар 40 өдрийн залбирал эхлүүлэв. Бид бүгд өдөр бүр найз нөхөд болон танилуудаас бүрдсэн 100 хүний төлөө залбирцгаалаа. Эдгээр хүмүүсийн нэрсийг сүмийн самбар дээр бичсэн байв. 30-35 дахь өдрийн залбирал хүртэл бид эдгээр хүмүүст тэдний төлөө залбирч байгаагаа мэдэгдээгүй. Тэгээд тэр өдөр мэдэгдээд, тэднийг зочдод зориулсан тусгай Шаббатад урилаа.

120 хүн энэ тусгай үйл ажиллагаанд ирэв. Нордрэйн-Вестфалены үйлчлэлийн захирал Кристиан Бадорек сургаал номлов. Зарим зочид өөрсдийнхөө нэрийг самбар дээрээс хараад, баярлан үйлж байлаа.

Дараа нь Бразилаас ирсэн баярт мэдээ түгээгч Антониа Гонзалес 15 өдрийн турш баярт мэдээний цуврал семинар явуулсан юм. Орой бүр тэрээр орчуулагчтай 1 цаг 30 минут номлож байв. Цуврал семинар “Библи таныг гайхашруулаг” хэмээх нэртэй байлаа. Сэдвүүд нь дахин ирэлт болон Даниел, Илчлэлтийн талаар байв. Лекц болон дуунуудаа Португалиас Герман руу орчуулж байлаа. Орой бүр найрал дуучид сайхан дуу дуулж, залбирлаар өндөрлөж байв. Энэ сайхан нөлөөлөлд нь бүгд талархаж байлаа. Сүмийн гишүүн бүр ялангуяа 40 өдрийн залбиралд оролцсон хүмүүс идэвхтэй залбирсан юм.

Бидний сүм 80 хүний багтаамжтай. Гэхдээ 100-с илүү хүн ирсэн. Амралтын өдрүүдээр сүм дүүрч байсан ч бусад өдрүүдэд ойролцоогоор 60 хүн ирлээ. 32 зочин тогтмол ирж байв. Ингээд 8 хүн баптисм хүртэхээр шийдвэр гаргаж, 14 хүн баптисмийн ангид хамрагдаж байна. Жилийн эцэст 13 хүн баптисм хүртсэн юм.

Бидэнд маш олон гайхалтай гэрчлэлүүд тохиолдсон. Орчуулагч олоход хэцүү байв. Нэгэн католик шашинтай багш бидэнд туслахаар болсон ч

тэрээр тийм ч их Библийн мэдлэг туршлагатай биш байлаа.

Тэгээд бид Протестанд орчуулагчийн төлөө залбирлаа. Удалгүй бид ресторанд нэгэн эмэгтэйтэй танилцав. Тэрээр нэгэн Пентокост сүмд Германаас Португаль руу маш сайн орчуулга хийдэг байжээ. Тэрээр бидний баярт мэдээний цувралын орчуулагчаар туслахыг зөвшөөрсөн бөгөөд өөрөө усан баталгаа хүртсэн юм.

Орчуулагч Мариа өөрийнхөө найз Элизабетаа урьж болох эсэхийг асууж билээ. Түүний найз нь Кологид 13 гишүүнтэй нэгэн жижигхэн Колумб сүмийн ахлагч. Тэрээр сүмийнхээ зарим гишүүдтэй ирэв. Түүнээс хойш эдгээр хүмүүсээс хоёр нь усан баталгаанд орсон. Элизабет болон түүний гэр бүл одоо Библи судлалын хичээл үзэж байгаа.

Бидний өөр нэгэн гэрчлэл “Итгэл буюу Норе” сувагтай холбогддог. Нэгэн Герман эмэгтэй Шаббатын талаар болон өөр бусад сэтгэл хөдөлгөсөн зүйл сонсож байгаад “Норе” сүвгийг олж мэджээ. Тэрээр нөхрөө өөртэйгөө хамт сонсохыг хүсжээ. Нөхөрт нь ч мөн адил мэдээ нь таалагдсан байна. Нэгэн өдөр тэд ээж дээрээ зочлохоор замд гарахдаа буруу яваад байгаа мэдрэмж төржээ. Тэгж байгаад тэд замын хажууд Долоо дахь өдрийн Адвентист Сүм гэсэн тэмдэг олж харсан байна. Тэгээд “Норе” сүвгийнхан Адвентистууд гэдгийг мэджээ. Тэр эмэгтэй нөхрөөсөө гадна ээжийгээ ч урьсан байна. Ингээд тэд гурвуулаа баптисм хүртсэн юм.

Орос-Герман эмэгтэйн өөр нэгэн гэрчлэл: Тэрээр 40 өдрийн залбиралд хамрагдсан бөгөөд Оросоор ярьдаг хөршүүдийнхээ талаар залбирч эхэлсэн юм. Түүний залбирч байсан хөршүүдийнх нь нэг нь Библийн Шаббат сахидаг сүм хайж байгаагаа хэлжээ. Тэгээд тэрээр хөрштэйгөө баярт мэдээний цуврал семинарт хамрагдаж удалгүй хоёулаа баптисм хүртсэн юм.

Жеанни хэмээх эмэгтэйн гэрчлэл: Тэрээр Бразилд байхдаа Баптист сүмийн гишүүн байсан бөгөөд Кологид Португалиар ярьдаг сүм хайж байжээ. Тэрээр Адвентист сүмтэй холбоо тогтоож, Библи судлалын хичээл үзэж улмаар баптисм хүртсэн байна. Жеанни өөрчлөгдсөнийхөө дараа Бразилд байдаг Адвентист хамаатан ах руугаа залгаж Адвентист болсон гэдгээ хэлжээ. Энэ нь түүний ээж, эгч мөн Бразил дахь баптист сүмийнхэнд нь том цохилт болсон байна. Бразил дахь ар гэрийнхэн сүүлд нь Адвентист сүмээр Шаббатын талаар мэдэх гэж очив. Энэ нь Бразилд түүний ээж, хоёр эгч мөн бусад хамаатнууд гээд таван хүнийг баптисм хүртэхэд хүргэсэн байна. Одоо тэрээр Аргентинд амьдардаг өөр нэгэн эгчийнхээ төлөө залбирч байгаа. Тэрээр гэр бүлээрээ Бурханы хаанчлалд хамтдаа байхыг хүсдэг.

Бурханы удирдамжийг дагасны улмаас ирсэн өөр олон гэрчлэл бий. Анхны усан баталгаанд 8 хүн орсон бөгөөд Итали, Герман, Перу,

Бразил, Украин, Венесуэл, Колумб болон Оросоос ирсэн хүмүүс байсан.

Намар бид дахиад мөргөлийн 40 өдөртэй холбоотой баярт мэдээний цуврал семинараа хийлээ. Жимми Кардосо болон түүний эхнэр хоёр баярын мэдээг удирдаж байлаа. (Америкт амьдардаг Бразил хүмүүс). Хэдийгээр семинар маань нэг долоо хоног үргэлжилсэн ч эцэст нь бид дөрвөн эрхэм хүнд баптисм хүртээсэн юм. Тэд өмнө нь Библи судлалд хамрагдаж байжээ. Гурван Герман, нэг Итали хүн байлаа.

Баптисм маань Кологнийн 400 гишүүнтэй, үнэхээр сайхан баптисмийн усан сантай төв сүмд болсон юм.

Биднийг ийм сайхан бүхнээр гайхшруулж буй Бурхандаа талархъя. Бурхан үүнээс ч илүү сайхан зүйлс бидэнд бэлдэж байгаа гэдэгт би итгэж байна. Биднийг залбиралдаа багтаагаарай. Жоа Лоце Германы Кологн.

Чухал зуучлан залбирал: “Би эхлээд 40 өдрийн номыг гүйлгэж уншсан юм. Эхний хуудаснаас л миний сэтгэл ихэд хөдөллөө. Бид бусдын төлөө зөвхөн залбираад хангалтгүй юм байна. Харин тэднийг хайрлан халамжлах хэрэгтэй. Энэ нь зуучлан залбирлыг амьд болгодог. Харамсалтай нь, би өмнө нь иймэрхүү байдлаар зуучлан залбирал хийж байгаагүй. Итгэлээрээ амьдарцгаая! Энэ нь залбируулж буй хүнд төдийгүй залбирч байгаа хүнд нь мөн адил чухал гэдгийг олж мэдсэн. Мөн сүмийн гишүүдийн нөхөрлөлийг хүчирхэгжүүлдэг гэдгийг ч ойлгосон. Номын сүүлийн бүлэгт дурдсан шиг тийм нөхөрлөл бий болно гэдэгт найдлаа. Миний нулимс урсаж байв. Учир нь би тиймэрхүү нөхөрлөлийг маш удаан хүсэн хүлээж байсан юм. “Миний доторх Христ” хэмээх энэхүү ном биднийг дэмжин тэтгэж, олон асуудлаас чөлөөлөх болно гэдгийг ойлгосон. “Христ миний дотор байх” тухай олон ном уншсан ч энэ ном хамгийн тус болохуйц ном мэт санагдсан. Энэ номоор дамжуулан таны залбирлын амьдрал хүчирхэгжиж, сүмийн тань нөхөрлөл хүчирхэгжиж мөн зуучлан залбирал тань илүү амьд болно гэдэгт итгэж байна. Энэ ном надад болон сүмд бүр дэлхийд хүртэл итгэл найдвар өгдөг. Энэ номын төлөө Эзэнд талархъя. Дараа нь би 40 өдрийн номын өөр нэг цувралыг уншиж, залбирч Эзэн хүсвэл хаашаа ч хамаагүй номоо авч явахаар төлөвлөж байна.”

Хэдэн долоо хоногийн дараа нэгэн эмэгтэйдээс имэйл хүлээн авлаа. “Би эхлээд таны номыг гүйлгэн уншиж билээ. Тэгээд залбирлын хамтрагчтайгаа мөргөл хийхийг сурч эхэлснээс хойш анх бодож байснаас минь илүү чухал бөгөөд үнэ цэнэтэй гэдгийг олж мэдсэн. Би хийж чадахгүй байсан олон зүйл дээрээ залбирлын хариугаа авлаа. Идэвх зүтгэлтэй залбирлын хамтрагчийнхаа төлөө Эзэнд талархъя.” Х.К

Огт итгэлгүй болов: “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” хэмээх энэ ном надад ер бусаар нөлөөлсөн юм. ... Адвентист гэр бүлд төрсөн учраас би өөрийгөө зөв замаар явдаг гэдэгт итгэдэг байв. Арван ариун бүсгүйн сургаалт зүйрлэл, ялангуяа Ром 8:9-н “Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш” хэмээх ишлэл намайг цохилтонд оруулсан юм. Гэнэт надад Ариун Сүнс байгаа эсэх Тэрээр миний дотор ажиллаж байгаа талаар эргэлзэж эхлэв. Учир нь би амьдралдаа зөвийн “үр жимсийг” түн их эрэлхийлж байсан юм. Шаббатын үдээс хойш би товхимлоо уншиж дуусгахад, гүн гүнзгий ёроолгүй гуниг намайг бүрхлээ. Тэгээд номын төгсгөл дэх залбирлаар залбирахад, миний дотор Түүний хүслийн дагуу өөрчлөгдөж, зүрх сэтгэлээ өөрчлөн, Ариун Сүнсээр дүүрэх гүн хүсэл орж ирэв. ... А.П.

ТҮҮНИЙГ мэдэх нь: “Нэлээн дээр үед би таны номыг уншиж байлаа. Энэ сэдэв миний сэтгэлийг гурван жил зовоож байна. Одоо би “Хувийн сүнслэг сэргэлтийн алхмыг” зүгээр л уншиж эхэллээ. Би үүнд зөвхөн АМЕН гэж л хэлж чадна. Тэдгээр хуудаснуудаас маш олон “Өөрийн гэсэн үзэл бодолтой” болсондоо их баяртай байна. Манай сүм зорилгоосоо хазайж буй мэт сэтгэгдэл төрдөг байлаа. Гол хараагаа алдаж буй тэрхүү мэдрэмжийг би зүгээр л хаячихаж чадахгүй. Ихэвчлэн “Үнэн гэж юу вэ?”, “Бид хэрхэн амьдрах вэ?”, “Эш үзүүллэг хэр чухал вэ?” гэх мэт зүйлс ярьдаг. Би үүнийг буруу гэж хэлэхгүй л дээ. Гэхдээ Бурхан ЯАГААД бидэнд эдгээр зүйлийг өгснийг өнгөцхөн хардаг. Үнэн нь Бурхантай бүрэн нөхөрлөх нөхөрлөл рүү чиглүүлдэг шүү дээ. Эдгээр зүйлс Бурханыг ҮНЭХЭЭР мэдэхэд туслахгүй гэж үү? Тэрээр бүх дэлхийг гартаа атгаж, удирдаж байдаг шигээ бидний амьдралыг хэлбэржүүлж чиглүүлж байдгийг ойлгож, Бурханы агуу байдал болон бүхнийг чадагч гэдгийг мэдэх нь эш үзүүллэгийн зорилго ажээ. Мөнхийн амьдрал гэж юу вэ? Иохан 17:3: ‘Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг МЭДЭХ НЬ мөнхийн амь мөн. ‘Сүйт бүсгүйн сургаалт зүйрлэлд мунхаг охидод зүгээр л ‘Би та нарыг мэдэхгүй’ гэж хэлдэг. Бидний итгэлийн гол зорилго бол зүгээр л Бурханыг мэдэх, ТҮҮНТЭЙ нөхөрлөх юм. Тэгсэнээр Тэрээр (2 Шастир 5:13-14)-д сүмийг дүүргэсний адил биднийг ДҮҮРГЭНЭ. Тэрээр бидэн рүү үлээхэд бидний бүхий л зүйлийг дүүргэж, бид амьдрахаа больж харин оронд нь Христ бидний дотор амьдарна.”

ЗУУЧЛАН ЗАЛБИРЛЫН ГАЙХАЛТАЙ ХАРИУЛТУУД

“Д.Смитийн 40 өдрийн залбирал номын хоёр дахь цуврал нь надад итгэмээргүй ивээл болсон юм. Миний залбирч байсан хүмүүсийн зарим нь амьдралдаа 180° өөрчлөлт мэдэрсэн.

Тэрхүү 40 өдрийн хугацаанд найзтайгаа маш гүн гүнзгий сүнслэг яриа өрнүүллээ. Тэрээр надад амьдрал нь сүүлийн хэдэн долоо хоног өөр чиглэл рүү эргэж байгаа тухай ярих. Түүнд Бурханы үгэнд илүү төвлөрөх мөн өөрийнх нь хувьд үнэ цэнэтэй, хүсдэг зүйлсээ тавьж явуулах тал дээр залбирах хэрэгцээ их байлаа. Надад урам орж, түүнд 40 өдрийн номын тухай хэлж мөн миний залбирч байгаа 5 хүний нэг тэр гэдгийг ч хэллээ. Тэрээр ихэд гайхан: “тэгэхээр чи энэ бүх зүйлийг хариуцна шүү” гэж билээ.

Амьдралаа Бурханд 100% зориулахаар шийдвэр гаргасан охин. Тэрээр хүүхэд байхаасаа итгэгч байсан хэдий ч Бурхангүй амьдарч байжээ. Түүнд итгэлийн талд ямар ч сонирхол байхгүй ба дэлхийн амьдралд бүхэлдээ үрхидуулсан байв. Тэрээр одоо бүрэн өөрчлөгдсөн ба түүнийг мэддэг хүн бүр хараад гайхдаг. Одоо тэр надтай Библи судалж мөн манай сүмийн 40 өдрийн хөтөлбөрт хамрагдаж байгаа ба итгэлийн амьдралын талаар нухацтай авч үзэх тухай хүмүүсийг ятгахыг хүсдэг болсон.

Миний залбирч байсан өөр нэг охин 40 өдрийн залбирлын оролцогчидтой хамт амьдрангаа долоо хоногийн хугацаатай сургалтад хамрагдахаар болов. Тэрээр танихгүй олон хүнтэй хамт байхаас санаа нь зовж байлаа. Түүнийг явахаас нэг өдрийн өмнө би түүнтэй ярилцаж, түүний төлөө нэлээн хугацаагаар залбирсан тухайгаа хэлэв. Тэгээд бид хамтдаа Эзэн түүнд энэ нөхцөл байдалд нь амар тайвныг өгч, залбиралд нь хариулж өгөх талаар залбирлаа. Сургалт болж байх хугацаанд тэрээр над руу залгаж сэтгэл нь ихэд хөдөлсөн байдалтай Бурхан түүний амьдралд итгэмээргүй зүйлс хийснийг хэллээ. Түүнд төгс амар тайвныг өгөөд зогсолгүй орой үдшийн зугаа цэнгэл болох диско, архи гэх мэт зүйлсээс хол байх талаар ухаарал өгчээ.

Бурханы залбиралд хариулдаг гайхалтай арга замуудыг харж, сонссоноос хойш 40 өдрийн залбирлын хугацаа дууссан ч тэдгээр хүмүүсийн төлөө үргэлжлүүлэн залбирч байна. А.М. (товчилсон хувилбар)

ЗУУЧЛАН ЗАЛБИРЛААР ДАМЖУУЛАН БУРХАН ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

“Сүүлийн таван жил миний хувьд нэгэн чухал хүнтэй бүрэн холбоо тасарсан юм. Тэрээр миний захиануудад ч хариулахгүй байв. Түүнийг сүүлийн 3 жил огт сүмдээ яваагүй гэдгийг нь сонссон. (үг нь тэр сүмд өссөн) Тэрээр итгэгч бус эмэгтэйтэй үерхэж байсан юм. Тэр надаас 600 км хол амьдардаг бөгөөд надад хариу өгөхгүй байгаа тул холбоо тогтоох боломжгүй гэж бодож байсан ч энэ залуу хүүг би залбирлын жагсаалтандаа оруулан залбирав.

Түүний ах баптисм хүртэх гэж байгаа талаар халт сонсов. Тэрээр надтай ойрхон амьдардаг бөгөөд “40 өдрийн залбирал” явагдаж байсан тэр үеэр баптисм хүртэх гэж байлаа. Би баптисмын ёслолд очихдоо

дүүтэй нь уулзсан юм. Бидэнд маш дотно ярилцах боломж олдсон бөгөөд тэрээр надад заримдаа Бурхан руу буцаж очих маш их хүсэл байдаг бөгөөд түүнд амьдралын хэмнэлээ өөрчилж чадах хүч байхгүй талаараа хэлэв. Би сүүлийн 20 өдөр түүний төлөө идэвхтэй залбирч байгаа бөгөөд өмнө ч түүний нэрийг залбирлынхаа жагсаалтад бичсэн тухайгаа хэлэв. Тэрээр хэлэх үггүй болсон ба яг миний залбирч байсан тэр үеэр Бурхан түүний дотор ажиллаж байгааг мэдэрсэн байжээ.

Сүнслэг баптисмийн үйл ажиллагааны үеэр пастор тангараг уншиж байхад тэрээр ихэд сэтгэл нь хөдөлсөн ба түүний дотор буй тэмцлийг би мэдэрч байлаа. Удаан тэмцэлдсэний эцэст тэрээр өвдөг сөгдөн унаж үйлсан юм. Тэрээр Бурханд дахин бүүж өглөө. Тэр орой надад тэрээр сүмдээ тогтмол хамрагдаж, амьдралын хэмнэлээ өөрчлөх шийдвэр гаргасан тухайгаа хэлэв. Энэ долоо хоногт түүний дэлхийн амьдралын зам төгсгөл болно гэж тэр огт бодоогүй байх.

Хэдэн долоо хоногийн дараа би түүнтэй залуучуудын чуулга уулзалт дээр уулзаж, дахин түүнийг хүчирхэгжүүлэн босгосон юм. Би Бурханд энэ залуугийн гэмшлийн төлөө талархаж байна.” М.Х.

ГЕРМАНЫ ВАДЕН-ВУЕРТТЕМБЕРГ ЛЮДВИГСБУРГИЙН СҮМ

“Эхэндээ бид 40 өдрийн номыг хосоороо судалсан бөгөөд тэр хугацаанд маш их ивээл ерөөл, ашиг тус мэдэрсэн юм. Дараа нь, сүмдээ долоо хоногт хоёр удаа залбирлын цуглаан зохион байгуулж, номоо сүмийнхээ гишүүдтэй хамт уншив. Тэгээд 40 өдрийн хугацаанд олон гайхамшиг, ивээл ерөөл болон гэрчлэлийг их тод мэдэрсэн юм. Бурхан биднийг сэргээж, шинэчилж байлаа. Танихгүй хүмүүстэй огт ярьдаггүй байсан гишүүд гэнэт өөрсдийн санаачлагаар танихгүй хүмүүстэй ярьдаг болов. Бурхан биднийг хамтын залбирлаар дамжуулан ойртуулж нэг сүм шиг нэгтгэж байв. Бидэнд 40 өдрийн турш таван хүний төлөө залбирсан онцгой гэрчлэл бий. Бурхан онцгой арга замаар тэдгээр хүмүүсийн амьдралд ажилласан юм. Дахин дахин Шаббатын цуглаан дээр гэнэт гудамжнаас хүмүүс орж ирдэг болов. Тэдний нэг гэр бүл бидэнтэй Библи судалж байгаа. Тэд Шаббатын тухай интернетийн бичлэгүүдээс мөн Агуу тэмцэл хэмээх номоос мэдээлэл авсан бөгөөд сүм хайж байжээ.” Катя & Кристиан Шиндлер, Лудвигсбург дахь Адвентист сүм (товчлов.)

40 ӨДРИЙН ТУРШЛАГА

“Бүх зүйл “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам”-с эхэлсэн юм. Тэр үед өдөр бүрийн амьдралдаа Бурханыг хүсэх хүсэл миний дотор бий боллоо. Тэгээд би 40 өдрийн мөргөл, залбирлын номын талаар сонссон юм. Би энэ адал явдлыг мэдрэхийг хүсэж буй нь тодорхой байв. Би өөрөө юунд

орж байгаагаа мэдсэнгүй. Тохиромжтой залбирлын хамтрагч олох нь (хөтөлбөрийн нэг хэсэг) тийм ч хэцүү байсангүй. 40 өдрийн турш өдөр бүр тодорхой цаг гаргах нь миний хувьд асуудалгүй байв. Сувилагч хүний хувьд би ажлын тогтмол цагтай. Би энэ талаар ч бодсонгүй. Бурхан миний шийдвэрийг эхнээс нь ивээж байжээ. Ариун Сүнсийг гүйж энэхүү сэдвийн талаар бие биентэйгээ хуваалцах өдрийн тэрхүү эрхэм нандин цагийг би хүсэн хүлээдэг болов. Залбирлаар бидний амьдралд ямар нэгэн өөрчлөлт гарсныг мэдэрлээ. Бид бие биедээ ярихгүй байж чадсангүй. Ямар нэгэн зүйл болох бүрт бид түүнийгээ хуваалцмаар санагддаг байв. Бусад хүмүүсийг урамшуулан зоригжуулах нь миний хувьд чухал байлаа. Сүмийн зарим гишүүдэд бидний идэвхтэй байдал нөлөөлж, маш хурдан залбирлын хамтрагч нар гарч ирлээ. Бид юу мэдэрсэнээ долоо хоног бүр хуваацахаар болов. Энэхүү халдвар залуучуудаас нэлээн хэдэд нь тархсан юм. 40 өдөр маш хурдан дууслаа. Бид үүнийг зүгээр зогсоож чадсангүй. Тэгээд бид энэ мөргөлийн цагаа Элен Уайтын бичсэн *Эзэн Есүс ирээрэй - Мараната* хэмээх номоор үргэлжлүүлсэн юм. Бурхан биднийг удаан хүлээлгэсэнгүй. 40 өдрийн турш Тэрээр бидний залбиралд гайхалтай хариулт өгсөөр байлаа. Энэ хугацаанд залбирч байсан нэгэн хүн удаан байхгүй байсны эцэст сүмдээ ирсэн юм. Бид маш их жаргалтай байлаа. Миний эргэн тойронд байгаа хүмүүс надад их чухал болж хувирлаа. Бурханы хайрыг бусадтай хуваалцах миний хүсэл маш хүчтэй болж өссөн байв. Ийнхүү миний амьдрал өөрчлөгдсөн юм. Бидний ихэнх нь бие биенээ илүү таньж, ойлгодог болсон. Маш олон хүн нэг нэгнийхээ амьдралд хүндтэй байр суурь эзэлж, өөрсдөө ч тэдний амьдралд тодорхой байр суурь эзлэв. Нөхөрлөл гэдэг зүйл шинэ утгатай мэт болов. Деннис Смитийн 40 өдрийн залбирал болон мөргөл надад маш их тус хүргэсэн. Бидэнд эрхэм нандин хүмүүс үүний төлөө бидэнд талархах болно.” Крайлшем Долоо дахь өдрийн Адвентист сүмийн гишүүн Хилдегард Велкер мэс заслын тасгийн сувилагч. (бага зэрэг товчлов.)

ЕСҮС БИДНИЙ ЖИШЭЭ

Есүс бүх зүйл дээр бидний хамгийн төгс жишээ билээ. Лук 3:21-22-т: “Ард олон бүгдээрээ баптисм хүртэж байх үед Есүс мөн баптисм хүртээд залбирч байх зуур тэнгэр заагдан, Ариун Сүнс биет хэлбэрээр Түүн дээр тагтаа мэт буун иртэл ...” хэмээн гардаг.

Энэ үйл явдлын тухай Элен Уайт ингэж хэлжээ: “Эцэгтээ хандсан түүний залбирлын хариуд тэнгэр нээгдэж, Ариун Сүнс тагтаа мэт Түүн дээр буулаа.”¹³⁰

Түүний үйлчлэлийн турш юу болсон нь гайхалтай. “Тэрээр тэнгэрийн Эцэгтэйгээ өглөө бүр харилцдаг ба Эцэгээсээ өдөр бүрийн Ариун Сүнсний шинэ баптисм хүртдэг байв.”¹³¹ Хэрэв Есүс өдөр бүр шинэхэн Ариун Сүнсний баптисм хүртэх хэрэгтэй байсан юм бол бидэнд хэр их хэрэгтэй байх бол!

131 Элен Уайт, *Цаг үеийн тэмдгүүд*, 1895 он 11 сарын 21

СОНИРХОЛ БА БУСАДТАЙ ХУВААЛЦАХ НЬ

Бусдад өгсөн баяр хоёр нь бидэнд буцаж ирдэг.

(Герман зүйр цэцэн үг)

"Бялхсан амьдралыг" мэдрүүлэхийн тулд

бид тэдэнд хэрхэн туслах вэ?

(Иохан 10:10)

СҮНСЭЭР ДҮҮРЭН АМЬДРАЛД ХЭРХЭН СОНИРХЛОО ӨСГӨХ ВЭ?

Удирдагчид болон сүм, чуулганууд юу хийж чадах вэ? Үүнд удирдагчдын хувьд (чуулганы ерөнхийлөгч, пастор, сүм, чуулганы нарийн бичиг, байгууллагын удирдагчид болон өөр гол хүмүүс) жижиг бүлгүүд, сүмүүд болон сүмийн зөвлөлтэй хамтарч юу хийж болох талаарх боломжуудыг харууллаа.

Боломжууд

- 1. Хосоороо хийх залбирлын бүлэг:** "Мөргөлийн 40 өдрийг" хосоороо эсвэл залбирлын хамтрагчтайгаа судлаарай. Деннис Смитийн "Дахин ирэлтэд бэлтгэх 40 өдрийн мөргөл залбирал"-р эхлээрэй. Хэрэв тохиромжтой байвал дараа нь "Бурхантай харилцаагаа сэргээх мөргөл залбирлын 40 өдөр" номоор үргэлжлүүлээрэй. Гэрлэсэн хосууд мөргөлийг хамт хийвэл энэ нь маш их тустай бөгөөд олон талын үр дүнтэй. Та өөр нэгэнтэй ч хамт энэ мөргөлийг хийж болно. Та хоёр хамт байж болно. Мөн утсаар, Скайпаар болон өөр медиа холбоог ашиглаж болно. Хоёроороо мөргөл үйлдэх нь маш их үр дүнтэй. Мөн Бурханы үгэнд ч хоёроороо залбирах (Матай 18:19) мөн ажиллахыг (Лук 10:1) санал болгодог. Энэ төрлийн мөргөлөөр бусдыг урамшуулах нь хамгийн сайн боломж юм.

2. Ном танилцуулах мөн хуваалцах жишээ:

“Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” товхимол нь (бүх хэл дээр хямд үнэтэй эсвэл төлбөргүй байгаа).

Уншигчдын 80-с илүү гэрчлэл болон 100 гаруй харилцан яриа нь талархал хүлээсэн сайн ном гэдгийг дараах арга замуудаар харуулдаг:

- ▶ Аврагдах үү эсвэл аврагдахгүй юү? гэдэг тал дээр сүнслэг үнэнийг харахад тэдний нүдийг нээж өгсөн: (2-р бүлэгт илүү дэлгэрэнгүй бий)
- ▶ Сүнслэг амьдрал руу хөтлөх зайлшгүй алхмуудыг ойлгосон: Өдөр бүр Есүст бууж өгөх, өдөр бүр Ариун Сүнсийг гуйх [DA 676.2] Ариун Сүнсээр өгөгдөх өөр олон алхмыг харуулсан. (3-р бүлэгт илүү дэлгэрэнгүй)
- ▶ Библийн амлалтуудаар залбирснаар тэд Ариун Сүнсийг хүлээн авсан хэмээх баталгааг авдаг. (5-р бүлэгт илүү дэлгэрэнгүй)
- ▶ Тэдний тэр их баяр хөөр нь номыг тараах болон гэрчлэх шалтгаан болсон.

Олон хүний гэрчлэлээр дамжуулан бид “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” болон “40 өдрийн ном”-н нэг, хоёрдугаар цуврал хамтдаа хамгийн сайн үр дүнд хүрэх юм байна гэдгийг ойлгосон. “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам” нь хүмүүсийн нүдийг нээж, хурдан эхлэхэд гайхалтай тусалдаг. “40 өдрийн ном” нь сүнслэг амьдралыг хүчирхэгжүүлэн, тэлж өгдөг. Цаашилбал, хувийн өглөөний мөргөлд дадлагажуулж, олон залбиралд хариулж өгдөг.

3. Хүндэтгэлийн цаг дээр унших богино уншлага: Цуглаантай өдөр номлолын өмнө Ариун Сүнстэй амьдрах нь номын хэсгээс уншиж болно. (5-10 минут). Санал болгохоор хэсгүүдийг дараагийн хэсэгт дурдсан байгаа. Дараа нь хүмүүс хос болон 40 өдрийн номын зааврыг даган хийж болох юм. (12-р дугаарыг харах).

4. Өөрсдийн ойлгосон хэсгээ сүмийнхээ мэдээллийн самбар дээр тавих эсвэл зарлалын үеэр хэлж болно:

- ▶ Үе үеийн хүслэн, бүлэг. 73: “Таны сэтгэл зовохгүй байж болно.”
- ▶ Элч нарын үйлс, бүлэг. 5 “Сүнсний бэлэг”
- ▶ Христийн зорилгууд, бүлэг. 12 “Өгөхийн тулд гуйх”
- ▶ Баялгийн гэрчлэл боть 3, Сүнсний амлалт, х. 209-215
- ▶ Элен Уайтын мөргөлийн бодлууд “Хүч чадлыг хүлээн авах нь” (бүгд Чуулганы хэвлэлийн хэлтсээс авах боломжтой)

5. Гэрчлэлээ хуваалцах нь: Цуглааны үеэр сүнслэг гэрчлэлүүдээ хуваалцах бүрэн боломжтой. Сүмийн гишүүн, бусад сүмийн гишүүд болон өөр хүмүүсийн гэрчлэл хуваалцаж болно. Та www.steps-to-personal-revival.info just click on: "Testimonies" хэмээх сайтаас гэрчлэл уншиж болно.

6. Шаббатыг эрчимжүүлэх дөрвөн хэсэг семинар: Энэ нь цуглааныг сонирхолтой болгох хамгийн үр дүнтэй арга байж болох юм. Энэ нь 3-4 хэсэгтэй онцгой Шаббат байх болно. Баасан гарагийн оройноос эхлэн Шаббатын үдээс хойш хүртэл байна. Ерөнхий гол сэдэв нь "Хувийн сүнслэг сэргэлтийн алхам"-н програм байж болно: www.steps-to-personalrevival.info сайтыг хараарай:

- ▶ Баасан гарагийн орой бол долоо хоногийн гэрчлэлээ хуваалцах цаг юм. Гэхдээ хамгийн ихээр мэдрэгдэж, нөлөөлсөн гэрчлэлээ ярина. Хэрэв боломжтой бол номлогчоос гэрчлэл сонсох хэрэгтэй. Дараагийн боломж нь "Есүст бууж өгөх" талаар ярилцах. Та үүний талаар "Abide in Jesus" номын 2-р бүлгийн "Есүст бууж өгөх нь" хэсгээс уншаарай.
- ▶ Мөргөлийн үеэр "Хувийн сүнслэг сэргэлтийн алхам"-с номлож болно. Илүү тодорхой болгохын тулд Ариун Сүнсний хомсдолын талаар танилцуулга хэсгээс 2-3 илэрхийлэл дурдаарай. Тэгээд гол санаагаа "Есүс Ариун Сүнсний талаар юу гэж заадаг вэ?" хэмээх нэгдүгээр бүлгээс мөн "Бидний асуудлын гол шалтгаан нь юу вэ?" хэмээх 2 дугаар бүлгээс үргэлжлүүлэн номлоорой. (Үүнийгээ хоёр өөр цагт хувааж номлож болно.)
- ▶ Эхний үдээс хойших уулзалтаар "Бидний асуудлыг шийдэж болох уу? Хэрхэн шийдэх вэ?" хэмээх 3-р бүлгээс гол санааг ярилцаарай.
- ▶ Дараагийн үдээс хойших уулзалтаар "Бодит үлгэр дуурайлд хүрэх түлхүүр" хэмээх 5-р бүлгээс гол санааг нь ярилцаарай.

Сүмдээ "Хувийн сүнслэг сэргэлтийн алхам"-н семинаруудаас аль хэдийн эхэлсэн ч тэд Шаббатаа өөрөөр идэвхжүүлэх эсвэл "Есүстэй хамт" товхимлын 4 бүлгээс ашиглан өөр семинар явуулж болно.

Энэхүү материал хэрэгжиж эхлэхээс өмнө зааврыг танилцуулж мөн маш сайн унших нь Шаббатыг идэвхжүүлэхэд дэмтэй. Мөн Шаббатын дараа амралтын өдрүүдээр 40 өдрийн залбирлын номыг эхлүүлэх нь тустай (12-р хэсгийг хараарай). Мөн "Хувийн сүнслэг сэргэлтийн алхам"-с долоо хоногт нэг бүлгийг системтэй уншиж болно. (7-р хэсгийг хараарай).

7. Системтэй уншлага: Долоо хоногт нэг бүлэг- “Хувийн сүнслэг сэргэлтийн алхам”, “Есүсийн дотор орших нь” мөн “40 өдрийн ном”-с долоо хоног бүр нэг бүлэг (тухайн бүлгийг нэгээс олон уншвал илүү дээр байх болно) унших нь хялбар бөгөөд тустай арга юм. Бүлгээрээ эсвэл сүмийнхэн эхлэх өдрөө тогтооно. Энэ нь мөн 4 хэсэг семинарын бэлтгэлд (6-г хар) эсвэл Шаббатын идэвхжүүлэлтийн дараа байж болно. Хүмүүс өөрсдөө бүлгээрээ, хосоороо эсвэл ганцаараа унших эсэхээ шийднэ. Уншиж ойлгосон зүйлийнхээ чухал хэсгийг Шаббатаар 5 минут уншиж мөн бусад хүмүүсийг гэрчлэлээ хуваалцахыг урьвал сайн. Хэрэв хэн нэгэнд гэрчлэл байхгүй бол өөр хүний гэрчлэлийг уншиж өгч болно. (цагаас нь өмнө гэрчлэлүүдийг уншиж бэлдэх). Тэгээд ирэх долоо хоногт ямар бүлэг уншигдахыг зарлаарай. Мөн та 40 өдрийн номыг www.spiritbaptism.org сайтаас захиалж болно.

8. Ариун Сүнсний талаар номлол хийсээр байх. Мөн өөр хэн нэгэнд үүнийг хийхийг уриалах. Энэхүү сайтад “Ground Zero and the New Reformation ” сэдвийн дор “Ариун Сүнсээр хэрхэн баптисм хүртэх вэ?” хэмээх Двайт Нелсоны гайхалтай номлолууд бий. Номлолууд 9 сарын 2-с эхэлсэн байгаа. Мөн түүний 8 сарын 30 болон 9 сарын 13 ны блогууд www.pmchurch.tv/sermons сайтад бий.

9. Ариун Сүнсгүй амьдрах талаар Библи судлалаа хийсээр байх. Мөн чангаар уншиж байх хэрэгтэй.

10. Жижиг бүлгүүд болон залбирлын бүлгүүд хэрэгтэй хэсгээ олж уншин ярилцаж, хамтдаа залбирч болно. 40 өдрийн мөргөлийг хийсэн залбирлын хамтрагчдыг урамшуулж байх. Мөн бүгдээрээ долоо хоногт нэг удаа уулзан хамтдаа залбирч, гэрчлэлээ хуваалцаж мөн ярилцаарай. (12-г хар).

11. Шаббатын үйлчлэл - Ариун Сүнсгүй амьдрал биднийг миссионерүүд болгодог. Хувь хүн бүр мөн жижиг бүлгүүд залбиралтайгаар бэлтгэл болон гүйцэтгэлийг өөрсдийн хариуцлага гэж авч үзэх хэрэгтэй. Хэрэв энэ нь дээр дурдсан зарим боломжуудтай хосолбол Шаббатын аз жаргалтай үр дүнтэй цагийг бий болгоно. Энэ нь миссионерийн сүнсийг сэрээдэг.

12. 40 өдрийн номны агуулгыг унших мөн ярилцах - “40 өдрийн номны” нэг, хоёр мөн гуравдугаар цувралын “Танилцуулга болон тойм” хэсгийг уншиж ярилцаарай. Үүнийг уншсанаах дараа сүм, чуулганаах шийдэх асуудлаар хэлэлцэж болно. Мөн энэхүү

номын ойлголтуудыг пасторууд, ахмадууд, залуучууд, миссион, дүүргүүд болон миссионы сургуулиудын уулзалт цуглаан дээр ярилцаж болно. Энэ ойлголт нь дараах зүйлсэд тустай:

- ▶ Ариун Сүнсээр дамжуулан Есүстэй илүү дотно харилцаатай болоход тустай.
- ▶ Залбирлын амьдралыг хүчирхэгжүүлнэ. (ганцаараа, хосоороо мөн бүлгээр).
- ▶ Бурхантай харилцах бидний хувийн харилцааг гүнзгийрүүлдэг.
- ▶ 40 өдрийн мөргөлөөр дамжуулан сүнслэг амьдралыг хүчирхэгжүүлнэ.
- ▶ Сүмээсээ явсан болон шинэ хүмүүстэй харилцах мөн халамжлахад тустай.
- ▶ Баярын мэдээнд туслах, бүлгүүдийг халамжлах мөн Библи судлахад тусална.
- ▶ Энэ нь гурван сүнслэг алхамд хүргэсэн байна:
- ▶ Хоёр хоёроороо 40 өдрийн мөргөлөөр дамжуулан хувийн сүнслэг сэргэлт шинэчлэлтэд хүргэнэ. (Номонд “асуултуудыг ярилцах” болон “Өдөр бүрийн залбирал”-ын талаар бий.)
- ▶ Сүнсээр дүүрсэн дуудлага, хүн бүр таван шинэ хүнтэй эсвэл идэвхгүй сүмийн гишүүдтэй холбоо барих.
- ▶ Баярт мэдээний үйл ажиллагаа (Сургалт/семинар, халамжлагч бүлгүүд, Библи судлал, жижиг эсвэл дунд хэмжээний үзэсгэлэн гэх мэт. Эрүүл мэнд, бүтээл эсвэл эш үзүүлэлэг гэх мэт).

Тэдгээр 40 өдрийн ухагдахууныг зохион байгуулж буй хүмүүс зааварчилгаа гарын авлагыг “40 Day-Instructions.pdf.” татаж авах боломжтой. Энэ нь 40 өдрийн үр жимс ургуулах зайлшгүй алхмуудыг багтаасан байгаа. Энэхүү санал болгож буй сүнслэг зам нь баярт мэдээнд хамгийн сайн бэлтгэл болно. Энэ л аргаар удирдагчид болон сүмийн гишүүд сүнслэгээр бэлтгэгдэнэ. Хүн бүр таван шинэ хүнтэй холбогдох арга замаар баярт мэдээний семинарын хөрс бэлтгэгддэг. Олон янзын баярт мэдээний төрлүүдийг ашиглаж болно. Деннис Смитийн 40 өдрийн номыг захиалахад доорх хаягаар холбогдоорой: www.spiritbaptism.org

13. Сүмийн гишүүддээ 40 өдрийн залбирлын хөтөлбөрийн талаарх мэдээлэл бүхий хуудас өгөх. Сүмдээ 40 өдрийн цуврал эхлэхэд зориулж урилга хийх хэрэгтэй.

14. Тохиромжтой үгс зарлалыг сүм, чуулган, бүсийн мэдээллийн самбар, сүмийн вебсайтууд, сонин хэвлэл мөн хэлтсүүдийн мэдээллийн хэсэгт тавьж, зарлах хэрэгтэй.

15. Судалгаа: Ариун Сүнсний талаар танилцуулсаны дараа нэрийг нь бичүүлэхгүйгээр товчхон судалгаа авахаар жижиг цаас тарааж болно: – Хэрэв тухайн хүн өдөр бүр эсвэл ихэвчлэн Ариун Сүнсийг залбиран гуйдаг бол нэг тэмдэг тавиг, мөн өдөр бүр амлалт барин залбирдаг бол хоёр тэмдэг тавиг. Энэ нь одоогийн тэдний сүнслэг байдал ямар буйг тодорхойлох сайн арга юм.

Дээр дурдсан бүх боломжуудын талаар **залбирах болон залбиралтайгаар бэлдэх** нь маш чухал юм. Үүний үр дүн болон гүйцэтгэлийн төлөө сүмийн гишүүдээс залбирахыг гуйх, залбирлын тойрог хийх мөн сүм даяараа ямар нэгэн тодорхой хүсэлт залбирах нь үнэлж баршгүй тус хүргэнэ.

СЭРГЭЛТ ШИНЭЧЛЭЛТИЙН МАТЕРИАЛЫГ ХЭРХЭН ТАРААХ ВЭ?

Зорилго:

Нэгэн залуугийн хэлснээр: “Энэ мэдээ нь дэлхий даяар буй Адвентист айл бүрт хүрэх ёстой. Би өөрийнхөө хэсгийг хийх болно” гэжээ. Тэрээр идэвхтэйгээр үйлчилж байна. Нэгэн эмэгтэйн хэлснээр: “Энэ ном нь бүх хэлүүд дээр орчуулагдах ёстой” гэжээ. Тэрээр өөрийнхөө амьдардаг бүх дүүргээр энэ сэдвээр номлож байна. Мөн тэрээр Бурханы удирдамжаар Христэд итгэх итгэлийг хүлээн аваагүй хөрш улс руугаа мянга мянган товхимлыг хүргүүлсэн.

Хөгжил болон Санхүү:

Бурханы хүслийн дагуу “Сүнслэг сэргэлтийн алхам” ном нь Адвентист айл бүрт эх хэл дээр нь хямд төсөр үнээр эсвэл үнэгүй хүргэгдэх ёстой. Зарим пастор, чуулган, бүсийн тусламжтайгаар зарим улсын айл өрхүүдэд үнэгүй хуулбарууд аль хэдийн хүргэгдсэн болно.

Энэхүү үндсийг тавигчид бол Австри, Герман, Швейцарын чуулганууд юм. Энэ төсөл нь Бурханы тодорхой оролцоотойгоор боловсруулагдсан болно. Бурханы нигүүлсэл, нөлөөллөөр 2017 он хүртэл 600,000-с илүү хувилбарууд тараагдсан байна. Бид та бүхнээс Эзэн энэ төслийг үргэлжлүүлэн удирдаж, цаашдын шаардлагатай зүйлсээр хангахын төлөө залбираасай хэмээн хүсч байна. Бид ихэвчлэн хэвлэлийн тал үнийг төлөх санхүүжилтийг чуулганууд болон нэгдлээс хүсдэг. Харин энэ удаад Бурханы тусламжтайгаар чуулгануудын хувьд бүх санхүүжилтийг нь бид гаргах болно. Эцэст нь хэрэглэгч материалыг үнэгүй эсвэл маш бага үнээр худалдаж авсан байх ёстой.

Хувь хүнд тавих шаардлага:

Бид таныг бусдад хүрээсэй хэмээн хүсч байна. Үүнийг бусдад хуваалцахад тавих шаардлага бол өдөр бүр Ариун Сүнснийг хүлээн авч, зүрх сэтгэлдээ Христийг амьдруулж энэ номоос ивээлийг авсан байх хэрэгтэй. Үе үеийн хүслэн номны [egwwritings.org] 676.2 хуудсыг уншаарай. Мөн Иохан 15:4 “Миний дотор бай, Би чиний дотор байна” хэмээх Есүсийн нандин үг бий. Энэ нь хоёр утгатай:

- ▶ Түүний Сүнсийг тогтмол хүлээн авах
- ▶ Түүний үйлчлэлд бууж өгсөн чин сэтгэлийн амьдрал

Есүс яагаад энэ санааг өгсөн вэ? “Миний баяр баясгалан [Есүсийн баяр баясгалан бол Сүнсний үр жимс Галат 5:22] та нарт байж, та нарын баяр баясгалан дүүрэн болохын тулд үүнийг Би та нарт хэлэв” (Иохан 15:11).

Дэмжих боломжууд:

Залбирал

Тодорхой хүмүүст сайн мэдээг түгээхийн тулд тэднийг зуучлан залбирлаар дамжуулан бэлдсэн байх нь их чухал юм. Элен Уайт, Баярт мэдээ х. 341.3: “Маш их залбирлаар та зүрх сэтгэлд ажиллах ёстой ба энэ бол зүрх сэтгэлд хүрч болох цорын ганц арга зам юм.”

Товхимол тараах:

Та ном хүлээн авагчид өөрийн гэрчлэл, ойлгосон зүйлсээ хэлж өгөх хэрэгтэй. Эдгээр нь таны найзууд, удирдагчид, сүмийн онцгой албан тушаалтнууд, чуулган нэгдлүүд, хэвлэлийн газрууд мөн миссионы төслүүд мөн бусад байгууллагууд байж болно. Өөр нэгэн сайхан боломж бол хурал цуглааны үеэр ном зарах мухлаг нээх эсвэл зохион байгуулагчийн зөвшөөрлөөр олон нийтэд тараах байж болно. Адвентист айл өрх бүр энэхүү номыг үнэгүй эсвэл хямд үнээр хүлээн авах ёстойг санаарай. Товхимлыг имэйлээр илгээж болно. Мөн аливаа уулзалт цугларалтаар дамжуулан хүмүүст өгч болно.

Интернетээр түгээх

Мэдээ түгээх хамгийн орчин үеийн арга бол имэйл билээ. Энэ мэдээг Австрали уруу илгээж, тэндээсээ Энэтхэгийн Мизорам уруу явуулжээ. Цаашлаад Пакистанаас Бразилд хүрсэн байна. Та энэ мэдээг www.schritte-zur-persoenlichererweckung.info вэб хуудаснаас уншиж болно. Та хэвлэж авах болон/эсвэл энгийн линкээр дамжуулан бүх орчуулагдсан хэлээр хэн нэгэнд эсвэл олон хүн рүү цааш илгээж болно. Түүнчлэн та Англи хэл дээр www.steps-to-personal-revival.info гэсэн вэб хуудас байдгийг

хүмүүст мэдүүлж болно. 2016 оны эцэс гэхэд Бурханы удирдамжин доор мөн олон орчуулагчдын дэмжлэгээр энэ мэдээ 20 орны хэл дээр уншигдах боломжтой болох ба түн удалгүй ахиад 8 хэл дээр орчуулагдана. Бурханы тусламжтайгаар илүү олон хүн энэ мэдээг дагах болно.

E-book – ээр түгээх

Энэ вэб хуудаснаас үнэгүй e-book-ийг ‘erub’ болон ‘mobi’ форматаар авч болно. Та бас ebook-ийг Amazon –оос 1 еврогоор захиалж болно.

Олон Нийтийн Сүлжээгээр түгээх

Энэ мэдээг нэг буюу хэд хэдэн номлолоор сүмдээ хуваалцах гайхалтай боломж бүх пасторууд болон сайн дурын номлогчдод бий. Та ч гэсэн өөрөө судлаад эсвэл энэ номны материалыг ашиглаад хийж болно. “Би тухайн сүмийн сонсож байсан эсвэл уншиж байсан сэдвээр хэзээ ч номлож байгаагүй. Би судалгаа хийсний үндсэн дээр өнөө үед ийм чухал сэдвийг 6-10 удаа унших буюу сонсох нэн шаардлагатай гэдгийг ойлгосон” (Хелмут Хаубейлын хувийн туршлага ба зөвлөгөө). Одоо би үүнийг мэддэг болсон учраас хүмүүс тухайн сэдвийн талаар өмнө нь уншсан эсвэл сонссон байсан ч гэсэн дахин номлоход асуудалгүй болсон. Хэрэв та хүсвэл энэ номны гол санаа болон ишлэлүүдийг ашиглаж байгаагаа хэлж болно.

Хэрэв та номлол хийгээгүй бол бусад хүмүүсийг номлолдоо энэ сэдвийг ашиглахыг хүсэмжилж болно.

“Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам” гэсэн ерөнхий сэдвээр Шаббат өдөр семинар хийх гэж байгаа бол дор хаяж гурван сэдвийг агуулах ёстой:

Номлол:

Бидэнд байдаг асуудлын үндэс нь юу вэ?

Бидний асуудалд сүнслэг учир шалтгаан байгаа юу?

Бидэнд Ариун Сүнс дутаж байна уу?

Би өөрийнхөө Сүнслэг амьдралыг хэрхэн дүгнэж байна вэ?

(Эдгээр нь удиртгал хэсэг болон 1, 2 бүлгийн гол санаанууд юм)

1. Үдээс хойших хөтөлбөр:

Бидний асуудлыг шийдэж болно – гэхдээ яаж?

- ▶ Бид хэрхэн аз жаргалтай, баяр хөөртэй, хүчирхэг Христэд итгэгчийн амьдралыг бий болгох вэ?
- ▶ Ариун Сүнс хэрхэн бидний амьдралыг дүүргэдэг вэ? Нууц үг нь “өдөр бүр”
(Эдгээр нь 3-р бүлгийн гол санаанууд)

2. Үдээс хойших эсвэл оройн хөтөлбөр

Бодитоор хэрэгжүүлэх гол санаанууд буюу хэрхэн бодитоор хэрэгжүүлэх вэ (Бодитоор Үзэх Арга)

- ▶ Бурханы шийдлийг амьдралдаа хэрхэн бодитоор хэрэгжүүлж үзэх вэ?
- ▶ Ариун Сүнсээр дүүрэхийн тулд би хэрхэн залбирах ёстой вэ?
- ▶ (Эдгээр нь 5-р бүлгийн гол санаанууд)

Хувийн гэрчлэлүүд

Дараах сэдвүүдтэй холбоотой хувийн гэрчлэлүүд маш үнэ цэнэтэй байдаг:

- ▶ Унших материалаас хувьдаа олж авсан сэтгэгдэл буюу ухаарлын талаар
- ▶ Энэ мэдээний амьдралд авчирсан үр нөлөөний талаар

Эх хэлээрээ орчуулах

Хэрэв энэ ном таны эх хэлээр орчуулагдаагүй байгаа бол та залбирч Бурханы ивээл дор энэ номыг орчуулах хүсэлтэй хүнийг олж болох юм. Энэ мэдээ сэтгэлд нь хүрсэн хүн орчуулбал маш том давуу тал болно. Ихэнхи орчуулгыг сайн дураараа хийсэн байгаа. Учир нь орчуулагч өөрөө энэ мэдээг түгээх их сонирхолтой байсан. Гэхдээ зарим хүмүүсийн хувьд орчуулга хийх нь амин зуулга байсан. Тэдгээр орчуулагч нарт “Ахан дүүгийн” ёсоор төлбөр төлсөн. Хэрэв та орчуулах талаар Хелмут Хаубейлтэй хувьчилан холбогдвол бид талархах болно. Тэрээр энэ номыг хуваалцах талаар сайн зөвлөгөө өгөх ба энэ номыг орчуулсан хэл тус бүр дээр адилхан хэвлэх тал дээр анхаарна.

ТӨГСГӨЛИЙН ҮГ

Түүний сүр жавхлант баялгийн дагуу бидэнд амьдралын бүхий л нөхцөл байдалд Ариун Сүнсээр дамжуулан гайхалтай удирдамж хийгээд хүч чадал оршдог.

Ийнхүү бидний зан чанар өөрчлөгдсөнөөр Бурханы ажил үйлсэд хэрэгтэй багаж зэвсэг болж чадна. Бид өдөр тутам өөрсдийгөө өргөж, Ариун Сүнсээр баптисм хүртсэнээр амьдралд маань жинхэнэ өөрчлөлт ирнэ.

Эзэн биднийг дэлхийн түүхэн дэх хамгийн агуу цаг үед бэлтгэхийг хүсдэг. Тэрээр биднийг Түүний дахин ирэлтэнд хувьчилан бэлэн байхыг тийнхүү Ариун Сүнсний хүчээр бидэнтэй хамт сайн мэдээний ажлыг дуусгахыг хүсдэг. Тэр биднийг хэцүү цаг үед амжилттай удирдан авч явахыг хүсэж байгаа.

Бурхан таны өдөр бүрийн зориулалт болон Ариун Сүнсний баптисмаар дамжуулан сүнслэг сэргэлт, шинэчлэлтийг авчрах болтугай.

Эцэст нь би Библийн ишлэл болон залбирлаар дуусгахыг хүсч байна.

“Миний нэрээр дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган, залбирч, Миний нүүрийг эрэлхийлж, бузар муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ” (Шастирын дэд 7:14).

Залбирал: Тэнгэрт оршигч Эцэг минь бидэнд даруу зан хайрлаач (Мика 6:8). Бидний зүрх сэтгэлийг Таны Мэлмийг хайж, залбиран гуйх агуу хүсэлтэй болгож өгөөч. Биднийг дуулгавартай байж, бузар муу замаасаа эргэхэд туслаач. Бидний дотор шаардлагуудыг гүйцэлдүүлж, Таны амлалтын үр дүн болох хариуг тань сонсоход туслаач. Гэм нүглийг маань уучилж, бүлээн байдал итгэлгүй байдлаас минь эдгээж өгөөч. Өдөр бүр өөрсдийгөө Есүст өргөж, итгэлээр Ариун Сүнсийг хүлээн авахад маань туслаач. Амен.

“Сэргэлт нь зөвхөн залбирлын хариуд биелэх боломжтой.”¹³² “Пентекост өдөр болсон шиг Ариун Сүнсний баптисм нь жинхэнэ сүсэг бишрэлийн сэргэлт болон олон гайхамшигтай үйлс рүү хөтлөх болно.”¹³³

132 Э. Уайт, *Сонгомол Мэдээнүүд*, 1 боть, (1958), х. 121

133 Э. Уайт, *Сонгомол Мэдээнүүд*, 2 боть, (1958), х. 57

Цаашид суралцах зөвлөмж

Чухал сануулга: Хэрэв боломжтой бол энэ номыг зургаан өдрийн турш өдөр бүр уншаарай. Судалгаагаар амьдралд хэрэгтэй чухал сэдвийг сайн ойлгохын тулд зургаагаас арван удаа унших эсвэл сонсох хэрэгтэй гэж тогтоожээ. Үүнийг туршаад үзээрэй. Үр дүн нь танд батлан харуулах болно.

Нэгэн багш үүнийг туршиж үзсэн байна: “Үүнийг ядаж нэг удаа туршаад үзээрэй. Үр дүн нь танд батлан харуулах болно гэсэн эдгээр урамшууллын үгс миний сэтгэлийг ихэд татсан юм.” Би үүнийг туршиж үзэхээр шийдсэн бөгөөд гурав дахь удаагийн уншилт надад маш гүн сэтгэгдэл төрүүлж, бүх л амьдралынхаа туршид эрэлхийлж байсан тэрхүү Аврагчийнхаа агуу хайр ивээлийг мэдэрсэн юм. Хоёр сарын дотор энэ номыг зургаан удаа уншсан бөгөөд үр дүн нь үнэхээр гайхалтай байсан. Энэ нь яг л Есүс бидний дэргэд ойртож, бид Түүний ариухан, зөөлөн дулаан, хайрын харцыг харж байгаа мэт санагдсан. Би түүнээс хойш энэхүү баяр хөөргүйгээр амьдрахыг хүсээгүй юм”.С.П

Би уншигчдын Ариун Сүнстэй хамт шинэ амьдралынх нь талаарх маш олон талархсан, урамшуулсан гэрчлэлүүдийг хүлээн авсан. Гэрчлэлүүдийн ихэнх нь номыг олон дахин уншсан хүмүүсээс ирсэн байсан.

Уг сэдвийн дагуу хэвлэгдсэн ном товхимол

- ▶ 40 өдрийн [ном 1] Дахин ирэлтэд бэлтгэх мөргөл болон залбирлууд
Деннис Смит, Review and Herald, 2009
- ▶ 40 өдрийн [ном 2] Бурхантай харилцаагаа сэргээх мөргөл болон залбирлууд, Деннис Смит, Review and Herald, 2011
- ▶ 40 өдрийн [ном 3] Сүүлчийн өдрүүдэд өгсөн Бурханы эрүүл мэндийн зарчмууд, Деннис Смит, Review and Herald, 2011
- ▶ 40 өдрийн [ном 4] Дэлхий дээрх сүүлчийн өдрүүдийн үйл явдлуудын мөргөл болон залбирлууд, Деннис Смит, Review and Herald, 2013
- ▶ Хэрэв миний хүмүүс залбирдаг бол- арван нэг дэх цагийн сэргэлт шинэчлэлт, залбирлын дуудлага,
Ренди Максвелл, Фасифик хэвлэл 1995
- ▶ Биднийг дахин шинэчлээч, Марк Финлэй, Фасифик хэвлэл 2010
- ▶ Хэрхэн Ариун Сүнсээр дүүрэх мөн үүнийгээ хэрхэн мэдэх вэ?
Гарри Ф.Виллиамс, Review and Herald, 1991
- ▶ Үндсэн залбирал,
Дерек Ж. Моррис, Review and Herald, 2008

40 ӨДРИЙН МАТЕРИАЛЫН ГАРЫН АВЛАГА

Та Деннис Смитийн 40 өдрийн номыг www.SpiritBaptism.org хэмээх Веб сайтаас 40 өдрийн гарын авлагын заавар гэсэн хэсэг рүү орж баярт мэдээтэй залбирлын 40 өдрийг зохион байгуулахад тустай матириалуудыг олж болно.

Ариун Сүнстэй амьдрах шинэ мэдрэмжүүд

Бидний Эзэн Есүс “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, ... энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв.” Үйлс 1:8 гэж хэлсэн.

Тусгай хүсэлт: Хэрэв та амьдралдаа Ариун Сүнсийг мэдэрсэн гэрчилсэнээ товчхон бичиж, Хэлмут Хаубэйл руу илгээвээс бид ихэд талархах бөгөөд тэрээр түүнийг тань МиссионБрифт (Герман дахь үйлчлэлийн сэтгүүл) хэвлэн гаргах болно. Та гэрчлэлдээ өөрийнхөө нэрний эхний үсгийг эсвэл бүтэн нэр болон хамрагддаг сүмээ бүтнээр нь бичүүлэх эсэхээ хэлээрэй. Таны гэрчлэл бусдын Ариун Сүнстэй хамт алхах аяллыг урамшуулах эсвэл Ариун Сүнстэй алхаж эхлэхэд нь хүч өгөх болно гэдгийг санаарай.

Холбоо барих:

Хэлмут Хаубэлл

Rosenheimerstr.49

D-83043 Bad Aibling / Oberbayern, Germany

Имэйл: helmut@haubeil.net

Хэл: Герман эсвэл Англи

[illegible]

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

Эрхэм хамтрагчдаа,

Одоогоор Калифоринд хоёр сүм ахлан ажиллаж байна. Би анх пастор Двайт Нельсоны долоо хоног бүрийн радиогийн хөтөлбөр сонсоод таны материалтай танилцаж байсан юм. Анхнаасаа л миний сэтгэлийг маш их хөдөлгөсөн. Өмнө нь Ариун Сүнсний талаар өөр материалууд сонсож байсан ч хэзээ ч ингэж анхаарал хандуулж байгаагүй юм. Бурхан ямар нэгэн шалтгаанаар олон хүнд Ариун Сүнсээр дамжуулан хүрэхийн тулд яг энэ цагийг сонгосон гэдэгт би баттай итгэж байна. Таны хүчин чармайлтаар үүнийг олсондоо би үнэхээр их баяртай байна.

Нэг зүйлийг батлан хэлж чадна. Номын эхний бүлэгт дахин бодож мөн зогсоодог үнэхээр хүчирхэг үнэн рүү хөтөлдөг энгийн аргыг олж илрүүлсэн. Олон дахин унших үйл явц бол үнэхээр үр дүнтэй шүү. Энэхүү номын талаар миний ярьж, зөвлөлдөж мөн номлосон хүн бүрт Ариун Сүнсний талаарх сэдэв илүү сонирхолтой болдог. Энэ нь яг л анх удаа сонсож байгаа мэт сэтгэгдэл үлдээдэг. Надад ч бас ийм санагдаж байсан. Би эхний бүлгийн утга санаанаас гурван номлол бэлдэтлээ салж чадахгүй байлаа. Үүнийг хэрхэн тодорхой тайлбарлаж болохыг мэдэхгүй байна. Гэхдээ би номоо түр хойш тавьж чадахгүй байсан ба үүний үр дүн сүмүүдэд маань мэдрэгдэж байсан. Би энэхүү мэдээний дуу хоолой болсон ба дүүрэгт маань тодорхой өсөлт харагдаж байна. Манай сүмийн гишүүд Бурхан руу чиглэж, Ариун Сүнсээр хүчирхэгжиж байсан. Ирэх жил илүү олон хүн ирнэ гэж найдаж байна.

Д.Р 2018, Нэгдүгээр сар

Андрюс Их Сургуулийн Мемориал сүмийн ахлах пастор **Пастор Двайт Нелсонд**, нэгэн хүн энэхүү бяцхан ном [Хувийн сүнслэг сэргэлтийн алхам] “Миний доторхыг өөрчилсөн. Би бусдад мөн адил үйлдмээр байна” хэмээн хэлсэн байна.

Тэрээр гурван цуврал номлол номложээ:

“Тэг хязгаар болон шинэ өөрчлөлт: Хэрхэн Ариун Сүнсээр баптисм хүртэх вэ?”

Тэрээр номлолдоо “Хувийн сүнслэг сэргэлтийн алхамаас” дурдаж, хүмүүст санал болгосон юм. Энэ нь 4000 хүн номыг татан авч, хэдэн мянган хүн номыг захиалахад хүргэсэн. Эдгээр номлолуудын линк болон түүний блог: <http://www.pmchurch.tv/sermons> (Sept. 2nd, Sept. 9th, Sept. 23rd)

ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН

Алхан

Хэлмут Хаубэйл пастор, бизнесмен хүн юм. Тээврийн компанид төлөөлөгчөөр амжилттай ажилласны дараагаар 37 насандаа Бурханы дуудлагад хариулж, үйлчлэлийн ажлаа 16 жил хийсэн байна. Дараа нь Германы Бэд Айблингийн Адвентист асрах газрын захирлаар ажиллажээ. Мөн тэрээр "Missionsbrief"-н үүсгэн байгуулагч бөгөөд (Герман хэлээр хэвлэгддэг үйлчлэлийн сонин) одоогоор тэтгэвэртээ гарсан хэдий ч Энэтхэг болон төв Азид баярт мэдээний ажил явуулахад маш чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

"Хүч чадал өгдөг Сүнсний бэлгээр бид яагаад өлсөж цангахгүй байна вэ? Бид яагаад үүний талаар ярихгүй, залбирахгүй мөн номлохгүй байна вэ?"

ЭЛЕН УАЙТ, Сүмүүдэд өгөх гэрчлэл, боть. 8, х. 22